

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 8


— Иргэний хэрэг шүүхэд шийдвэрлэх тухай Монгол Улсын хууль
— Нийгмийн даатгалын тухай Монгол Улсын хууль
— Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай Монгол Улсын хууль
— Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай Монгол Улсын хууль
— Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай Монгол Улсын хууль
— Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх тухай Монгол Улсын хууль
— Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай Монгол Улсын хууль



Монгол Улсын Их Хурлын Тамгын газар

1994 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

## (ХУУЛЬ, ТОГТООЛ ,ЗАРЛИГ, ШИЙДВЭР, НИЙТЛЭЛ–ХУУЛИЙН ТАЙЛБАР)

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар

№ 1994 оны 8 сар № 8 (27)

ГАРЧИГ

I. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 589
2. Хууль, зарлиг, зарлигийн заалт хүчингүй болсонд тооцох тухай 668
3. Нийгмийн даатгалын тухай 669
4. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай 684
5. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай 697
6. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай 704
7. Хуульд өөрчлөлт, оруулах, хууль, хуулийн заалт хүчингүй болсонд тооцох тухай 707
8. Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэглэх журмын тухай 708
9. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай 710
10. Хуулийн заалт хүчингүй болсонд тооцох тухай 719

II. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

11. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай №44 720
12. Мөнгөн тэмдэгтийн загвар, тодорхойлолт батлах тухай № 48 721
13. Ажилд томилох, цалин тогтоох тухай № 49 722

14. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай № 50 723

III. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

15. Төрийн тугийг хүндэтгэн залах журам батлах тухай № 67 724
16. Төрийн тамгыг хадгалах журам батлах тухай № 68 728

IV. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

17. Хүнсний жилийн ажлын дүнгийн тухай № 71 729
18. Нийгмийн халамж, хүнсний хангамжийн үйлчилгээг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай № 72 731
19. Хэлэлцээр батлах тухай № 73 734
20. Г. Занабазарын ойг тэмдэглэх тухай № 74 735

V. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ

21. Монгол Улсын ерөнхийлөгчийн тухай хуулийн 7-р зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай № 49 737
22. Төрийн эрүүгийн ял шийтгэлийн бодлогыг шүүхээс хэрэгжүүлэхэд анхаарах зарим асуудлын тухай № 51 738

VI. НИЙТЛЭЛ, ТАЙЛБАР ЗӨВЛӨМЖ

23. Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн агуулга, онцлог 743
24. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн тухай 748

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ

1994 оны 5 дугаар сарын 9-ний өдөр

Улаанбаатар хот

# ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### Нийтлэг үндэслэл

**1 дүгээр зүйл.** Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь өөрийн буюу бусдын эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалж иргэн, хуулийн этгээдээс нэхэмжлэл, хүсэлт, гомдол гарган мэдүүлсэн эрх зүйн маргааныг шүүх иргэний хэрэг үүсгэн хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомж

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

**3 дугаар зүйл.** Шүүхэд мэдүүлэх эрх

1. Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө, ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа сонирхогч этгээд уул эрхээ хамгаалуулахаар энэ хуульд заасан журмын дагуу шүүхэд мэдүүлэх эрхтэй.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрхийн талаар шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх өөр журмыг хуулиар тогтоож болно.

**4 дүгээр зүйл.** Шүүхэд иргэний хэрэг үүсгэх

Шүүх дараахь үндэслэлээр иргэний хэрэг (цаашид «хэрэг» гэх) үүсгэж болно.

1) эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус амины эрх нь зөөрчигдсөн гэж үзээд иргэн, хуулийн этгээдээс гаргасан нэхэмжлэл;

3) онцгой ажиллагааны журмаар шийдвэрлүүлэхээр хууль заасан асуудлаар сонирхогч этгээдээс гаргасан хүсэлт;

4) төрийн захиргаа, шүүх, прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, төдгээрийн албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааны талаар иргэн, хуулийн этгээдээс хуульд заасан журмын дагуу гаргасан гомдол;

5) хуульд заасан бусад үндэслэл.

**5 дугаар зүйл.** Шүүхийн өмнө эрх тэгш байх

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол болон бусад байдал, хуулийн этгээдийг өмчийн хэлбэр, эрх хэмжээгээр нь ялгаварлахгүй эрх тэгш байх зарчимд үндэслэн явагдана.

**6 дугаар зүйл.** Хэрэг хянан шийдвэрлэх эрх мэдлийг шүүх хэрэгжүүлэх, шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдах

1. Хэрэг хянан шийдвэрлэх эрх мэдлийг хуулийн дагуу байгуулагдсан шүүх хэрэгжүүлнэ.

2. Шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдана.

**7 дугаар зүйл.** Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах хэл бичиг

1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг монгол хэлээр явуулж төрийн албан хэрэг хөтлөх бичгээр бичиж баримтжуулна.

2. Хэргийн оролцогч нь төрийн албан ёсны хэл, бичгийг мэдэхгүй бол өөрийн эх хэл буюу мэддэг хэл, бичгээр, хэрэв хараагүй, хэлгүй, дүлий зэрэг шалтгааны улмаас төрийн албан ёсны хэл, бичгээр харилцаж чадахгүй бол дохио зангаа, тусгай тэмдэгт ашиглан шүүхэд тайлбар өгөх, үг хэлэх, бичиг баримт гаргаж өгөх эрхтэй.

3. Шүүх нь хэрэгт цугларсан баримт болон энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүмүүсээс гаргасан тайлбар, бичиг баримт, хэлсэн үгийг хэргийн оролцогчдод, түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа бүрийг эдгээр хүмүүст орчуулагч (хэлмэрч)-аар дамжуулан танилцуулах үүрэгтэй.

**8 дугаар зүйл.** Шүүх хуралдааныг нээлттэй явуулах

1. Бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг нээлттэй явуулна.

2. Хэргийн оролцогч биш бол 16 насанд хүрээгүй хүнийг шүүх хуралдаан явагдаж байгаа танхимд байлгаж болохгүй.

3. Хэргийн нотлох баримт нь төр, байгууллага, хувь хүний нууцтай холбогдолтой бол шүүх хуралдааныг бүрэн буюу түүний зарим ажиллагааг хаалттай явуулж болно.

4. Хаалттай хуралдааны явцад илэрхий болсон, түүнчлэн албан үүрэгтэй нь холбогдуулж шүүгчид итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг шүүгч, хуралдаанд оролцогчид задруулж болохгүй.

**9 дүгээр зүйл.** Шүүх хуралдааныг тасралтгүй явуулах

1. Бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг өдрийн цагаар, амрах зайлшгүй шаардлагатайгаас бусад цагт тасралтгүй явуулна.

2. Шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч шүүх хуралдаанаар нэгэнт хэлэлцэж эхэлсэн хэргийг шийдвэрлэж дуусах буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хойшлуулах, түдгэлзүүлэх хүртэл өөр хэргийг хянан шийдвэрлэх эрхгүй.

**10 дугаар зүйл.** Мэтгэлзэх зарчим

1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг мэтгэлзэх үндсэн дээр хэрэгжүүлнэ.

2. Нэхэмжлэгч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч нь нэхэмжлэлийн шаардлага маргааны үйл баримт, хариуцагчийн гэм бурууг нотолж, түүний татгалзлыг үгүйсгэх; хариуцагч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч нь нэхэмжлэгчийн шаардлагыг татгалзах, түүнийхээ үндэслэлийг нотлох үүднээс тэдгээр нь шүүх хуралдаанд биечлэн оролцох, хүсэлт, тайлбар гаргах, үг хэлэх, нотлох баримт гаргаж өгөх, түүнийг шинжлэн судлахад тэгш эрхтэйгээр оролцох замаар мэтгэлзэнэ.

**11 дүгээр зүйл.** Хууль хэрэглэх

1. Шүүх хэрэг хянан шийдвэрлэхдээ гагцхүү Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан, албан ёсоор нийтлэгдсэн, хүчин төгөлдөр бусад хуулийг хэрэглэнэ.

2. Тодорхой хэргийг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль нь Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж шүүх үзвэл тухайн

хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, Улсын дээд шүүхэд энэ талаар санал оруулна.

3. Тухайн маргаантай харилцааг зохицуулсан хууль байхгүй бол шүүх төсөөтэй харилцааг зохицуулж байгаа хуулийг хэрэглэнэ. Хэрэв тийм хууль байхгүй бол шүүх Үндсэн хуулийн утга агуулга, ерөнхий үндэслэлд нийцүүлэн шийдвэрлэнэ.

4. Шүүх тухайн маргаантай харилцааг зохицуулсан хууль байхгүй гэсэн үндэслэлээр хэргийг шийдвэрлэхээс татгалзаж болохгүй.

**12 дугаар зүйл.** Шүүхийн шийдвэр заавал биелэгдэх

1. Шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа хүн, аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн албан тушаалтан заавал биелүүлнэ.

2. Шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадан биелүүлнэ.

**13 дугаар зүйл.** Хэргийн харьяалал

1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан үндэслэлээр гаргасан нэхэмжлэл, хүсэлт, гомдол (цаашид «нэхэмжлэл» гэх)-ыг шүүх харьяалан хянан шийдвэрлэнэ.

2. Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан бүрэн зохигчид хэлэлцэн тохиролцсон бол гадаадын иргэн, хуулийн этгээд оролцсон болон тэдгээрийн хооронд үүссэн маргааныг арбитр хянан шийдвэрлэнэ.

**14 дүгээр зүйл.** Нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа (оршин байгаа) нутаг дэвсгэрийн харьяаллаар гаргах

1. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа газрын шүүхэд гаргана.

2. Хариуцагч нь хуулийн этгээд байвал нэхэмжлэлийг түүний ажил хэргийг байнга явуулж байгаа байгууллагын оршин байгаа газрын шүүхэд гаргана.

3. Хариуцагчийн оршин суугаа газар нь мэдэгдэхгүй байвал нэхэмжлэлийг түүний эд хөрөнгө байгаа газрын шүүхэд буюу сүүлчийн оршин сууж байсан газрын шүүхэд гаргана.

4. Хариуцагчийг эрэн сурвалжлах, түүний оршин суугаа газрыг тогтоох ажиллагааг шүүгчийн захирамжийн дагуу цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ.

**15 дугаар зүйл.** Нэхэмжлэгчийн сонгон авсан нутаг дэвсгэрийн харьяалал

1. Бусдын амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсны хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг хариуцагч, нэхэмжлэгчийн алины нь ч оршин суугаа газрын шүүхэд гаргаж болно.

2. Хуулийн этгээдийн салбар нь хуулийн этгээдийн эрхтэй байгаа нөхцөлд түүний үйл ажиллагаатай холбоотой нэхэмжлэлийг оршин байгаа газрынх нь шүүхэд гаргаж болно.

3. Гэрээнд үүрэг гүйцэтгэх газрыг тусгайлан заасан бол түүнтэй холбогдсон нэхэмжлэлийг уг гэрээг биелүүлбэл зохих газрын шүүхэд гаргаж болно.

4. Өөр өөр газар оршин суугаа (оршин байгаа) хэд хэдэн хариуцагчид холбогдох нэхэмжлэлийг нэхэмжлэгч өөрийн үзэмжээр хариуцагчдын аль нэгний оршин суугаа (оршин байгаа) газрын шүүхэд гаргана.

**16 дугаар зүйл.** Шүүхийн онцгой харьяалал

1. Үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой буюу эд хөрөнгийн битүүмжлэлийг нээлгэх тухай нэхэмжлэлийг тухайн эд хөрөнгө байгаа газрын шүүхэд гаргана.

2. Өв залгамжлагч өвлөгдөх эд хөрөнгийг хүлээн авахаас өмнө өвлүүлэгчийн үүрэг гүйцэтгүүлэгчээс гаргах нэхэмжлэлийг уг эд хөрөнгө бүхэлдээ буюу түүний гол хэсэг нь байгаа газрын шүүхэд гаргана.

3. Эрх зүйн ач холбогдох бүхий үйл явдлыг тогтоолгох тухай нэхэмжлэлийг тухайн үйл явдал болсон газрын шүүхэд гаргана.

**17 дугаар зүйл.** Хоорондоо холбоотой хэд хэдэн хэргийн шүүхийн харьяалал

1. Нэг хариуцагчид холбогдох хэд хэдэн нэхэмжлэл өөр өөр шатны шүүхэд харьяалагдахаар байвал уг нэхэмжлэлийг дээд шатны шүүхэд нь гаргана.

2. Эрүүгийн хэрэг үйлдэгдсэнээс үүссэн нэхэмжлэлийг эрүүгийн хэрэгтэй хамт шийдвэрлээгүй бол иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хэлэлцүүлэхээр энэ хуульд заасан харьяаллаар гаргана.

**18 дугаар зүйл.** Харьяаллыг өөрчлөх

1. Хэргийн нутаг дэвсгэрийн харьяаллыг зохигчид хэлэлцэн өөрчилж болно.

2. Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан шүүхийн онцгой харьяаллыг зохигчид хэлэлцэн өөрчилж болохгүй.

**19 дүгээр зүйл.** Хэргийг шийдвэрлэх шүүхийн харьяалал

1. Сум буюу сум дундын, дүүргийн шүүх нь хуулиар Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүхэд харьяалуулснаас бусад бүх хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.

2. Аймаг, нийслэлийн шүүх дор дурдсан хэргийг дараахь журмаар хянан шийдрвэрлэнэ:

1) хуулиар харьяалуулсан хэрэг болон нэхэмжлэлийн үнийн дүн нь 10 сая төгрөгөөс дээш хэргийг анхан шатны журмаар;

2) сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шийдвэрлэсэн хэргийг давж заалдах болон хяналтын журмаар.

3. Улсын дээд шүүх дор дурдсан хэргийг дараахь журмаар хянан шийдвэрлэнэ:

1) хуулиар харьяалуулсан хэргийг анхан шатны журмаар;

2) Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүхийн анхан шатны журмаар шийдвэрлэсэн хэргийг давж заалдах журмаар;

3) Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүхийн давж заалдах болон хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн хэргийг хяналтын журмаар.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Хэргийн оролцогч

**20 дугаар зүйл.** Хэргийн оролцогчдын бүрэлдэхүүн

Зохигчид, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, түүнчлэн энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2-т заасны дагуу бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа этгээдийг хэргийн оролцогч гэнэ.

**21 дүгээр зүйл.** Иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн чадвар

Хэргийн оролцогчийн эрх эдэлж, үүрэгтэй байх чадвар (эрх зүйн чадвар)-ыг бүх иргэн, хуулийн этгээд тэгш эдэлнэ.

**22 дугаар зүйл.** Иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн чадамж

1. Шүүхэд эрхээ өөрөө хэрэгжүүлэх буюу төлөөлөгчөөр дамжуулан гүйцэтгүүлэх чадварыг эрх зүйн бүрэн чадамжтай иргэн хуулийн этгээд эдэлнэ.

2. 14-өөс 18 хүртэлх насны (насанд хүрээгүй) хүмүүс өөрийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлоо шүүхэд биечлэн хамгаалах эрхтэй.

3. Шүүх энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүмүүст хамаарагдах хэрэгт тэдний эцэг, эх, харгалзан дэмжигчийг татан оруулах үүрэгтэй. Харин тэдгээрийн хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн хөлсийг зарцуулах явдалтай холбогдсон хэргийг шийдвэрлэхдээ тэдний эцэг, эх, харгалзан дэмжигчийг оролцуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

4. 14 насанд хүрээгүй (бага насны) хүмүүс, түүнчлэн сэтгэцийн өвчний улмаас эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон хүмүүсийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг тэдгээрийн эцэг, эх буюу асран хамгаалагч шүүхэд хамгаална.

**23 дугаар зүйл.** Зохигч

1. Зохигч гэдэгт нэхэмжлэгч, хариуцагч, хуульд зааснаар тэдгээртэй эрх зүйн хувьд ажил байдалтайгаар хэрэгт оролцож байгаа этгээд хамаарна.

2. Нэхэмжлэгч нь нэхэмжлэл гаргасан үндэслэл буюу нэхэмжлэлийг өөрчлөх, нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг ихэсгэх буюу багасгах, эсхүл нэхэмжлэлээс бүрэн татгалзах эрхтэй.

3. Хариуцагч нь нэхэмжлэлийг зөвшөөрөн хүлээх буюу нэхэмжлэлийг зөвшөөрөн хүлээхээс татгалзах, сөрөг нэхэмжлэл гаргах эрхтэй.

4. Зохигчид эвлэрэн хэлэлцэнээр хэргийг дуусгавар болгож болно.

**24 дүгээр зүйл.** Хэргийн оролцогчдын эрх, үүрэг

1. Хэргийн оролцогчид нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дараахь эрх эдэлнэ:

1) эсрэг талын шаардлага, тайлбар, татгалзал, түүнийг дэмжих баримттай хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль бүрэд танилцах;

2) хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамж гарсны дараа хэргийн материалтай танилцах, түүнээс хуулбар эмдэглэл хийх;

3) шүүх хуралдаанд оролцох;

4) бусад оролцогчдод асуулт тавих;

5) гэрчийг байцаалгах, шинжээч томилуулах болон энэ зүйлийн 45 дугаар зүйлд заасан ажиллагаа гүйцэтгүүлэх; оролцох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн, хуурамч гэж үз-

вэл шалгуулах буюу нотлох баримтаас хасуулах; шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах;

6) шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, прокурор, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шинжээч, орчуулагч (хэлмэрч)-ийг татгалзах;

7) шүүхийн шийдвэрийг давж заалдах.

2. Хэргийн оролцогчид нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дараахь үүрэг хүлээнэ:

1) гаргасан шаардлага, тайлбар, татгалзлаа өөрөө нотлох, түүний нотлох баримтыг өөрөө цуглуулах;

2) шүүхийн дуудсанаар ирэх;

3) шүүхийн тавьсан шаардлагыг биелүүлэх;

4) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг сахих;

5) шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэрийг биелүүлэх.

**25 дугаар зүйл.** Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэд хэдэн зохигч оролцох

1. Нэхэмжлэлийг хэд хэдэн нэхэмжлэгч буюу хэд хэдэн хариуцагч тус тус хамтран гаргаж болно. Зохигч бүр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бие дааж оролцоно.

2. Хамтран нэхэмжлэгчид буюу хамтран хариуцагчид нь уг хэргийг хянан шийдвэрлэхэд бүгд байлцах шаардлагагүй гэж үзвэл аль нэгийгээ төлөөлүүлэн оролцуулж болно.

**26 дугаар зүйл.** Нэхэмжлэгч, хариуцагчийг солих

1. Нэхэмжлэгч нь уг нэхэмжлэлийг гаргах эрхгүй, эсхүл хариуцагч нь уг нэхэмжлэлийг жинхэнэ хариуцагч биш болох нь тогтоогдвол шүүх нэхэмжлэл гаргах эрхгүй этгээдийг жинхэнэ нэхэмжлэгчээр нь буюу хариуцах ёсгүй этгээдийг нэхэмжлэгчийн зөвшөөрснөөр жинхэнэ хариуцагчаар нь солино.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан байдал шүүх хуралдааны явцад тогтоогдвол нэхэмжлэгч, хариуцагчийг сольсны дараа шүүх хуралдааны ажиллагааг шинээр эхлэн явуулна.

3. Хариуцагчийг өөр этгээдээр солихыг нэхэмжлэгч зөвшөөрөөгүй бол шүүх уг этгээдийг хоёр дахь хариуцагчаар татан оролцуулна.

**27 дугаар зүйл.** Гуравдагч этгээд

1. Маргаж байгаа зүйлийн талаар бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд шүүхийн шийдвэр гарахаас өмнө

үг хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болно.

2. Бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд нь зохигчийн бүх эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

3. Шүүхээс гарах шийдвэр нь маргаж байгаа зүйлийн талаар бие даасан шаардлага гаргаагүй этгээдийн эрх, үүрэгт нөлөөлөхөөр байвал тэрээр шүүхийн шийдвэр гарахаас өмнө өөрийн санаачилгаар, эсхүл зохигчийн хүсэлт, гүүнчлэнэ шүүхийн санаачилгаар гуравдагч этгээдийн хувиар хэрэгт оролцох эрхтэй.

4. Бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээд нь нэхэмжлэлийн үндэслэл ба нэхэмжлэлийг өөрчлөх, нэхэмжлэлийн шаардлагыг ихэсгэх буюу багасгах, нэхэмжлэлээс татгалзах, нэхэмжлэлийг зөвшөөрөн хүлээх, эвлэрэн хэлэлцэхээс бусад зохигчийн бүх эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

**28 дугаар зүйл.** Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлан авах

1. Маргаантай байгаа эрх зүйн харилцааны зохигчдын аль нэг нь уг эрхийн харилцаанаас гарсан (хүн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан, шаардлага ба үүргээ бусдад шилжүүлсэн) бол шүүх тэрхүү зохигчийг түүний эрх залгамжлан авбал зохих этгээдээр сольж болно. Эрх залгамжлан аваж явдал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль чатанд гүйцэтгэгдэж болно.

2. Эрх залгамжлагч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас гарсан этгээдийн гүйцэтгэвэл зохих бүх үүргийг бүрэн хариуцна.

**29 дүгээр зүйл.** Бусдын эрхийг хамгаалж байгаа иргэн, хуулийн этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох

1. Иргэн, хуулийн этгээд бусдын эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалахын тулд хуульд заасан бол нэхэмжлэл гаргаж болно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар нэхэмжлэл гаргасан иргэн, хуулийн этгээд нь энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Харин тэдгээр нь гаргасан нэхэмжлэлээсээ татгалзсан явдал уг хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгох үндэслэл болохгүй.

**30 дугаар зүйл.** Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэнийг төлөөлөх

1. Иргэн нь өөрийн биеэр буюу төлөөлөгчөөрөө дамжуулан шүүхэд хэрэг хянан шийдвэрлэхэд оролцоно.

2. Төлөөлөл нь хуульд зааснаар, эсхүл сайн дурааар буюу гэрээгээр төлөөлөх хэлбэртэй байна:

1) иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй болон зарим буюу хэсэгчилсэн чадамжтай, түүнчлэн сураггүй алга болсонд тооцогдсон нас барсан гэж зарлагдсан хүнийг хуульд заасан төлөөлөгч нь төлөөлнө;

2) эрх зүйн бүрэн чадамж бүхий иргэн сайн дурааraa гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно.

**31 дүгээр зүйл.** Иргэнийг хуульд зааснаар төлөөлөх

1. Эрх зүйн бүрэн чадамжгүй болон зарим буюу хэсэгчилсэн чадамжтай хүний эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг түүний хууль ёсны төлөөлөгч-эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь шүүхэд хамгаалах бөгөөд тэд өөрийн бүрэн эрхийг нотлох баримт бичгийг шүүхэд үзүүлнэ.

2. Сураггүй алга болсонд тооцогдсон хүн оролцвол зохих байсан хэрэгт түүний эд хөрөнгийг хамгаалахаар томилогдсон этгээд түүнийг төлөөлөн оролцоно.

3. Нас барсан буюу нас барсан гэж зарлагдсан хүний өв залгамжлагч оролцвол зохих байсан хэрэгт хэрэв өв залгамжлагч нь уул өвийг хүлээж аваагүй байвал өвлөгдөх эд хөрөнгийг хамгаалахаар томилогдсон этгээд түүнийг төлөөлөн оролцоно.

4. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийн сонгон авсан төлөөлөгчийг оролцуулж болно.

**32 дугаар зүйл.** Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох, түүний эрх, үүрэг

1. Өмгөөлөгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дараахь эрх эдэлнэ:

1) шаардлагатай нотлох баримтыг цуглуулах;

2) шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах талаар хүсэлт гаргах;

3) төлөөлүүлэгчийн шаардлага, татгалзал, түүнийг нотлох баримт, үндэслэлийг гаргах;

4) эсрэг талын болон бусад оролцогчдын гаргасан нотлох баримт, шаардлага, татгалзал, тайлбартай танилцах, тэдгээрт тайлбар өгөх;

5) бусад зохигчид, оролцогчдод асуулт тавих;

6) нотлох баримт шинжлэхэд оролцох, нэмэлт нотлох баримт шинжлүүлэх, гэрч байцаалгах, шинжээч томилуулах, шүүх хуралдааныг хойшлуулах болон бусад асуудлаар хүсэлт гаргах;

7) шүүх хуралдааны болон хэрэг хянан шийдвэрлэх бусад ажиллагааны тэмдэглэлтэй танилцах;

8) шүүх бүрэлдэхүүн, оролцогчдыг татгалзан гаргах;

9) шүүхийн шийдвэрийг давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах.

2. Өмгөөлөгч нь гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдийг төлөөлөхдөө төлөөлүүлэгчийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хуульд заасан бүх арга хэмжээ авах ба шаардагдах эрх зүйн туслалцаа үзүүлэх, хэргийн бодит байдлыг тогтооход туслах үүрэгтэй.

**33 дугаар зүйл.** Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийг төлөөлөх

1. Хуулийн этгээд нь төлөөлөгчөөрөө дамжуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно.

2. Хуулийн этгээдийг төлөөлж байгаа этгээд өөрийн албан тушаалыг буюу эрх олгогдсоныг нотлох баримт бичгийг шүүхэд үзүүлнэ.

**34 дүгээр зүйл.** Төлөөлөгчийн бүрэн эрх

1. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулна.

2. Төлөөлөгчийн бүрэн эрхийг хуульд заасны дагуу бүрдүүлсэн итгэмжлэлээр тодорхойлно. Итгэмжлэлд зохигчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эдлэх эрхийн заримыг төлөөлөгчид эдлүүлэхгүй байхаар зааж болно.

3. Өмгөөлөгчийн бүрэн эрх нь эрх бүхий байгууллагаас олгосон баримт бичгээр батлагдана.

**35 дугаар зүйл.** Төлөөлөн оролцож болохгүй байдал

1. Дараахь иргэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөн оролцож болохгүй:

1) 18 насанд хүрээгүй;

2) эрх зүйн бүрэн чадамжгүй;

3) шүүгч, прокурор, мөрдөн байцаагч.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан иргэн нь эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувиар болон өөрийн ажиллаж байгаа байгууллагын төлөөлөгчөөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Нотлох баримт

**36 дугаар зүйл.** Нотлох баримт

1. Зохигчоос өөрийн шаардлага ба татгалзалаа үндэслэж байгаа, шүүх хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, хуульд заасан хэрэгслээр тодорхойлогдож буй нөхцөл байдлыг нотлох баримт гэнэ.

2. Хэрэгт нотлох баримт нь зохигч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээдийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичмэл ба эд мөрийн баримт, шинжээчийн дүгнэлт, кино ба гэрэл зураг, зураглал, дүрс, дууны бичлэг, ул мөрнөөс буулгаж авсан хэв, үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэлээр тогтоогдоно.

**37 дугаар зүйл.** Нотлох баримт гаргах ба цуглуулах

1. Зохигч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд нь өөрийн шаардлага ба татгалзлын үндэс болж байгаа байдлыг нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад оролцогчид нотлох баримт гаргаж болно.

3. Хэргийн оролцогч нь хуурамч нотлох баримт гаргах буюу түүнийг хууль бус аргаар цуглуулахыг хориглоно.

4. Хэргийг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай нотлох баримт нь төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой; өөр улс, орон нутагт байгаа учраас зохигч тэдгээрийг өөрөө олж авах боломжгүй; түүнчлэн туршилт, үзлэг, шинжилгээ хийлгэх, гэрчийг байцаах зэрэг тохиолдолд нотлох баримтыг зохигчийн хүсэлтээр шүүх бүрдүүлнэ.

5. Нотлох баримтыг гаргах, цуглуулах талаарх хуульд заасан журмыг зөрчсөн бол тэдгээр нь нотлох чадвараа алдах бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй.

6. Нотлох баримтыг анхан шатны шүүх хуралдаан эхлэхийн өмнө гаргана. Шүүх хуралдаан дээр гаргах боломжтой нотлох баримтыг хуралдаан дээр гаргаж болно.

7. Шүүхэд гаргаж өгсөн нотлох баримтаас нэг тал нь татгалзсаан ч эсрэг тал нь түүнийг иш татах эрхтэй.

8. Шүүх хуралдааны явцад шинээр нотлох баримт шаардагдвваал хуралдааныг нэг удаа хойшлуулах, хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй баримтыг хэргийн нотлох баримтаас хасах буюу шаардан авахаас татгалзах эрхийг шүүх эдлэх бөгөөд тэдгээр тохиолдолд тогтоол буюу захирамж гаргана.

38 дугаар зүйл. Нотлох баримтыг үнэлэх

1. Шүүх нотлох баримт ба хэргийн байдлыг хооронд нь харьцуулан дүгнэж, тал бүрээс нь бодитойгоор хянан үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлнэ.

2. Нотлох баримтыг тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлнэ.

3. Шүүхэд урьдаас хөдөлбөргүй үнэн гэж тогтоогдсон ямар ч нотлох баримт байж болохгүй.

4. Шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт тогтоогдсон буюу нийтэд илэрхий гэж үзэгдсэн үйл баримт хэрэг хянан шийдвэрлэхэд холбогдолтой байвал түүнийг дахин нотлохгүй.

39 дүгээр зүйл. Шүүхийн даалгавар, түүнийг биелүүлэх

1. Хянан шийдвэрлэж байгаа хэргийн талаар өөр орон нутгаас нотлох баримт бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байвал шүүгч захирамж гарган тодорхой ажиллагаа гүйцэтгэхийг зохих шүүхэд даалгана.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан захирамжид хэргийн товч агуулга, тодруулбал зохих нотлох баримтыг зааж, даалгавар биелүүлэх хугацааг тогтооно.

3. Шүүхийн даалгавар хүлээн авсан шүүх түүнийг заавал биелүүлнэ.

4. Шүүхийн даалгавар биелүүлэхэд хөтөлсөн тэмдэглэл, бүрдүүлсэн бүх материалыг хэрэг хянан хэлэлцэж байгаа шүүхэд тогтоосон хугацаанд явуулна.

40 дүгээр зүйл. Гэрчийн мэдүүлэг

1. Хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий байдлыг мэдэж байгаа хэн ч гэрч байж болно.

2. Гэрчийг шүүх өөрийн санаачилгаар буюу хэргийн оролцогчийн хүсэлтээр дуудаж мэдүүлэг авна.

3. Гэрчээр дуудагдсан этгээд шүүхэд заавал хүрэлцэн ирэх ба үнэн зөв мэдүүлэг өгөх үүрэгтэй. Мэдүүлэг өгөхөөс татгалзах буюу зайлсхийх, зориуд худал мэдүүлэг өгвөл Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээнэ.

4. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүхийн дуудлагаар ирж чадахгүй гэрчээс байгаа газарт нь очиж мэдүүлэг авч болно.

5. Гэрчүүдийн мэдүүлэгт ноцтой зөрөө байвал тэдгээрийг нүүрэлдүүлэн мэдүүлэг авч болно. Шүүгч нүүрэлдүүлэн мэдүүлэг авахдаа гэрчүүдээс бие биенээ таних эсэх, хоорондоо ямар харилцаатай болохыг асууна. Дараа нь тодруулах гэж байгаа зүйлийн талаар гэрчүүдээр ээлжлэн мэдүүлэг гаргуулна. Мэдүүлэг өгсний дараа шүүгч гэрчүүдэд асуулт тавьж болно. Харилцан нүүрэлдэж байгаа гэрчүүд бие биедээ асуулт тавьж болно.

6. Зохигчдын эхнэр, нөхөр, эцэг, эх, хүүхдийг зөвхөн өөрсдийнх нь зөвшөөрснөөр гэрчээр байцааж болно. Энэ тохиолдолд тэд гэрчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

7. Дараахь хүмүүсийг гэрчээр дуудах ба байцааж болохгүй:

1) үүргээ гүйцэтгэх замаар уг хэргийн байдлыг мэдэх болсон зохигчийн төлөөлөгч буюу эрүүгийн хэргийн өмгөөлөгч;

2) эрх зүйн бүрэн чадамжгүй этгээд.

**41 дүгээр зүйл.** Бичмэл нотлох баримт

1. Хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдох бүхий бичмэл хэлбэртэй баримтыг бичмэл нотлох баримт гэнэ.

2. Бичмэл нотлох баримтыг шүүхэд жинхэнэ эхээр нь, хэрэв эхийг өгөх боломжгүй бол нотариатаар батлуулсан хуулбарыг өгнө. Хуулбарыг өгсөн үед шаардлагатай гэж үзвэл шүүх жинхэнэ эхийг шаардан авах эрхтэй. Бичмэл нотлох баримтыг шаардан авахад бэрхшээлтэй байвал түүний хадгалагдаж байгаа газарт нь шүүх үзлэг явуулах ба шинжлэн судалж болно.

3. Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсны дараа бичмэл нотлох баримтын жинхэнэ эхийг түүнийг гаргаж өгсөн этгээд хүсвэл буцаан өгч болно. Харин уг баримтын батлагдсан хуулбарыг хэрэгт үлдээнэ.

**42 дугаар зүйл.** Эд мөрийн баримт

1. Хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтоож чадах бист зүйлийг эд мөрийн баримт гэнэ.

2. Эд мөрийн баримтыг хэрэгт, эсхүл тусгай байр, саванд нэгбүрчлэн тодорхой бүртгэлтэйгээр хадгална. Шүүхэд авчирч хадгалах боломжгүй эд мөрийн баримтыг түүний байгаа газарт нь үзлэг хийж, энэ тухай тэмдэглэл хөтөлнө. Шаардлагатай бол уг эд мөрийн баримтын талаар кино ба гэрэл зураг, зураглал, дүрс, дууны бичлэг хийж, бэхжүүлэн авч, хэрэгт хавсаргах буюу түүнийг битүүмжилж болно. Хүнсний ба түргэн гэмтэх бусад зүйлд үзлэгийг шүүхээс хэргийнх оролцогчдод мэдэгдэж даруй хийнэ. Үзлэг хийсний дараа уг зүйлийг хуульд өөрөөр заагаагүй бол гаргаж өгсөн этгээдэд буцаан олгоно.

3. Шаардлагатай бол эд мөрийн баримтыг эзэмшигчид нь буюу бусад итгэлтэй хүмүүст, эсхүл зохих нутгийн захиргааны болон цагдаагийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтанд хадгалуулж болно. Хадгалахаар авсан этгээд эд мөрийн баримтыг хэвийн байдлаар хадгалах үүрэгтэй.

4. Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсны дараа эд мөрийн баримтыг хуульд өөрөөр заагаагүй бол эзэмшигчид нь буцаан олгоно. Харин эд мөрийн баримтын кино ба гэрэл зураг, зураглал, дүрс, дууны бичлэгийг хэрэгт үлдээнэ.

**43 дугаар зүйл.** Бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг гарган өгөх

1. Иргэн, хуулийн этгээд нь шүүхээс шаардсан бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг тогтоосон хугацаанд явуулна. Хэрэв иргэн, хуулийн этгээд хүндэтгэн үзэх шалтгаанаар бичмэл нотлох баримт, эд мөрийн баримтыг явуулах боломжгүй бол энэ тухайгаа шаардсан шүүхэд мэдэгдэнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шаардлагыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй гэм буруутай албан тушаалтан, иргэнд захиргааны хариуцлагын тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

**44 дүгээр зүйл.** Шинжээч, түүний эрх үүрэг, шинжээчийн дүгнэлт

1. Хэргийг хянан шийдвэрлэхэд шинжлэх ухаан, тооцоо, тоо бүртгэл, урлаг, утга зохиол, техникийн зэрэг тусгай мэдлэг шаардагдах асуудлыг тодруулахын тулд зохигчийн хүсэлтээр буюу өөрийн санаачилгаар шүүгч захирамж гарган шинжээчийг томилно.

2. Шаардлагатай тохиолдолд шүүгч хэд хэдэн шинжээчийг нэгэн зэрэг томилж болох бөгөөд тэдгээр нь санал нэг-

тэй байвал нэг дүгнэлт гаргаж, түүнд бүгд гарын үсэг зурна. Харин аль нэг шинжээч нь бусад шинжээчийн дүгнэлттэй санал нийлэхгүй байвал дүгнэлтээ тусад нь гаргаж болно.

3. Шинжээч шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх, тавьсан асуултад үнэн зөв хариулах үүрэгтэй. Шинжээч санаатайгаар худал дүгнэлт гаргавал Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээнэ.

4. Шинжээчид өгсөн материал нь даалгасан үүргийг биелүүлэхэд хангалтгүй буюу шинжээч нь оногдсон үүргийг биелүүлэхэд шаардагдах мэдлэг эзэмшээгүй байвал дүгнэлт гаргахаас татгалзаж болно.

5. Шинжээч нь шаардлагатай гэж үзвэл тухайн хэргийн материалтай танилцах, нэмэлт материал гаргаж өгөхийг шүүхэд хүсэх эрхтэй.

6. Шинжээч дүгнэлтээ бичгээр гаргана. Дүгнэлтэд ямар шинжилгээ хийсэн, түүний үндсэн дээр гарсан дүгнэлт, шүүгчээс тавьсан асуултад өгсөн үндэслэл бүхий хариултыг тодорхой бичнэ.

**45 дугаар зүйл.** Хэрэг хянан шийдвэрлэх бусад ажиллагаа

1. Хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тодруулахын тулд шүүх үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагааг хөндлөнгийн 2 гэрчийг байлцуулан, хэргийн оролцогчдыг оролцуулан хийж, тэмдэглэл үйлдэж, түүнд уг ажиллагаанд оролцогчдын гарын үсгийг зурууулна. Харин хэргийн оролцогчид ирээгүй нь уг ажиллагаа явуулахад саад болохгүй.

2. Хөндлөнгийн гэрчээр уг хэрэгт хувийн сонирхолгүй, эрх зүйн бүрэн чадамжтай иргэнийг оролцуулна. Хөндлөнгийн гэрч нь түүнийг байлцуулан хийсэн ажиллагааны явц, агуулга, дүнг баталж өгөх үүрэгтэй. Хөндлөнгийн гэрч тэмдэглэлд засвар оруулахаар санал гаргах эрхтэй.

**46 дугаар зүйл.** Орчуулагч (хэлмэрч)

1. Хэргийн оролцогч нь монгол хэл мэдэхгүй, түүгээр харьцаж чадахгүй бол орчуулагч (хэлмэрч)-аа өөрөө сонгон авах буюу эсхүл орчуулагч (хэлмэрч)-ийг шүүгч захирамж гарган томилно.

2. Орчуулагч (хэлмэрч) нь тухайн этгээдийн нэхэмжлэл, шаардлага, тайлбар, мэдүүлэг, татгалзал; түүнчлэн түүнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын нэхэмжлэл, шаардлага, тайлбар, мэдүүлэг, татгалзал, шүүх хуралдааны болон бусад ажиллагаа, шүүхийн шийдвэрийн агуул-

гыг оролцуулж (хэлмэрчилж) өгөх, хэргийн материалтай танилцахад нь туслах үүрэгтэй.

3. Орчуулагч (хэлмэрч) нь шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх, үнэн зөв орчуулах (хэлмэрчлэх) үүрэгтэй.

4. Орчуулагч (хэлмэрч) зориуд буруу орчуулбал (хэлмэрчилбэл) Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээнэ.

**47 дугаар зүйл.** Нотлох баримтыг хангах

1. Хэргийг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай нотлох баримтыг гаргах боломжгүй буюу бэрхшээл төвөгтэй болох үндэстэй гэж үзсэн хэргийн оролцогч нь уг нотлох баримтыг хангуулахаар хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүхэд хүсэлт гаргаж болно.

2. Хүсэлтэд ямар нотлох баримтыг хангах, тэр нь хэргийн ямар байдлыг батлах, хангуулах болсон шалтгааныг заана.

3. Шүүгч хүсэлтийг хүлээн авч нотлох баримтыг хангах, эсхүл хангахаас татгалзах тухай захирамж гаргана.

**48 дугаар зүйл.** Тэмдэглэл

1. Анхан шатны шүүх хуралдаан болон хэргийн оролцогч оролцож байгаа бол давж заалдах, хяналтын шүүх хуралдаан явуулах, түүнчлэн хэргийн оролцогчдоос мэдүүлэг, тайлбар авах, үзлэг, туршилт хийх зэрэг хэрэг хянан шийдвэрлэх бусад ажиллагаа гүйцэтгэх, нотлох баримтыг шинжлэн судлахад тэмдэглэл үйлдэнэ.

2. Тэмдэглэлийг шүүх хуралдаан дээр шүүх хуралдааны нарийн бичгийн дарга; хэрэг хянан шийдвэрлэх бусад ажиллагааны үед шүүгч түүний даалгавраар шүүх хуралдааны нарийн бичгийн дарга үйлдэнэ.

**49 дүгээр зүйл.** Хэрэг хянан шийдвэрлэх бусад ажиллагааны тэмдэглэл

1. Хэрэг хянан шийдвэрлэх бусад ажиллагааны тэмдэглэлийг уг ажиллагааны явцад буюу түүнийг дуусмагц үйлдэнэ.

2. Тэмдэглэлд ямар ажиллагааг хэн, хэзээ, хаана явуулсан, түүний эхэлсэн ба дууссан цаг, ажиллагаанд оролцсон буюу байлцсан хүн нэг бүрийн овог, нэр, хаяг, түүнчлэн ажиллагааны дараалал, явц, илэрсэн нөхцөл байдлыг бичнэ. Тэмдэглэлийг уг ажиллагаа явуулахад оролцсон буюу байлцсан бүх хүн уншиж танилцах бөгөөд тэмдэглэлд засвар оруулахаар санал гаргах эрхтэйг тэдэнд тайлбарлаж өгнө.

3. Тэмдэглэлд үг ажиллагааг явуулсан этгээд болон түүнд оролцсон буюу байлцсан бүх хүн гарын үсэг зурна. Тэдгээр нь гарын үсэг зурахаас татгалзах эрхгүй.

4. Тэмдэглэлд гэрэл зураг, зураглал, үл мөрнөөс бүүлгаж авсан хэв болон хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой бусад зүйлийг хавсаргаж болох бөгөөд тэмдэглэлд энэ тухай заана.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамж

**50 дугаар зүйл.** Шүүхийн зардал

1. Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдон зайлшгүй гарах зардлыг шүүхийн зардал гэнэ.

2. Шүүхийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх боловч энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасан зардлыг зохигчдоор нөхөн төлүүлж улсын төсвийн орлогод оруулна.

**51 дүгээр зүйл.** Нөхөн төлүүлэх шүүхийн зардал

Шүүхээс гаргасан дараахь зардлыг зохигчдоор нөхөн төлүүлнэ:

1) шинжээч, орчуулагч (хэлмэрч)-ийн тээвэр, байр, хоолны зардал, шүүхийн шийдвэрээр гүйцэтгэсэн ажил нь үүрэгт ажилд нь хамаарахгүй бол ажлын хөлс;

2) гэрчийн тээвэр, байр, хоолны зардал, цалин, хөдөлмөрийн хөлс;

3) үзлэг хийх, туршилт явуулах, таньж олуулах ажиллагаа явуулахад гарсан зардал;

4) эд мөрийн баримт хадгалуулсны зардал.

**52 дугаар зүйл.** Нөхөн төлүүлэх шүүхийн зардлын хэмжээг тодорхойлох

Нөхөн төлүүлэх шүүхийн зардлыг дараахь журмаар тодорхойлно:

1) шинжээч, орчуулагч (хэлмэрч), гэрчид олгох тээвэр, байрны зардлыг зохих баримтыг үндэслэн; хоолны зардлыг улсын төсвөөс санхүүждэг байгууллагад мөрдөгдөж буй албан томилолтын зардлын хэмжээгээр;

2) шинжээч, орчуулагч (хэлмэрч)-ийн ажлын хөлсийг дундаж үнэлгээгээр;

3)) мэдүүлэг өгөхөөр шүүхэд дуудагдсан хүгацаанд гэрч ходөлмөрийн хөлсөөр хохирсон бол энэ хугацааны цалин, хөлсний дундажаар;

4)) бусад зардлыг гүйцэтгэлийн баримтад заасан хэмжээгээр.

**53 дугаар зүйл.** Шүүхийн зардлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх

1. Зохигч төлбөрийн чадваргүй буюу хуульд заасан бусад үндэслэлээр түүнийг шүүхийн зардал нөхөн төлөхөөс шүүхийн шийдвэрээр чөлөөлж болно.

2. Шүүх тухайн этгээдийн эд хөрөнгийн болон бусад байдлыг харгалзан шүүхийн зардлыг нөхөн төлөх хэмжээг нь багасгах буюу хугацааг хойшлуулах, хэсэгчлэн төлүүлэх эрхтэй.

**54 дүгээр зүйл.** Шүүхийн зардлыг хуваарилах

1. Шүүхийн зардлыг нэхэмжлэл бүрэн хангагдсан тохиолдолд харицуагчаар, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд нэхэмжлэгчээр нөхөн төлүүлнэ.

2. Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан бол шүүхийн зардлыг тэр хэмжээгээр харицуагч буюу нэхэмжлэгчид хуваарилан харицуулна.

3. Дээд шатны шүүх хэргийг шинэчлэн хэлэлцүүлэхгүйгээр шүүхийн шийдвэрийг өөрчилбөл шүүхийн зардлын хуваарилалтыг нэгэн адил өөрчлөн шийдвэрлэнэ.

4. Зохигчид эвлэрэн хэлэлцэхдээ шүүхийн зардлыг өөрөөр хуваарилахаар тохиролцоогүй бол шүүх энэ зүйлд заасан журмаар шийдвэрлэнэ.

5. Нэхэмжлэгч гаргасан нэхэмжлэлээсээ татгалзвал харицуагч нь шүүхийн зардлыг нөхөн төлөхгүй. Харин нэхэмжлэгч шаардлагаа дэмжээгүй явдал нь харицуагч өөрийн үүргийг сайн дураар гүйцэтгэснээс болсон бол шүүхийн зардлыг харицуагч нөхөн төлнө.

**55 дугаар зүйл.** Улсын тэмдэгтийн хураамж

1. Хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдуулж төлөх улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээ, хураамж, төлөх, хөнгөлөх журмыг Тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар зохицуулна.

2. Хураамжийг буцаан олгох, нөхөн төлүүлэх, чөлөөлөх тухай асуудлыг Тэмдэгтийн хураамжийн хуулийн холбогдох заалт болон энэ хуулийн 56, 57, 58 дугаар зүйлд зааснаар зохицуулна.

**56 дугаар зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийг нөхөн төлүүлэх, хураамжаас чөлөөлөх

1. Нэхэмжлэл гаргах үед түүний үнийг шууд тогтооход бэрхшээлтэй байвал шүүгч улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг урьдчилан тогтоож, хэрэг шийдвэрлэхдээ шүүхээс тогтоосон нэхэмжлэлийн үнэд тохируулан нөхөн төлүүлнэ.

2. Нэхэмжлэлийн шаардлагыг ихэсгэх тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг нэхэмжлэлийн үнийн ихэссэн хэмжээгээр нөхөн төлүүлнэ.

3. Улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх асуудлыг энэ хуулийн 53 дугаар зүйлд заасны адилаар зохицуулна.

**57 дугаар зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийг буцаах

1. Шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан бол улсын тэмдэгтийн хураамжийг хураасан хэмжээгээр буцаан олгоно.

2. Нэхэмжлэгч шаардлагаа багасгах, нэхэмжлэлээсээ татгалзах, зохигчид эвлэрэн хэлэлцэх замаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавал улсын тэмдэгтийн хураамжийг буцааж олгохгүй.

**58 дугаар зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийг зохигчдод нөхөн төлүүлэх

Нэхэмжлэгчийн төлсөн улсын тэмдэгтийн хураамжийг зохигчдод нөхөн төлүүлэх асуудлыг энэ хуулийн 54 дүгээр зүйлд заасны адилаар зохицуулна.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Нэхэмжлэл гаргах, түүнийг хүлээн авах

**59 дүгээр зүйл.** Нэхэмжлэлийн хэлбэр

Нэхэмжлэлийг шүүхэд бичгээр гаргана.

**60 дугаар зүйл.** Нэхэмжлэлийн бүрдүүлбэр

1. Нэхэмжлэлд дараахь зүйлийг заана:

1) нэхэмжлэлийг ямар шүүхэд гаргаж байгаа;
2) нэхэмжлэгчийн овог, нэр, хаяг;
3) хариуцагчийн овог, нэр, хаяг;
4) нэхэмжлэлийн агуулга;
5) нэхэмжлэлийн үнэ;
6) шаардлагыг нотлох баримт;
7) хавсаргасан бичиг баримтын жагсаалт.

2. Нэхэмжлэлд улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, хэрэв нэхэмжлэлийг төлөөлөгч гаргасан бол итгэмжлэлийг хавсаргана.

3. Нэхэмжлэлд нэхэмжлэгч буюу төлөөлөгч гарын үсгээ зурж, нэхэмжлэл болон түүнд хавсаргасан бичиг баримтыг хариуцагчийн тоогоор хувилж өгнө.

**61 дүгээр зүйл.** Нэхэмжлэлийн үнийг тодорхойлох

1. Нэхэмжлэлийн үнийг дараахь байдлаар тодорхойлно:

1) мөнгө төлүүлэхээр шаардсан нэхэмжлэлд нэхэмжилж байгаа мөнгөний дүнгээр;

2) эд хөрөнгө гаргуулах тухай нэхэмжлэлд нэхэмжилж байгаа эд хөрөнгийн үнийн дүнгээр;

3) бие даасан хэд хэдэн шаардлагыг нэг нэхэмжлэлд бичсэн бол бүх шаардлагын үнийн нийлбэрээр;

4) гэрээ хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах тухай нэхэмжлэлд уг гэрээ, хэлцлийн үнийн дүнгээр;

5) тогтмол хугацаанд төлөгдөх тэтгэвэр, тэтгэмж, тэтгэлэг, хохирол, нөхөн төлбөр шаардсан нэхэмжлэлд тэдгээрийн нэг жилийн хугацаанд төлбөл зохих дүнгээр.

2. Гадаад валютын ханшийг Монголбанкны зарласан албан ёсны ханшаар, эд хөрөнгийн үнийг нотлогдсон хэмжээгээр тус тус тооцно.

**62 дугаар зүйл.** Нэхэмжлэлийг хүлээн авах

Нэхэмжлэлийг тухайн шүүхийн шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хүлээн авч, ийнхүү авснаа баримтжуулна.

**63 дугаар зүйл.** Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах

1. Шүүгч дараахь тохиолдолд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана:

1) шүүхэд харьяалагдахгүй бол;

2) уг шүүхэд харьяалагдахгүй бол;

3) шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлүүлэх талаар хуульд заасан журмыг нэхэмжлэгч зөрчсөн ба энэ журмыг хэрэглэх боломжгүй байвал;

4) нэхэмжлэгч нь эрх зүйн бүрэн чадамжгүй этгээд байвал;

5) нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан бол;

6) нэхэмжлэлд дурдсан үйл баримт, зохигчдын гэм буруугийн талаар хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийд-

вэр, эсхүл нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан, түүнчлэн хэргийг хэрэгсэхгүй болгосон хуулийн хүчин төгөлдөр шүүхийн тогтоол буюу шүүгчийн захирамж байгаа бол;

7) зохигчдын маргаж байгаа зүйл ба түүний үндэслэлийн талаарх өөр хэргийг шүүх хянан шийдвэрлэж байгаа бол;

8) зохигч болох хүн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд маргаж байгаа шаардлага буюу маргаантай үүрэг нь эрх залгамжлагчид шилжээгүй бол;

9) энэ хуулийн 60 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй байвал.

2. Шүүгч нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзахдаа захирамж гаргах бөгөөд түүнд уг нэхэмжлэлийг хэрхэн мэдүүлэх, эсхүл шүүх түүнийг хүлээн авахад саад болж байгаа зөрчлийг хэрхэн засахыг зааж өгнө.

**64 дүгээр зүйл.** Нэхэмжлэлийг арбитрт шилжүүлэх

Энэ хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас арбитрт харьяалагдах нэхэмжлэлийг шүүгч захирамж гарган арбитрт шилжүүлнэ.

**65 дугаар зүйл.** Хэрэг үүсгэх

Шүүгч энэ хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 63 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл байхгүй гэж үзвэл хэрэг үүсгэх тухай захирамж гаргана.

**66 дугаар зүйл.** Хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаа

Нэхэмжлэлийг хүлээн авч хэрэг үүсгэсэн шүүгч дараахь ажиллагаа явуулна:

1) зохигчид, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээдэд шаардлага ба татгалзлаа үндэслэж буй нотлох баримтаа өөрөө гаргаж нотлох үүрэгтэйг танилцуулж, эдлэх эрхийг нь тайлбарлан өгөх;

2) хариуцагчид нэхэмжлэл, түүнд хавсаргасан баримт бичгийн хувийг гардуулах;

3) шаардлагатай бол энэ хуулийн 37 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан ажиллагаа явуулах.

**67 дугаар зүйл.** Зохигчид эвлэрэх, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзах, хариуцагч шаардлагыг зөвшөөрөх, биелүүлэх

1. Хэрэг үүсгэсний дараа нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэгчийн шаардлагыг зөвшөөрөх хүлээсэн, эсхүл зохигчид эвлэрэн хэлэлцвэл шүүгч нэхэмжлэгчийн татгалзал, хариуцагчийн зөвшөөрөл, зохигчдын эв-

лэрлийг баталж хэргийг хэрэгсэхгүй болгох тухай захирамж гаргана.

22. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан захирамж нь шийдвэрийн нэгэн адил журмаар биелэгдэнэ.

3. Нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч биелүүлбэл шүүгч хэргийг хэрэгсэхгүй болгох тухай захирамж гаргана.

**688 дугаар зүйл.** Нэхэмжлэлийн хэд хэдэн шаардлагыг нэгтгэх ба тусгаарлах

1. Нэхэмжлэгч хоорондоо холбоотой хэд хэдэн шаардлагыг нэг нэхэмжлэлд нэгтгэн гаргаж болно. Нэгтгэн гаргасан нэхэмжлэлийн шаардлагаас нэг буюу хэд хэдэн шаардлагыг тусгаарлан хянан шийдвэрлэх нь зохистой гэж үзвэл тэдгээрийг шүүгчийн захирамжаар тусгаарлаж болно.

2. Хэд хэдэн нэхэмжлэгч гаргасан буюу хэд хэдэн хариуцагчийд холбогдуулан гаргасан нэхэмжлэлийн шаардлагаас нэг бүюу хэд хэдэн шаардлагыг тусгаарлан хянан шийдвэрлэх нь зохистой байвал тэдгээрийг шүүгчийн захирамжаар тусгаарлаж болно.

3. Нэг шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд адил төрлийн хэд хэдэн хэрэгт урьд оролцож байсан зохигчид оролцож байгаа, эсхүл нэг нэхэмжлэгчээс өөр өөр хариуцаагчид гаргасан нэхэмжлэлтэй буюу өөр өөр нэхэмжлэгчээс нэг хариуцагчид гаргасан нэхэмжлэлтэй хэд хэдэн хэргийг нэг ажиллагаагаар хамтатган хянан шийдвэрлэх нь уг хэргийг түргэн, зөв шийдвэрлэхэд ашигтай гэж үзвэл тэдгээрийг шүүгчийн захирамжаар нэгтгэн хэлэлцэж болно.

**689 дүгээр зүйл.** Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах

1. Хэрэг үүсгэсний дараа нэхэмжлэгчийн хүсэлтийг үндэслэн шүүгч шаардлагатай гэж үзвэл шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах дараахь арга хэмжээг захирамж гарган авч болно:

1) хариуцагчийн эд хөрөнгө буюу мөнгийг битүүмжлэх;

2) хариуцагчаас ямар нэгэн тодорхой ажиллагаа явуулахыг хориглох;

3) хариуцагчийн дансны зарлагын хөдөлгөөнийг нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээнд зогсоох.

2. Шүүгч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэд хэдэн арга хэмжээг нэгэн зэрэг авч болно.

3. Шүүгч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээ авахдаа энэ хуулийн 70 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг нэхэмжлэгчид мэдэгдэнэ.

4. Шүүгч хариуцагчийн хүсэлтээр энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нэг арга хэмжээг өөр арга хэмжээгээр сольж болно. Хариуцагч нь мөнгөн төлбөр гаргуулах тухай нэхэмжлэлтэй хэргийн талаар авсан арга хэмжээг солиулахын тулд нэхэмжлэлээр шаардсан хэмжээний мөнгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн харилцах дансанд оруулж болно.

**70 дугаар зүйл.** Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг биелүүлэх, түүнээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэх

1. Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамжийг гарсан өдрөөс нь эхлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар биелүүлнэ.

2. Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ нь нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болтол хэвээр байна.

3. Нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд энэ хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээнээс хариуцагчид учирсан хохирлыг нэхэмжлэгчээр нөхөн төлүүлнэ.

**71 дүгээр зүйл.** Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа

1. Хуулиар тусгай хугацаа тогтоогоогүй бол хэргийг үүсгэсэн өдрөөс нь хойш 60 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

2. Хэрэг хянан шийдвэрлэх хугацааг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч захирамжаараа сунгаж болно.

3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусад хугацааг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааны дотор шүүх тогтоож болно.

4. Хугацаа тоолох, тодорхойлоход Иргэний хуульд заасан журмыг хэрэглэнэ.

**72 дугаар зүйл.** Нэхэмжлэлийг хариуцагчид гардуулах

1. Шүүгч нэхэмжлэлийн хувийг хариуцагчид гардуулна.

2. Хариуцагч нь нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрөх эсэхээ нэхэмжлэлийн хувийг хүлээн авсан өдрөөс хойш 14

хоноогийн дотор шүүхэд мэдэгдэж, эс зөвшөөрвөл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа ирүүлэх үүрэгтэй.

**733 дугаар зүйл.** Сөрөг нэхэмжлэл

1. Үндсэн нэхэмжлэлтэй хамтруулан хянан шийдвэрлүүлэхийн тулд хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхээс өмнө харилцагч сөрөг нэхэмжлэл гаргах эрхтэй. Сөрөг нэхэмжлэл нь эдэнэ хуулийн 60 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

2. Сөрөг нэхэмжлэлийн шаардлага нь үндсэн нэхэмжлэлийн шаардлагатай тооцогдох байвал шүүх сөрөг нэхэмжлэлийг үндсэн нэхэмжлэлтэй хамтруулан хэлэлцэнэ. Бусад тохиолдолд тэдгээрийг хамтруулан хэлэлцэх эсэхийг шүүгч шийддвэрлэнэ.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

### Шүүх хуралдааны бэлтгэл хангах

**711 дүгээр зүйл.** Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх

1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дараахь тохиолдолд шүүх хуралдааны үед шүүхийн тогтоолоор, шүүх хуралдаанаас өмнө шүүгчийн захирамжаар түдгэлзүүлнэ:

1) зохигч болох хүн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд маргаантай байгаа шаардлага буюу маргаантай үүрэг нь эрх залгамжлагчид шилжих ёстой байвал;

2) зохигчид асран хамгаалалт тогтоох шаардлагатай болбол;

3) зохигч нь онц ба дайны байдал зарласан нөхцөлд цэргийн албаа хааж байгаа бол;

4) эрүү, иргэний ба захиргааны журмаар шийдвэрлэгдвэл зохих өөр хэрэг, маргааныг шийдвэрлэхээс өмнө уг хэргийг шийдвэрлэх боломжгүй бол;

5) зохигч хүнд өвчний учир эмнэлэгт байгаа бол;

6) харилцагчийг эрэн сурвалжилж байгаа бол;

7) хэргийг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль Үндсэн хуульд нийцээгүй тухай асуудлаар Улсын дээд шүүхэд санал оруулсан бол.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад хүндэтгэн үзэх шалтгаан байвал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж болно.

3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх хугацааг шүүх буюу шүүгч тогтооно.

4. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн шалтгаан арилмагц хэргийн оролцогчдын хүсэлт буюу шүүхийн санаачилгаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шинэчлэн явуулах тухай шүүгч захирамж гаргах ба энэ өдрөөс эхлэн хэрэг хянан шийдвэрлэх хугацааг үргэлжлүүлэн тоолно.

**75 дугаар зүйл.** Шүүх хуралдааны бэлтгэл хангах шүүгчийн ажиллагаа

Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан шүүгч дараахь бэлтгэл ажиллагаа явуулна:

1) хэргийг хянан шийдвэрлэхэд нотлох баримт хангалттай гэж зохигчид үзсэн, эсхүл энэ хуулийн 71 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа дууссан, түүнчлэн шаардлагатай гэж үзсэн тохиолдолд шүүгч уг хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамж гаргаж, шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг товлох;

2) хэргийн болон шүүх хуралдааны оролцогчдод шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг мэдэгдэх;

3) хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэлэлцүүлэх бол шүүх бүрэлдэхүүн болон хуралдаан даргалагчийг томилуулах, иргэдийн төлөөлөгчийн тоог тогтоолгох ба тэдгээрийг томилуулах.

**76 дугаар зүйл.** Шүүхийн мэдэгдэх хуудас

1. Зохигчид, түүнчлэн шүүх хуралдаанд ирвэл зохих бусад оролцогчдод шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг шүүхийн мэдэгдэх хуудсаар тэдгээрийн оршин суугаа буюу ажлын газрын хаягаар мэдэгдэж, хүрэлцэн ирээгүйгээс гарах холбогдлыг заана. Шүүхийн мэдэгдэх хуудсыг баталгаат шуудангаар буюу биечлэн хүргэнэ. Шаардлагатай үед утас, цахилгаан, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдэгдэж болно.

2. Мэдэгдэх хуудсыг иргэнд гардуулан өгч, гарын үсэг зуруулж, гардуулсан он, сар, өдөр, цагийг тэмдэглэнэ. Хуулийн этгээдэд өгөх мэдэгдэх хуудсыг түүний удирдах албан тушаалтанд гардуулан өгч, гарын үсэг зуруулж, гардуулсан он, сар, өдөр, цагийг тэмдэглэнэ.

3. Мэдэгдэх хуудсыг гардуулан өгвөл зохих иргэн оршин суугаа газартаа буюу ажлынхаа газарт байхгүй бол уул хуудсыг түүний хамт амьдран суудаг насанд хүрсэн иргэн, эсхүл нутгийн захиргааны байгууллагын зохих албан тушаалтанд буюу ажлын газрыхх нь захиргаанд хүлээлгэн өгч, гарын үсэг зуруулна.

4. Зохигчид нь мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас татгалзвал энэ тухай мэдэгдэх хуудсанд тэмдэглэж шүүхэд буцаана. Энэ нь хэргийг хянан шийдвэрлэхэд саад болохгүй.

5. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа үед хэргийн оролцогч хаягаа өөрчилбөл энэ тухай шүүхэд мэдэгдэх үүрэгтэй. Хаягаа өөрчилснөө мэдэгдээгүй зохигчид мэдэгдэх хуудсыг түүний сүүлчийн хаягаар хүргүүлж, энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан иргэн, албан тушаалтанд хүлээлгэн өгөх бөгөөд түүнийг хүргэсэнд тооцно.

6. Мэдэгдэх хуудсыг хүлээн авсан хэргийн бусад оролцогч шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол тэдгээрийг шүүгчийн захирамжаар албанд ирүүлэх буюу тэдгээрт захиргааны харицлагын тухай хуульд заасан харицуцага хүлээлгэнэ.

**77 дугаар зүйл.** Шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг томилох

Хэрэг шийдвэрлэх шүүгч болон шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч томилно.

**78 дугаар зүйл.** Иргэдийн төлөөлөгчийг томилох

1. Шүүх хуралдаанд тухайн шүүхийн харьяалах нутаг дэвсгэрээс сонгогдсон иргэдийн төлөөлөгчийг оролцуулна.

2. Шүүх хуралдаан даргалагч иргэдийн төлөөлөгчийн тоог тогтоож, энэ хуулийн 92 дугаар зүйлийн заалтыг удирдлага болгон тэдгээрийг томилно.

**79 дүгээр зүйл.** Хэрэг шилжүүлэх

1. Харьяаллын журмаар нэхэмжлэлийг нэгэнт хүлээн авсан бол шүүх хэргийг хянан шийдвэрлэж дуусгах ёстой бөгөөд дараахь шалтгаанаар шүүх хуралдааны үеэр буюу түүнээс өмнө шүүхийн тогтоол буюу шүүгчийн захирамжаар хэргийг шүүхэд шилжүүлж болно:

1) хэргийг тал бүрээс нь, бүрэн, зөв, түргэн хянан шийдвэрлэхийн тулд нотлох баримтын дийлэнх нь байгаа газрын шүүхэд хянан хэлэлцэх шаардлагатай гэж үзвэл;

2) оршин суугаа газар нь урьд мэдэгдээгүй байсан хариуцагч өөрийн оршин суугаа газрын шүүхэд шилжүүлж өгөхийг хүсвэл;

3) нэхэмжлэлийг хүлээн авахдаа шүүхийн харьяаллын журмыг зөрчсөн нь илэрвэл.

2. Шилжүүлсэн хэргийг хүлээн авсан шүүх түүнийг хянан шийдвэрлэх үүрэгтэй. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шилжүүлсэн хэргийн харьяаллын талаар шүүхүүд хоорондоо маргаж болохгүй.

**80 дугаар зүйл.** Хэрэг шилжүүлэх журам

Хэргийг нэг шүүхээс нөгөө шүүхэд шилжүүлэх тухай шүүхийн тогтоол (шүүгчийн захирамж)-д гомдол гаргах хугацаа өнгөрсний дараа уг хэргийг шилжүүлнэ. Хэрэв гомдол гарсан байвал уг гомдлыг шийдвэрлэсэн дээд шатны шүүхийн шийдвэр гарсны дараа хэргийг шилжүүлнэ.

## ДОЛДУГААР БҮЛЭГ

### Шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны оролцогчид, хуралдааны нийтлэг журам

**81 дүгээр зүйл.** Шүүх бүрэлдэхүүн

1. Анхан шатны журмаар шүүгч дангаар шийдвэрлэхээс бусад хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэнэ.

2. Урьд нь шүүгч дангаар шийдвэрлэж гаргасан анхан шатны шүүхийн шийдвэр нь давж заалдах буюу хяналтын шүүх хуралдаанаас хүчингүй болж хэргийг дахин хянан шийдвэрлэх тохиолдолд түүнийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ.

3. Давж заалдах журмаар хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ.

4. Хяналтын журмаар хэргийг аймаг, нийслэлийн шүүх 3 шүүгчийн, Улсын дээд шүүх нийт шүүгчдийн олонхийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ.

5. Энэ хуулийн 92 дугаар зүйлд заасан үндэслэлээр Улсын дээд шүүхийн хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцож болох шүүгчдийн тоо нийт шүүгчдийн олонхид хүрэхгүй бол оролцох эрх бүхий шүүгчдийн бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэнэ.

**82 дугаар зүйл.** Шүүгч дангаар хянан шийдвэрлэх хэрэг

1. Шүүгч дор дурдсан хуулийн дараахь зүйл, заалтад заасаан хэргийг дангаар хянан шийдвэрлэнэ:

1) Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 1, 5, 6 дахь хэсэг;

2) Хөдөлмөрийн хуулийн 92 дугаар зүйлийн 1, 3, 6, 8, 9, 10 дахь хэсэг;

3) Гэр бүлийн хуулийн 16—24, 33, 55—64, 70—75 дугаар зүйл;

4) Тэтгэврийн хуулийн 61 дүгээр зүйл;

5) Тэтгэмжийн хуулийн 27 дугаар зүйл;

6) Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 136 дугаар зүйлийн 1, 4, 5-д заасан хэрэг;

7) шүүх торгууль ногдуулахаар хуульд заасан асуудал.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэрэг ээдрээ төвөгтэй бол түүхайн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар түүнийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж болно.

**83 дугаар зүйл.** Шүүгч буюу шүүх бүрэлдэхүүнийг өөрчилж үл болох

Хэрргийг гагцхүү нэг шүүгч буюу шүүхийн нэг бүрэлдэхүүнэээр хянан хэлэлцэж шийдвэрлэнэ. Хэрэв шүүх бүрэлдэхүүнийй хэн нэг нь шүүх хуралдааны ажиллагаанд оролцох боломжгүй болсон бол түүнийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар өөр шүүгчээр сольж, уг хэргийг шинээр эхлэн хэлэлцэнэ.

**84 дүгээр зүйл.** Шүүх хуралдааны оролцогчид

Шүүүх хуралдааны оролцогчид гэдэгт хэргийн оролцогч, иргэдийн төлөөлөгч, прокурор, шинжээч, орчуулагч (хэлмэрч), шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хамаарна.

**85 дугаар зүйл.** Прокурор, түүний эрх үүрэг

1. Прокурор шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно.

2. Шүүх хуралдаанд оролцох прокурор тухайн хэргийн материаалтай танилцах, нотлох баримт шинжлэхэд оролцох, хүсэлт гаргах, дүгнэлт гаргах, шүүхийн шийдвэр бодит байдал буюу хуульд нийцээгүй гэж үзвэл давж заалдах журмаар гомдлын эсэргүүцэл, эсхүл хэрэг нь хяналтын журмаар Улсын дээд шүүхэд хянагдах бол Улсын ерөнхий прокурорт саналаа бичих эрхтэй.

3. Төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл прокурор төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргаж болно. Иймхүү нэхэмжлэл гаргасан прокурор нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Прокурор гаргасан нэхэмжлэлээсээ татгалзсан нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгох үндэслэл болохгүй.

**86 дугаар зүйл.** Иргэдийн төлөөлөгч, түүний эрх, үүрэг

1. Хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэх шүүх хуралдаанд 3 хүртэл тооны иргэдийн төлөөлөгч оролцуулна.

2. Иргэдийн төлөөлөгч нь шүүхийн байранд уг хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, нотлох баримт шинжлэхэд оролцох, зохигчид, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд, гэрч, шинжээчид асуулт тавих, нэмэлт нотлох баримт судлах талаар болон шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах хүсэлт гаргах, түүнчлэн шүүхийн шийдвэрийг давж заалдах эрх эдэлж, маргааны үйл баримт, зохигчдын гэм буруугийн талаар дүгнэлт гаргах үүрэгтэй.

**87 дугаар зүйл.** Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга

Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нь шүүх хуралдаан явуулах бэлтгэлийг хангаж, шүүх хуралдааны ирцийг бүртгэж, хуралдааны ажиллагааг тэмдэглэл үйлдэн баталгаажуулна.

**88 дугаар зүйл.** Шүүхийн хуяг

1. Шүүхийн хуяг нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) шүүх хуралдааны дэгийг сахиулах, шүүх бүрэлдэхүүн болон хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах;

2) шүүх хуралдааны дэг, хуралдаан даргалагчийн шийдвэрийг оролцогчид болон хуралдааны танхимд байгаа хүн үл биелүүлбэл албадан биелүүлэх;

3) шүүхэд дуудагдсан этгээд ирэхгүй бол албадан ирүүлэх.

2. Шүүх хуралдааны үед шүүхийн хуяг нь зөвхөн хуралдаан даргалагчид захирагдана.

**89 дүгээр зүйл.** Шүүх хуралдаан

Хэргийг гагцхүү шүүх хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

**90 дүгээр зүйл.** Шүүх хуралдаан даргалагч, түүний эрх, үүрэг

1. Хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдэрлэж байгаа бол тухайн шүүхийн Ерөнхий шүүгч буюу үүний томилсон шүүгч; дангаар хэргийг шийдвэрлэж байгаа бол шүүгч шүүх хуралдааныг тус тус даргална.

2. Шүүх хуралдаан даргалагч нь хуралдааныг удирдахаа хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн, бодитойгоор тогтоох, хэргийн оролцогчдыг бүрэн эрхээ хэрэгжүүлэх, мэтгэлзэх боломжоор хангана.

3. Шүүх хуралдаан даргалагч хуралдааныг зохих журмаар явуулах шаардлагатай арга хэмжээг авна.

**91 дүгээр зүйл.** Шүүх хуралдааны нийтлэг журам

1. Шүүх хуралдааны танхимд байгаа бүх хүн шүүхийг үндэтгэх, хуралдааны танхимд тогтоосон журмыг сахих, уралдаан даргалагчийн шийдвэрт захирагдах үүрэгтэй.

2. Шүүх хуралдаанд оролцогчид тайлбар, мэдүүлэг, дүгэлт гаргахдаа суудлаасаа босно. Хуралдаанд оролцогч нь вчний улмаас хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр суугаараа үг хэлж болно.

3. Шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч хуралдааны танхимд рж ирэх, шүүхийн шийдвэрийг уншиж сонсгох үед танхимд айгаа бүх хүн суудлаасаа босно.

4. Шүүх хуралдааны журам зөрчсөн этгээдэд эхний удаа уралдаан даргалагч урьдчилан сануулна. Дахин зөрчил ргасан этгээдийг хуралдаан даргалагчийн захирамжаар үүх хуралдааны танхимаас гаргаж, энэ хуулийн 241 дүэр зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

5. Зөрчлийн улмаас хэргийн оролцогч, гэрч, шинжээчийг уралдааны танхимаас гаргасан тохиолдолд хуралдааныг уралдаан даргалагчийн захирамжаар тодорхой хугацаагаар йшлуулах буюу эсхүл тэдгээрийн тайлбар, мэдүүлгийг сонхгүйгээр хэргийг хэлэлцэх боломжтой гэж үзвэл үргэлжүүлэн явуулах бөгөөд хуралдаан даргалагч уг этгээдэд үний байхгүйд хэлэлцсэн асуудлыг танилцуулна.

**92 дугаар зүйл.** Татгалзан гаргах үндэслэл

1. Шүүгч дараахь үндэслэл байвал хэрэг хэлэлцэхэд олцож болохгүй:

1) урьд нь уг хэргийг хянан шийдвэрлэхэд иргэдийн өөлөгч, өмгөөлөгч, прокурор, шүүх хуралдааны нарийн чгийн дарга, гэрч, шинжээч, орчуулагч (хэлмэрч)-ийн хувьд оролцсон;

2) уг хэргийн болон шүүх хуралдааны оролцогчийн төрөл садан бол, эсхүл шүүх бүрэлдэхүүнд хоорондоо төрөл садангийн холбоотой хүмүүс орсон байвал;

3) хэргийн оролцогчтой хувийн харилцаатай, түүнчлэн уг хэргийг шударгаар шийдвэрлэж чадах талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал.

2. Анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй. Анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгчтэй төрөл садан шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй.

3. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаас бусад үндэслэлээр шүүгчийг татгалзаж үл болно.

4. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь иргэдийн төлөөлөгч, прокурор, шинжээч, орчуулагч (хэлмэрч), шүүх хуралдааны нарийн бичгийн даргад нэгэн адил хамаарна.

5. Шинжээч энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна дараахь тохиолдолд шүүх хуралдаанд оролцож болохгүй:

1) албан тушаалын буюу бусад байдлаар хэргийн оролцогч нь шинжээчид нөлөөлж болох байвал;

2) урьд нь түүний хийсэн шалгалтын материал уг хэргийн үндэс болсон бол.

**93 дугаар зүйл.** Татгалзан гаргах хүсэлт, татгалзан гарах

1. Энэ хуулийн 92 дугаар зүйлд заасан татгалзан гарах үндэслэл байвал шүүгч, иргэдийн төлөөлөгч, прокурор, шинжээч, орчуулагч (хэлмэрч), шүүх хуралдааны нарийн бичгийн дарга энэ тухайгаа шүүх хуралдаан эхлэхээс өмнө, эсхүл татгалзан гарах үндэслэл шүүх хуралдааны явцад тогтоогдвол тухайн үед нь мэдэгдэж татгалзан гарах үүрэгтэй.

2. Энэ хуулийн 92 дугаар зүйлд заасан үндэслэлээр энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээдийг татгалзан гаргахыг зохигч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч, прокурор, гуравдагч этгээд хүсч болно.

3. Татгалзан гаргах тухай хүсэлт гарвал шүүх хэргийн оролцогчдын саналыг сонсож болно. Түүнчлэн татгалзан гаргагдаж байгаа этгээд хүсвэл түүний тайлбарыг сонсоно.

4. Татгалзан гаргах тухай асуудлыг шүүх бүрэлдэхүүнд буюу шүүгч зөвлөлдөх тасалгаанд хэлэлцэж, тогтоол буюу захирамж гаргаж шийдвэрлэнэ.

5. Шүүгчийг татгалзан гаргах тухай асуудлыг түүнийг байлцуулахгүйгээр бусад шүүгчид шийдвэрлэнэ. Санал тэнцвэл уг шүүгчийг татгалзан гаргасанд тооцно. Хэд хэдэн буюу хэргийг дангаар шийдвэрлэх шүүгчийг, түүнчлэн шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах хүсэлтийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч шийдвэрлэнэ.

6. Иргэдийн төлөөлөгч, прокурор, шинжээч, орчуулагч (хэлмэрч), шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлтийг хэргийг хэлэлцэж байгаа шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч шийдвэрлэнэ.

**94 дүгээр зүйл.** Шүүгчийг татгалзан гаргасны үр дагавар

1. Шүүх бүрэлдэхүүн буюу шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг хангасан бол хэргийг өөр бүрэлдэхүүн (шүүгч)-ээр хянан шийдвэрлэнэ.

2. Тухайн шүүхийн бүх шүүгчийг татгалзан гаргасан тохиолдолд хэргийг адил шатны өөр шүүхээр хянан шийдвэрлүүлэхээр Ерөнхий шүүгчийн захирамжаар дээд шатны шүүхэд шилжүүлнэ.

**95 дугаар зүйл.** Шийдвэрийг зөвлөлдөх тасалгаанд гаргах

1. Бүх шатны шүүх хэргийг хянан хэлэлцээд шийдвэрээ зөвлөлдөх тасалгаанд гаргана.

2. Зөвлөлдөх тасалгаанд хэргийг шийдвэрлэх талаар шүүгчийн гаргасан санал нууц байна.

**96 дугаар зүйл.** Санал хураах

1. Шүүх бүрэлдэхүүн асуудал бүрийг олонхийн саналаар шийдвэрлэнэ.

2. Хуралдаан даргалагч өөрийн саналыг бусад шүүгчийн дараа гаргана. Асуудал шийдвэрлэхэд шүүгч саналаа өгөхөөс татгалзах эрхгүй.

3. Улсын дээд шүүхэд хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх бүрэлдэхүүний санал тэнцвэл тухайн асуудлаар олонхийн санал аваагүй гэж үзнэ.

**97 дугаар зүйл.** Шүүхийн шийдвэрийн агуулга

1. Шүүхийн шийдвэр нь тодорхойлон бичих ба тогтоох хэсгээс бүрдэнэ.

2. Тодорхойлон бичих хэсэгт шийдвэрийг хэзээ, хаана, ямар шүүх гаргаж байгаа, шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, иргэдийн төлөөлөгч, прокурор, шүүх хуралдааны нарийн

бичгийн дарга, хэргийн оролцогчдыг заахын хамт нэхэмжлэгчийн шаардлага, хариуцагчийн татгалзал, зохигчдын төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээдийн тайлбар, прокурорын дүгнэлт, иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг тусгана.

3. Тогтоох хэсэгт хэргийг хэрхэн шийдвэрлэсэн, түүний үндэслэл, улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардал төлүүлэх, эд мөрийн баримтыг хэрхэх, шийдвэрийг давж заалдах журам, шийдвэр биелүүлэх арга, журам, хугацааг заана.

**98 дугаар зүйл.** Шүүх хуралдааны тэмдэглэл

1. Шүүх хуралдааны тэмдэглэлд хуралдааныг хэзээ, хаана хийсэн, эхэлсэн, дууссан цаг, шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, хэргийн ба шүүх хуралдааны оролцогчдын овог, нэр, хаяг, тэдний ирц болон тэдэнд эрх, үүргийг нь тайлбарласан байдал, хэргийн ба шүүх хуралдааны оролцогчдын тайлбар, мэдүүлэг, шинжээчийн тайлбар, нотлох баримтыг шинжлэн судалсан байдал, шүүх бүрэлдэхүүн болон иргэдийн төлөөлөгчөөс хэргийн талаар асууж тодруулсан байдал, прокурорын дүгнэлт, иргэдийн төлөөлөгчдийн дүгнэлт, шүүхийн шийдвэрийг сонсгосон байдал, шүүхийн шийдвэрийн агуулга, түүнд гомдол гаргах хугацаа, журмыг тайлбарласан байдлыг бичнэ.

2. Шүүх хуралдаан дууссан өдрөөс хойш 3 хоногийн дотор тэмдэглэлийг бэлэн болгоно. Тэмдэглэлд шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

**99 дүгээр зүйл.** Торгууль ногдуулах журам

1. Хуульд зааснаар торгууль ногдуулж болох зөрчлийг шүүх хуралдаан дээр гаргасан бол торгуулийг уг хэргийг хэлэлцэж буй шүүх тогтоол, шүүгч шийтгэвэр гарган ногдуулна.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд торгууль ногдуулах асуудлыг шүүгч торгууль хүлээвэл зохих этгээдийг дуудан ирүүлж шийдвэрлэнэ. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр түүний ирээгүй явдал шийдвэр гаргахад саад болохгүй.

# НАЙМДУГААР БҮЛЭГ

## Анхан шатны шүүх хуралдааны дэг

**1000 дугаар зүйл.** Шүүх хуралдааныг нээх

Шүүх хуралдаан даргалагч нь хуралдааныг нээж, ямар хэргийг хянан шийдвэрлэх гэж байгааг зарлан мэдээлж, танхимд байгаа хүмүүст суухыг зөвшөөрнө.

**1001 дүгээр зүйл.** Шүүх хуралдааны ирц ба эрхийг шалгах

1. Шүүх хуралдааны ирцийг нарийн бичгийн дарга бүртгэж, ирээгүй этгээдэд мэдэгдэх хуудсыг гардуулан өгсөн эсэх, ямар шалтгаанаар ирээгүй болохыг даргалагчид илтгэн танилцуулна.

2. Шүүх оролцогчидтой нэг бүрчлэн танилцаж, төлөөлөгчдийн бүрэн эрхийг шалгана.

**1002 дугаар зүйл.** Зохигч, оролцогчид шүүх хуралдаан ирээгүйгээс гарах холбогдол

1. Нэхэмжлэгч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч нь хүндэтгэн үзэх шалтгаанаар ирээгүй бол шүүх хуралдааныг шүүх тогтоол буюу шүүгч захирамж гарган хойшлуулна. Харин тэдгээр нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол нэхэмжлэлийг буцаана. Энэ тухай шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.

2. Хариуцагч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч ирээгүй бол түүнийг байлцуулахгүйгээр хэргийг шийдвэрлэнэ.

3. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаас бусад оролцогч шүүх хуралдаанд ирээгүй тохиолдолд хэрхэхийг шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч шийдвэрлэнэ.

4. Томилогдсон иргэдийн төлөөлөгч ирээгүй бол өөр иргэдийн төлөөлөгч томилж оролцуулна.

**1003 дугаар зүйл.** Орчуулагч (хэлмэрч)-ийн үүргийг тайлбарлах

Хуралдаан даргалагч орчуулагч (хэлмэрч)-д түүний үүрэг, буруу орчуулбал (хэлмэрчилбэл) хүлээлгэх хариуцлагыг сануулж, хуралдааны тэмдэглэлд гарын үсэг зуруулна.

**1004 дүгээр зүйл.** Гэрчийг гаргах

1. Шүүх хуралдаанд дуудагдсан гэрчийг хуралдааны танхимаас түр гаргана.

2. Гэрчүүдийг хооронд нь уулзаж харилцуулахгүй байлгах талаар хуралдаан даргалагч арга хэмжээ авна.

**105 дугаар зүйл** Шүүх бүрэлдэхүүнийг зарлах ба татгалзан гаргах эрхийг тайлбарлах

1. Хуралдаан даргалагч шүүх бүрэлдэхүүнийг зарлан, иргэдийн төлөөлөгч, прокурор, шинжээч, орчуулагч (хэлмэрч), шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг танилцуулж, тэдгээрийг татгалзан гаргах эрхтэйг зохигчид, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчид тайлбарлан өгнө.

2. Татгалзан гаргах хүсэлт гарвал түүнийг энэ хуулийн 93 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

**106 дугаар зүйл.** Хэргийн оролцогчдын эрх үүргийг тайлбарлах

Хуралдаан даргалагч хэргийн оролцогчдод тэдний эрх, үүргийг нь тайлбарлан өгнө.

**107 дугаар зүйл.** Хэргийн оролцогчдоос гаргасан хүсэлтийг шийдвэрлэх

Шинэ нотлох баримт бүрдүүлэх ба хэрэг хэлэлцэхтэй холбогдсон бусад асуудлын талаар хэргийн оролцогчдоос гаргасан хүсэлтийг бусад оролцогчдын саналыг сонсмогц шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч даруй шийдвэрлэнэ.

**108 дугаар зүйл.** Хэрэг хэлэлцэж эхлэх

1. Хэрэг хэлэлцэх ажиллагаа нь хуралдаан даргалагч буюу шүүгч хэргийн талаар танилцуулснаар эхэлнэ.

2. Нэхэмжлэгч нэхэмжлэлээ дэмжиж байгаа эсэх, хариуцагч нь нэхэмжлэгчийн шаардлагыг зөвшөөрч байгаа эсэх, зохигчид эвлэрэн хэлэлцэх хүсэлтэй байгаа эсэхийг хуралдаан даргалагч тодруулна.

**109 дүгээр зүйл.** Зохигчид эвлэрэн хэлэлцэх

Зохигчид эвлэрсэн, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэгчийн шаардлагыг зөвшөөрөн хүлээсэн нь бусдын эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хөндөөгүй; хуульд харшлахгүй бол шүүх зохигчдын эвлэрэл, хариуцагчийн зөвшөөрөл, нэхэмжлэгчийн татгалзалыг баталсан тогтоол буюу захирамж гаргаж хэргийг хэрэгсэхгүй болгоно.

**110 дугаар зүйл.** Зохигч, оролцогчид мэтгэлзэх

1. Нэхэмжлэгч, түүний талд оролцож буй гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь нэхэмжлэлийн шаардлага ба түүний үндэслэлээ гаргаж нотолно.

2. Хариуцагч, түүний талд оролцож буй гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь татгалзал, түүнийг үндэслэл ба нотлох баримтаа гаргаж мэтгэлзэнэ.

3. Бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй иргэн, хуулийн этгээд нь хариуцагчийн өмнө тайлбар гаргана.

4. Зохигч, оролцогчид нь харилцан асуулт тавьж болно.

5. Шүүх бүрэлдэхүүн, иргэдийн төлөөлөгч, прокурор нь хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр зохигч, оролцогчдод аль ч үед асуулт тавьж болно.

**111 дүгээр зүйл.** Нотлох баримтыг шинжлэх

Шүүх гэрч, шинжээчийг баййцаах, цугларсан бичмэл болон эд мөрийн баримтыг судлах, үзлэг явуулах болон бусад нотлох баримтыг шинжлэх дарааллыг тогтоож, эдгээр ажиллагааг энэ хуулийн 112, 113, 114 115 дугаар зүйлд заасан журмын дагуу явуулна.

**112 дугаар зүйл.** Гэрчийг байцаах

1. Хуралдаан даргалагч гэрчийг шүүх хуралдааны танхимд оруулж, түүний үүрэг, хүлээлгэх хариуцлагыг түүнд урьдчилан сануулж, энэ тухай хуралдааны тэмдэглэлд гарын үсэг зуруулна.

2. Гэрч бүрийг тус тусад нь асууна. Мэдүүлэг өгч дуусаагүй байгаа гэрч шүүх хуралдааны ажиллагаа явагдаж байх үед хуралдааны танхимд байж болохгүй. Хэрэв мэдүүлэг өгсөн гэрчийг грч явахыг хуралдаан даргалагч зөвшөөрөөгүй бол тэрээр шүүх хуралдаан дуустал танхимд байна.

3. Гэрч мэдүүлгээ өгсний дараа түүнд асуулт тавьж болно. Гэрчийг дуудаж асуухыг хүссэн этгээд тэргүүн ээлжинд, дараа нь хэргийн бусад оролцогч асуулт тавина. Харин шүүхийн санаачилгаар дуудсан гэрчид нэхэмжлэгч эхэлж асуулт тавина. Шүүх бүрэлдэхүүн, иргэдийн төлөөлөгч, прокурор нь гэрчийг мэдүүлэг өгч байх аль ч үед нь хуралдаан даргалагчийн зөшвөөрлөөр асуулт тавьж болно.

4. Насанд хүрээгүй гэрчийг байцаахдаа эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл сурган хүмүүжүүлэгчийг байлцуулна. Түүний мэдүүлгийг шүүх сонсохдоо үнэн зөв мэдүүлэг өгөхөд нь нөлөөлж болохоор оролцогчийг хуралдааны танхимаас түр гаргаж болно. Иймхүү гарсан эт-

гээд хуралдааны танхимд буцаж ороход насанд хүрээгүй гэрчийн мэдүүлгийг түүнд танилцуулж, асуулт тавих боломж олгоно. Насанд хүрээгүй гэрчийн мэдүүлгийг сонссоны дараа түүнийг хуралдааны танхимаас гаргана.

**113 дугаар зүйл.** Бичмэл болон эд мөрийн баримтыг шинжлэх

1. Шүүх хэрэгт цугларсан бичмэл болон эд мөрийн баримтыг судалж, шаардлагатай гэж үзсэн болон хэргийн оролцогч, иргэдийн төлөөлөгч, гэрч, шинжээчийн хүсэлтээр бичмэл нотлох баримтыг хуралдаанд уншиж сонсгон, эд мөрийн баримтыг танилцуулна.

2. Төр, байгууллага, хувь хүний нууц, нэр төр, алдар хүндийн асуудалтай холбогдсон зүйлийг хуралдаанд танилцуулахгүй. Захидал харилцааны нууцыг хамгаалахын тулд хувийн захидал бичгийг тухайн этгээдийн зөвшөөрөлтэйгээр нээлттэй шүүх хуралдаанд уншин сонсгож болно. Хэрэв зөвшөөрөл аваагүй бол хувийн захидал, бичгийг уншин сонсгох ба шинжлэх явдлыг хаалттай хуралдаанаар гүйцэтгэнэ.

3. Хэрэгт байгаа бичмэл баримт хуурамч болох нь мэдэгдвэл тийнхүү хуурамч болохыг мэдсэн этгээд уг баримтыг нотлох баримтаас хасахыг шүүхээс хүсэж болно. Бичмэл баримт хуурамч болох тухай мэдээллийг шалгахын тулд шүүх шинжилгээ хийлгэх буюу бусад нотлох баримт шаардан авч болно.

4. Бичмэл баримт хуурамч байсан нь тогтоогдвол шүүх түүнийг нотлох баримтаас хасч, буруутай этгээдэд энэ хуулийн 241 дүгээр зүйлд заасан хариуцлага хүлээлгэх буюу эсхүл холбогдох материалыг хэрэг бүртгэх байгууллагад харьяаллын дагуу шилжүүлнэ.

**114 дүгээр зүйл.** Шинжээчийн дүгнэлт сонсгох, шинжээчийг байцаах

1. Шинжээчийн дүгнэлтийг шүүх хуралдаанд уншиж сонсгоно.

2. Шинжээч шүүх хуралдаанд оролцож байгаа бол өөрийн дүгнэлтийг тайлбарлана. Дараа нь шинжээчид асуулт тавьж болно. Шинжээч томилуулахыг хүссэн этгээд тэргүүн ээлжинд, дараа нь хэргийн бусад оролцогч асуулт тавина. Харин шүүхийн санаачилгаар томилогдсон шинжээчид нэхэмжлэгч эхэлж асуулт тавина. Шүүх бүрэлдэхүүн, иргэдийн

төлөөлөгч, прокурор нь шинжээч дүгнэлтээ тайлбарлаж байх аль ч үед хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр асуулт тавьж болно.

3. Шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй, тодорхой бус буюу үндэсгүй гэж үзэж зөвшөөрөөгүй, эсхүл шинжээчид зөрүүтэй дүгнэлт гаргасан бол шүүх өөр шинжээчээр дахин шинжилгээ хийлгэж болно.

**115 дугаар зүйл.** Зохигчдоос нэмж тодруулах

Шотлох баримт шинжлэн судалсны дараа хуралдаан даргалагч нь нэмж тодруулах зүйл байгаа эсэхийг зохигч, гуравдагч этгээд тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчөөс асууна.

**116 дугаар зүйл.** Прокурор дүгнэлт гаргах

Прокурор маргааны үйл баримт, хууль хэрэглэх талаар дүгнэлтээ бичгээр гаргана. Гаргасан дүгнэлтийг шүүх хуралдаанд уншиж сонсгож, хэрэгт хавсаргана.

**117 дугаар зүйл.** Иргэдийн төлөөлөгч дүгнэлт гаргах

1. Иргэдийн төлөөлөгч нь маргааны үйл баримт, зохигчдын гэм буруугийн талаар гагцхүү хуульд нийцсэн дүгнэлтийг бичгээр гаргана. Эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас бичгээр гаргах боломжгүй бол энэ тухай хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлж, амаар дүгнэлт гаргаж болно.

2. Иргэдийн төлөөлөгч шаардлагатай гэж үзвэл дүгнэлтээ зөвлөлдөх тасалгаанд гаргана.

3. Иргэдийн төлөөлөгчид санал нэгдвэл хамтарсан, зөрвөл тус тусдаа дүгнэлт гаргана. Гаргасан дүгнэлтээ шүүх хуралдаанд уншин сонсгож, хэрэгт хавсаргана.

**118 дугаар зүйл.** Шүүх зөвлөлдөх тасалгаанд орох

Иргэдийн төлөөлөгч дүгнэлт гаргасны дараа даргалагч хуралдаан завсарласныг мэдэгдэж, шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч шийдвэрээ гаргахын тулд зөвлөлдөх тасалгаанд орно.

## ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

### Шүүхийн шийдвэр, түүнийг гаргах

**119 дүгээр зүйл.** Монгол Улсын нэрийн өмнөөс шийдвэр гаргах

1. Анхан шатны шүүхээс хэргийг хянан шийдвэрлэсэн гаргасан баримт бичгийг шийдвэр гэнэ.

2. Шүүх шийдвэрээ Монгол Улсын нэрийн өмнөөс гаргана.

3. Шүүхийн шийдвэр нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байна.

4. Шүүх шийдвэрээ гагцхүү хэрэгт байгаа бөгөөд шүүх хуралдаан дээр хэлэлцэгдсэн нотлох баримтын үндсэн дээр гаргана.

**120 дугаар зүйл.** Хэргийг хэрэгсэхгүй болгох

Энэ хуулийн 63 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 3, 4, 5, 6, 7, 8, 9-д заасан үндэслэл хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэх үед тогтоогдох буюу мөн хуулийн 67 дугаар зүйлд заасан нөхцөл байдал бий болбол хэргийг хэрэгсэхгүй болгоно. Энэ тухай шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.

**121 дүгээр зүйл.** Шүүхийн шийдвэр

Анхан шатны шүүх хэргийг хянан хэлэлцээд дараахь байдлаар шийдвэрлэж шийдвэр гаргана:

1) нэхэмжлэлийн шаардлагыг хангах;

2) нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангах, үлдсэнийг нь хэрэгсэхгүй болгох;

3) нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох.

**122 дугаар зүйл.** Шийдвэрийг уншиж сонгох, хуралдааныг хаах

1. Шүүх шийдвэрээ уншин сонгож, давж заалдах журам болон шаардлагатай бусад асуудлыг тайлбарлан өгч, хуралдаан хаасныг мэдэгдэнэ.

2. Шүүхийн шийдвэрт илт буруу зүйл бичигдсэн, эсхүл тооны алдаа байвал шүүх өөрийн санаачилгаар буюу хуралдаанд оролцогчийн хүсэлтээр шийдвэрийн утга агуулгыг өөрчлөхгүйгээр засварлаж болно.

3. Шүүх гаргасан шийдвэрээ хэргийн оролцогчдод уг шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор өгнө.

**123 дугаар зүйл.** Нэмэлт шийдвэр

1. Шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор шүүх өөрийн санаачилгаар буюу хэргийн оролцогчийн хүсэлтээр дараахь тохиолдолд дор дурдсан асуудлыг шүүх хуралдаанаар хэлэлцэн нэмэлт шийдвэр гаргаж болно:

1) нэхэмжлэлийн ямар нэг шаардлагын талаар шийдвэр гаргалгүй орхигдуулан;

2) эрх олгох тухай асуудлыг шийдвэрлэхдээ хариуцагчийн төлбөл зохих мөнгө, эд хөрөнгийн хэмжээ буюу хариуцагч нь ямар ажиллагаа гүйцэтгэхийг заагаагүй бол;

3) шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамж төлүүлэх асуудлыг шийдвэрлээгүй буюу буруу шийдвэрлэсэн, эсхүл эд мөрийн баримтыг хэрхэхийг заагаагүй бол;

4) шийдвэрийн ямар нэг заалт тодорхой бус байвал.

2. Шүүх хуралдаан хийх, нэмэлт шийдвэр гаргах, түүнийг давж заалдах, уг шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох асуудал энэ хуульд заасан зохих журмаар зохицуулагдана.

**124 дүгээр зүйл.** Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох

1. Шүүхийн шийдвэр дараахь тохиолдолд хуулийн хүчин төгөлдөр болно:

1) шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор түүнд давж заалдах гомдол, эсэргүүцэл гараагүй бол;

2) шийдвэрт давж заалдах гомдол, эсэргүүцэл гарсан бол уг шийдвэрийг хэвээр үлдээсэн буюу өөрчилсөн тухай шүүхийн магадлал гарсны дараа.

2. Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсны дараа зохигчид ба хэргийн бусад оролцогчид, түүнчлэн тэдгээрийн эрх залгамжлагчид нь шүүхээр нэгэнт шийдвэрлэгдсэн нэхэмжлэлийн шаардлагын тухайн үндэслэлээр дахин шүүхэд нэхэмжлэл гаргах буюу шүүхээс нэгэнт тогтоосон үйл баримт, эрх зүйн харилцааны талаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх өөр ажиллагаанд маргах эрхгүй.

**125 дугаар зүйл.** Шүүхийн шийдвэрийг биелүүлэх

1. Шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс нь эхлэн биелүүлнэ.

2. Шаардлагатай гэж үзвэл шүүх шийдвэрийг гарсан өдрөөс нь эхлэн (даруй) биелүүлэхээр тогтоож болно.

**126 дугаар зүйл.** Шийдвэр биелүүлэхийг хойшлуулах буюу хэсэгчлэн биелүүлэх, биелүүлэх арга журмыг өөрчлөх

Шүүх шийдвэр гаргасныхаа дараа шаардлагатай бол хэргийн оролцогчдын хүсэлтээр зохигчдын эд хөрөнгийн болон бусад байдлыг харгалзан шийдвэр биелүүлэхийг хойшлуулах, хэсэгчлэн биелүүлэхээр тогтоох буюу биелүүлэх арга,

журмыг өөрчлөх эрхтэй бөгөөд энэ асуудлаар шүүгч захирамж гаргана.

**127 дугаар зүйл.** Тогтмол хугацаанд төлөгдөх төлбөрийн тухай шийдвэрийг өөрчлөх

Хариуцагчаас тогтмол хугацаанд төлбөр гаргуулах тухай шийдвэр хүчин төгөлдөр болсны дараа уг төлбөрийн хэмжээ буюу төлөх хугацаанд нөлөөлөх байдал өөрчлөгдвөл зохигчид шинээр нэхэмжлэл гаргах замаар төлбөрийн хэмжээ ба хугацааг өөрчлөхийг шаардах эрхтэй.

**128 дугаар зүйл.** Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, тэдгээрийг гаргах

1. Хэрэг хянан шийдвэрлэж энэ хуулийн 119 дүгээр зүйлд зааснаар шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах, хэргийг хэрэгсэхгүй болгох, шийдвэр биелүүлэхтэй холбогдуулан шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.

2. Тогтоолыг 3 шүүгчийн бүрэлдэхүүнээр хэрэг хянан шийдвэрлэж байгаа үед; захирамжийг шүүгчийг дангаар хэрэг хянан шийдвэрлэж байгаа үед буюу шүүх хуралдааны бус үед гаргана.

3. Шүүх хуралдааныг хойшлуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх, шинэчлэн явуулах, татгалзан гаргах тухай хүсэлтийг шийдвэрлэх, шийдвэр биелүүлэхтэй холбогдсон болон шүүх хуралдааны бус үед шийдвэрлэж буй асуудлаар шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг бичгээр гаргана. Бусад асуудлаар шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг шүүх хуралдааны тэмдэглэлд тусгах замаар амаар гаргаж болно.

**129 дүгээр зүйл.** Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хүчингүй болгох буюу өөрчлөх

Энэ хуулийн 128 дугаар зүйлд заасны дагуу бичгээр гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хэргийн байдал өөрчлөгдсөнтэй холбогдуулан тухайн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар хүчингүй болгох буюу өөрчилж болно.

## АРАВДУГААР БҮЛЭГ

### Гэрлэлт цуцлах тухай хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа

**130 дугаар зүйл.** Гэрлэлт цуцлах тухай хэргийг хэлэлцэх

Шүүх гэрлэлт цуцлах тухай хэргийг энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуульд заасан ерөнхий журмын дагуу хэлэлцэнэ.

**131 дүгээр зүйл.** Гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэл

1. Гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа газрын шүүхэд гаргана.

2. Хариуцагчийн оршин суугаа газар тодорхойгүй, эсхүл нэхэмжлэгч бага насны хүүхэдтэй буюу тахир дутуу, бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хариуцагчийн байгаа газар очиход бэрхшээлтэй байвал нэхэмжлэлийг өөрийн оршин суугаа газрын шүүхэд гаргаж болно.

3. Зохигчид хэргийг хэний оршин суугаа газрын шүүхэд хэлэлцүүлэхийг тохиролцон тогтоож болно.

4. Гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлд гэрлэгчдийн овог, нэр, гэрлэлтээ хэзээ, хаана бүртгүүлсэн, гэрлэлт цуцлуулах шалтгаан, хүүхэдтэй бол түүний овог, нэр, төрсөн он, сар, өдөр, түүнчлэн хүүхдээ хүмүүжүүлэх талаар хоорондоо хэлэлцэн тохирсон зүйл бий эсэхийг зааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана.

**132 дугаар зүйл.** Тэтгэвэр гаргуулах ба эд хөрөнгө хуваах

Гэрлэгчдийн дундын эд хөрөнгийг хуваах, туслалцаа шаардагдаж байгаа хөдөлмөрийн чадваргүй эхнэр буюу нөхөрт тэтгэвэр олгуулах тухай асуудлыг шүүх гэрлэлт цуцлах нэхэмжлэлтэй хамт шийдвэрлэж болно.

**133 дугаар зүйл.** Гэрлэгчид шүүх хуралдаанд ирэх

1. Зохигчдын төлөөлөгч буюу өмгөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа ч гэсэн гэрлэгчид өөрсдөө шүүх хуралдаанд ирэх үүрэгтэй.

2. Гэрлэгчдийн аль нэг нь хүндэтгэн үзэх шалтгаанаар ирээгүй бол шүүх хуралдааныг хойшлуулна.

3. Гэрлэгчид нь хоёр дахь удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол хэргийг хариуцагчийн байхгүйд хэлэлцэж болно. Харин нэхэмжлэгч ирээгүй тохиолдолд нэхэмжлэлийг буцаана.

4. Хүндэтгэн үзэх шалтгаанаар өөрийгөө байхгүйд хэрэг хэлэлцэхийг хүссэн нэхэмжлэгчийг шүүх хуралдаанд ирэхээс шүүгчийн захирамжаар чөлөөлж болно.

**134 дүгээр зүйл.** Гэрлэлт цуцлах тухай хэргийг шийдвэрлэх

1. Шүүх хэргийг шүүх хуралдаанд бэлтгэх болон шүүх хуралдаанаар хянан хэлэлцэх явцад гэрлэлт цуцлах болсон шалтгааныг тогтоох ба гэрлэгчдийг эвлэрүүлэх арга хэмжээ авч болно.

2. Гэрлэгчид эвлэрвэл шүүх буюу шүүгч эвлэрлийг баталсан тогтоол буюу захирамж гаргаж хэргийг хэрэгсэхгүй болгоно.

3. Гэрлэгчид эвлэрээгүй бол шүүх гэрлэлтийг цуцлах тухай буюу гэрлэлт цуцлахыг татгалзсан шийдвэр гаргана. Шүүх гэрлэлт цуцлах тухай шийдвэр гаргахдаа хүүхдийг цаашид хүмүүжүүлэх талаар гэрлэгчдийн хооронд хэлэлцэн тохирсон зүйл байхгүй бол хүүхдийг эцэг буюу эхийн хэний нь асрамжид үлдээхийг тогтоож, хүүхдийн тэтгэлэг гаргуулах асуудлыг нэхэмжлэлийг үндэслэн шийдвэрлэнэ. Хуульд заасан бол гэрлэлт цуцлахыг бүртгэхэд хураах улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг шүүх тодорхойлж, түүнийг гэрлэгчдийн хэн нь, ямар хэмжээгэр төлбөл зохихыг тогтооно.

**135 дугаар зүйл.** Гэрлэгчдийн харилцан зөвшөөрснөөр гэрлэлтийг цуцлах

Гэрлэгчид нь гэрлэлтээ цуцлуулах тухайгаа харилцан зөвшөөрөлцсөн бөгөөд 18-аас доош насны хүүхэдгүй бол шүүх эвлэрүүлэх арга хэмжээ авалгүйгээр гэрлэлтийг цуцалж болно.

## АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### Хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаа

**136 дугаар зүйл.** Онцгой ажиллагааны журмаар хэлэлцэх хэргүүд

Шүүх дараахь хэргүүдийг онцгой ажиллагааны журмаар хэлэлцэнэ:

1) эрх зүйн ач холбогдох бүхий үйл явдлыг тогтоох тухай;

2) хүнийг сураггүй алга болсонд тооцох тухай нас барсан гэж зарлах тухай;

3) сэтгэцийн өвчний улмаас хүнийг эрх зүйн чадамжгүй гэж тооцох тухай;

4) эрх олгосон бичиг баримтыг үрэгдүүлснээс алдагдсан эрхийг сэргээх тухай;

5) иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд буруу бичигдсэнийг тогтоох тухай;

6- хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх тухай;

7) аж ахуйн нэгжийг дампуурсанд тооцох, ноёрхогч болохыг тогтоох болон эдгээртэй адил төрлийн бусад үйл явдлыг тогтоох тухай.

**137 дугаар зүйл.** Онцгой ажиллагааны журмаар хэрэг хэлэлцэх

1. Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэргийг шүүх энэ бүлэг өөрөөр заагаагүй бол энэ хуулиар тогтоосон ерөнхий журмын дагуу хэлэлцэнэ.

2. Энэ хуулийн 136 дугаар зүйлд заасан хэргийг шүүх хүсэлт гаргасан этгээд болон холбогдох хуулийн этгээд, иргэнд мэдэгдэж хэлэлцэнэ.

**138 дугаар зүйл.** Эрх зүйн ач холбогдол бүхий баримтыг шүүх тогтоовол зохих үйл явдал

1. Иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгийн болон амины эрх үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болоход хамаарагдах дараахь үйл явдлыг шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар тогтооно:

1) садан төрлийн холбоо;

2) бусдын асрамжинд байгаа эсэх;

3) төрөлт, үрчлэлт, гэрлэлт, гэрлэлт цуцлалт, нас баралтыг бүртгүүлсэн байдал;

4) эрх олгосон ямар нэгэн барим бичиг (иргэний паспорт, гэр бүлийн байдлыг бүртгэх байгууллагаас олгосон гэрчилгээнээс бусад)-т дурдсан овог, нэр, төрсөн он, сар, өдөр нь паспорт, төрөлтийн тухай гэрчилгээнд бичигдсэнтэй тохирохгүй байвал түүний жинхэнэ эзэмшигч нь мөн эсэх;

5) осол гэмтэл гарсан эсэх;

6) хүний ажиллаж байсан байдал;

7) тогтоох журмыг нь хуульд заагаагүй эрх зүйн ач холбогдол бүхий бусад үйл явдал.

2. Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоолгох тухай хүсэлт гаргагч гагцхүү уг үйл явдлыг батлах бичиг баримтыг өөр журмаар олж авах боломжгүй буюу үрэгдсэн бичиг баримтыг сэргээх боломжгүй бол шүүх түүнийг тогтооно.

**139 дүгээр зүйл.** Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоолгох тухай хүсэлт гаргах

1. Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоолгох тухай хүсэлтийг тухайн үйл явдал болсон газрын шүүхэд гаргана.

2. Хүсэлтэд уг үйл явдлыг тогтоолгох гэж байгаа зорилгыг зааж уг үйл явдлыг тогтооход ач холбогдол бүхий баримт, баримт бичгийг олж авах буюу үрэгдсэн баримт бичгийг сэргээх боломжгүй болсныг нотлох баримтыг хавсаргана.

**140 дүгээр зүйл.** Хүнийг сураггүй алга болсонд тооцуулах буюу нас барсан гэж зарлуулах тухай хүсэлт гаргах

1. Хүнийг сураггүй алга болсонд тооцуулах буюу нас барсан гэж зарлуулах тухай хүсэлтийг уг хүний сүүлчийн оршин сууж байсан газрын шүүхэд, хэрэв сүүлчийн оршин сууж байсан газар нь мэдэгдэхгүй бол сүүлчийн ажиллаж байсан газрын харьяалах шүүхэд гаргана.

2. Сураггүй алга болсонд тооцуулах буюу нас барсан гэж зарлуулахыг хүсэж байгаа зорилго, түүнчлэн иргэний сураггүй болсныг батлах байдал, эсхүл түүний нас барсан буюу амь үрэгдсэн гэж үзэх үндэслэлээ хүсэлтэд зааж, түүнийг нотлох баримтыг хавсаргана.

**141 дүгээр зүйл.** Хүнийг сураггүй алга болсонд тооцуулах буюу нас барсан гэж залруулах тухай хүсэлт хүлээн авсан шүүгчийн ажиллагаа

1. Хүсэлт хүлээн авсан шүүх алга болсон хүний талаар мэдээ өгч чадах ямар хүмүүс (төрөл садан, хамт ажиллаж, сурч байсан хүн) байгааг тодруулж, алга болсон хүний талаар түүний сүүлчийн оршин сууж байсан буюу ажиллаж байсан газрын зохих байгууллагад ямар мэдээ байгааг лавлана.

2. Шүүх шаардлагатай гэж үзвэл цагдаагийн байгууллагаар дамжуулан уг хүнийг эрэн сурвалжлах арга хэмжээ авахуулах бөгөөд түүний эд хөрөнгөд хамгаалалт тогтоохыг зохих байгууллага, албан тушаалтанд даалгаж болно.

**142 дугаар зүйл.** Хүнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах тухай хэргийг хэлэлцэх

1. Хүнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах тухай хэргийг шүүх хэлэлцэхдээ хүсэлт гаргасан этгээдийг оролцуулна.

2. Хүнийг сураггүй алга болсонд тооцсон шүүхийн шийдвэр хүүлийн хүчин төгөлдөр болсны дараа түүний эд хөрөнгөд хамгаалалт тогтоолгохын тулд уг шийдвэрийг эд хөрөнгө байгаа газрын асран хамгаалах байгууллагад явуулна.

3. Хүнийг нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэр хүүлийн хүчин төгөлдөр болсны дараа иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд зохих тэмдэглэл хийлгэх буюу түүний эд хөрөнгөд хамгаалалт тогтоолгохын тулд шийдвэр гаргасан шүүх байгаа газрын иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх болон асран хамгаалах байгууллагад уг шийдвэрийг явуулна.

**143 дугаар зүйл.** Хүнийг сураггүй алга болсонд тооцсон буюу нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох

1. Сураггүй алга болсонд тооцогдсон буюу нас барсан гэж зарлагдсан хүн хүрэлцэн ирэх буюу байгаа газар нь мэдэгдвэл тухайн шүүх шинээр шийдвэр гаргаж урьд гаргасан шийдвэрийг хүчингүй болгоно.

1. Шинэ шийдвэр хүүлийн хүчин төгөлдөр болсны дараа уг хүний эд хөрөнгөд тогтоосон хамгаалалтыг өөрчлөх буюу иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд тэмдэглэсэн зүйлийг хүчингүй болгуулахын тулд уг шийдвэрийг зохих байгууллагад явуулна.

**144 дүгээр зүйл.** Хүнийг эрх зүйн чадамжгүй гэж тооцох тухай хүсэлт гаргах

1. Сэтгэцийн өвчний улмаас хүнийг эрх зүйн чадамжгүй гэж тооцуулах тухай хүсэлтийг уг хүний гэр бүлийн гишүүн ба сонирхогч бусад этгээд (сонгуулийн хороо, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг дарга), асран хамгаалах байгууллага, эрүүл мэндийн байгууллага шүүхэд гаргана.

2. Хүсэлтийг уг хүний оршин суугаа буюу эмчлүүлж байгаа газрын шүүхэд гаргана.

3. Хүсэлтэд сэтгэцийн өвчний улмаас уг хүн өөрийн үйл ажиллагааны учир холбогдлыг ойлгох буюу өөрийгөө зөв

удирдаж чадахгүй байгаа байдлыг тодорхой дурдаж, холбогдох нотлох баримтыг хавсаргана.

**145 дугаар зүйл.** Хүнийг эрх зүйн чадамжгүй гэж тооцох тухай хэргийг хэлэлцэх

1. Хүсэлт хүлээн авсан шүүх нь шүүх-сэтгэц гэм судлалын шинжээч томилон, шинжилгээ хийлгэж, тухайн хүний сэтгэцийн байдал, өөрийн үйл ажиллагааны учир холбогдлыг ойлгох, өөрийгөө зөв удирдаж чадах эсэх талаар дүгнэлт гаргуулна.

2. Шинжилгээ хийлгэхээс зайлсхийсэн этгээдэд шүүгчийн захирамжийн дагуу албадан шинжилгээ хийлгэж болно.

3. Хэргийг шүүх хэлэлцэхдээ асран хамгаалах байгууллагын төлөөлөгчийг оролцуулах бөгөөд тухайн хүний эрүүл мэндийн байдал нь боломжтой бол ирүүлнэ.

**146 дугаар зүйл.** Хүнийг эрх зүйн чадамжгүй гэж тооцох тухай шүүхийн шийдвэр

1. Шүүх шинжээчийн дүгнэлт, бусад нөхцөл байдлыг үндэслэн тухайн хүн эрх зүйн чадамжтай эсэхийг тогтоож шийдвэр гаргана.

2. Хүнийг эрх зүйн чадамжгүй гэж тооцсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсны дараа уг хүнд асран хамгаалалт тогтоолгохын тулд зохих байгууллага болон хүсэлт гаргасан этгээдэд уг шийдвэрийг явуулна.

3. Эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон хүн эдгэрэх буюу эрүүл мэнд нь мэдэгдэхүйц сайжирвал уг хүн, түүний асран хамгаалагч, түүнчлэн энэ хуулийн 144 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээдийн хүсэлтийн дагуу шүүх шүүх-сэтгэц гэм судлалын шинжээчийн дүгнэлтийг үндэслэн уг хүнийг эрх зүйн бүрэн чадамжтай болсон тухай шийдвэр гаргаж болно.

4. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсны дараа уг хүнд тогтоосон асран хамгаалалтыг хүчингүй болгуулахын тулд уг шийдвэрийг зохих байгууллагад явуулна.

**147 дугаар зүйл.** Хүнийг эрх зүйн чадамжгүй гэж тооцох тухай хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны шүүхийн зардал

1. Хүнийг сэтгэцийн өвчний улмаас эрх зүйн чадамжгүй гэж тооцох тухай хэргийг хянан шийдвэрлэхтэй холбогдон гарах шүүхийн зардлыг төр хариуцна.

2. Сэтгэцийн талаар эрүүл гэдгийг мэдсээр байж хүний эрх зүйн чадамжийг хасуулахын тулд энэ хуулийн 144 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүсэлт гаргасан нь тогтоогдвол шүүхийн бүх зардлыг бурууталй этгээдээс гаргуулна.

**148 дугаар зүйл.** Үрэгдсэн бичиг баримтыг устгагдсанд тооцуулснаас алдагдсан эрхийг сэргээн тогтоолгох тухай хүсэлт гаргах

1. Эд хөрөнгийн болон амины эрх олгогдсон бичиг баримтыг үрэгдүүлж устгагдсанд тооцуулсан тохиолдолд уг бичиг баримтыг эзэмших эрхийн талаар маргаан гарвал тухайн эрхийг сэргээн тогтоолгох тухай хүсэлтийг хуульд өөрөөр заагаагүй бол шүүхэд гаргана.

2. Хүсэлтийг уул бичиг баримтыг олгосон байгууллагын оршин байгаа газрын шүүхэд гаргана.

3. Хүсэлтэд уг бичиг баримтыг эзэмшиж байсан этгээд ямар эрхтэй болох тухайгаа үндэслэж, түүнийг нотлох баримтыг хавсаргана.

4. Хүсэлт гаргасан этгээд бичиг баримт эзэмшиж байгаа этгээдэд холбогдуулан энэ хуульд заасан ердийн журмаар нэхэмжлэл гаргах эрхтэйг шүүгч тайлбарлаж өгнө.

**149 дүгээр зүйл.** Үрэгдсэн бичиг баримтыг устгагдсанд тооцуулснаас алдагдсан эрхийг сэргээн тогтоолгох тухай хэргийг хэлэлцэх

1. Үрэгдсэн бичиг баримтыг устгагдсанд тооцуулснаас алдагдсан эрхийг сэргээн тогтоох тухай хэргийг шүүх хэлэлцэхдээ хүсэлт гаргасан этгээдийг оролцуулна.

2. Шүүх хүсэлтийг хангавал үрэгдсэн бичиг баримтын оронд дахин шинийг олгохыг уг бичиг баримтыг олгосон байгууллагад үүрэг болгосон шийдвэр гаргана.

**150 дугаар зүйл.** Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд буруу бичигдсэнийг тогтоолгох тухай хүсэлт гаргах

1. Эрхийн тухай маргаан байхгүй байхад иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх байгууллага өөрийн бүртгэлд залруулга хийхээс татгалзсан тохиолдолд иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд буруу бичигдсэнийг тогтоолгох тухай хүсэлтийг шүүхэд гаргана.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүсэлтийг түүнийг гаргагч өөрийн оршин суугаа газрын шүүхэд гаргана.

3. Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд ямар зүйл буруу бичигдсэн, уг асуудлыг эрхлэх ямар байгууллага залруулга хийхээс хэдийн татгалзсаныг бичиж, холбогдох нотлох баримтыг хавсаргана.

**151 дүгээр зүйл.** Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд буруу бичигдсэнийг тогтоох тухай хэргийг хянан шийдвэрлэх

1. Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд буруу бичигдсэнийг тогтоох тухай хэргийг шүүх хүсэлт гаргагчид мэдэгдэж хэлэлцэнэ.

2. Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд буруу бичигдсэнийг тогтоосон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсны дараа бүртгэлд зохих залруулга хийлгэхийн тулд иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх байгууллагад уг шийдвэрийг явуулна.

**152 дугаар зүйл.** Хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх

Хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн материал үрэгдсэн байвал хэргийн оролцогчдын хүсэлт, түүнчлэн шүүхийн санаачилгаар түүнийг бүрэн буюу зарим хэсгийг нь сэргээж болно.

**153 дугаар зүйл.** Хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх тухай хүсэлт гаргах

1. Хэргийн материалыг сэргээх тухай хүсэлтийг уг хэргийг хэлэлцсэн шүүхэд, шийдвэр гүйцэтгэлийн материалыг сэргээх тухай хүсэлтийг уг шийдвэрийг гүйцэтгэвэл зохих газрын шүүхэд гаргана.

2. Хүсэлтэд хэрэг буюу шийдвэр гүйцэтгэлийн материалын талаар тодорхой дурдаж, тэдгээртэй холбогдолтой бичиг баримт буюу түүний хуулбарыг хавсаргана.

**154 дүгээр зүйл.** Хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх тухай хэргийг хэлэлцэх

1. Хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх тухай хэргийг шүүх хэлэлцэхдээ үрэгдсэн хэрэг, шийдвэр гүйцэтгэлийн материалаас үлдсэн болон үрэгдэхийн өмнө иргэн, хуулийн этгээдэд олгосон бичиг баримт, түүний хуулбар, ач холбогдол бүхий бусад баримт сэлтийг ашиг-

лана). Хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх тухай хэргийг шийдвэрлэх шүүх уг хэргийн оролцогчид, шаардлагатай бол хэргийг урьд хянан шийдвэрлэсэн шүүх бүрэлдэхүүн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэсэн этгээдийг гэрчийн хувиар байцааж болно.

2. Хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх талаар цугларсан нотлох баримт хангалтгүй байвал энэ тухай хүсэлтийг шүүхийн тогтоол буюу шүүгчийн захирамжаар хэрэгсэхгүй болгоно. Ийнхүү хэрэгсэхгүй болгосон бол сонирхогч этгээд энэ хуульд заасан ердийн журмаар нэхэмжлэл гаргах эрхтэй.

**155 дугаар зүйл.** Хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээхтэй холбогдсон зардал

1. Иргэний хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх тухай хэргийг хянан шийдвэрлэхтэй холбогдон гарах зардлыг төр хариушна.

2. Энэ хуулийн 153 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүсэлтийг зориуд худал гаргасан нь тогтоогдвол шүүхийн бүх зардлыг буруутай этгээдээс гаргуулна.

**156 дугаар зүйл.** Аж ахуйн нэгжийг дампуурсанд тооцуулах тухай хүсэлт гаргах

1. Аж ахуйн нэгжийг дампуурсанд тооцуулах тухай хүсэлтийг тухайн аж ахуйн нэгжийн оршин байгаа газрын шүүхэд гаргана.

2. Хүсэлтэд тухайн аж ахуйн нэгж төлбөрийн чадваргүй болсон буюу төлбөрийн чадваргүйн улмаас үүргээ биелүүлэхгүй байна гэж үзсэн үндэслэл, түүний хүлээсэн төлбөр, тоцооны үүрэг, үүргийг биелүүлэх болон биелүүлээгүй хэтрүүлсэн хугацаа зэргийг зааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана.

**157 дугаар зүйл.** Аж ахуйн нэгжийг дампуурсанд тооцуулах тухай хүсэлт хүлээн авсан шүүгчийн ажиллагаа

1. Аж ахуйн нэгжийг дампуурсанд тооцуулах тухай хүсэлт хүлээн авсан шүүгч хэрэг үүсгэж, энэ тухайгаа 10 хоногийн дотор хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлаж мэдээлнэ.

2. Аж ахуйн нэгж хариуцагч талын нэхэмжлэлийн шаардлагыг жангах баталгаа гаргасан буюу сонирхогч этгээд хүсэлт

гаргаж харилцагч талууд зөвшөөрсөн тохиолдолд шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан хугацаагаар түдгэлзүүлж болно.

**158 дугаар зүйл.** Аж ахуйн нэгжийг дампуурсанд тооцох тухай хэргийг хэлэлцэх

1. Аж ахуйн нэгжийг дампуурсанд тооцох тухай хэргийг хэлэлцэхдээ шүүх тухайн аж ахуйн нэгжийн болон харилцагч талуудын төлөөлөгчид мэдэгдэнэ.

2. Шүүх аж ахуйн нэгжийг дампуурсанд тооцох тухай шийдвэр гаргасан бол нэхэмжлэгчдийн хурал хийх газар, хугацааг тогтоож, нийтэд зарлана.

**159 дүгээр зүйл.** Нэхэмжлэгчдийн хурлыг зохион байгуулж, хэрэг гүйцэтгэгчийг томилох

Аж ахуйн нэгжийг дампуурсанд тооцох тухай шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсны дараа шүүх нэхэмжлэгчдийн хурлыг зохион байгуулж, аж ахуйн нэгжийг татан буулгах ажлыг эрхлэх үүрэг бүхий хэрэг гүйцэтгэгчийг нэхэмжлэгчдийн хурлаас гаргасан саналыг үндэслэн шүүгчийн захирамжаар томилно.

**160 дугаар зүйл.** Аж ахуйн нэгжийг дангаар болон зүй ёсны дангаар ноёрхогч, эсхүл давамгайлах байдалтай буюу энэ байдлаа алдсаныг тогтоох

1. Аж ахуйн нэгжийг дангаар болон зүй ёсны дангаар ноёрхогч, эсхүл давамгайлах байдалтай буюу энэ байдлаа алдсаныг тогтоолгох тухай хүсэлтийг хуулиар эрх олгогдсон хуулийн этгээд тухайн аж ахуйн нэгжийн оршин байгаа газрын шүүхэд гаргана.

2. Аж ахуйн нэгжийг дангаар болон зүй ёсны дангаар ноёрхогч, эсхүл давамгайлах байдалтай буюу энэ байдлаа алдсаныг тогтоох тухай хэргийг хэлэлцэхдээ шүүх хүсэлт гаргагч болон тухайн аж ахуйн нэгжид мэдэгдэнэ. Шүүх хуралдаанд тэдний ирээгүй явдал хэрэг хэлэлцэхэд саад болохгүй.

3. Шүүх эрх бүхий байгууллагаас гаргаж өгсөн бичиг баримт болон бусад нотлох баримтыг үндэслэн аж ахуйн нэгжийг дангаар болон зүй ёсны дангаар ноёрхогч, эсхүл давамгайлах байдалтай буюу энэ байдлаа алдсан эсэхийг тогтоож, энэ тухай шийдвэрээ нийтэд зарлан мэдээлнэ.

# АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ

## Гомдлоор авч хэлэлцэх хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа

**161 дүгээр зүйл.** Шүүх гомдлоор авч хэлэлцэх хэрэг

1. Шүүх дараахь хэргийг гомдлоор авч хэлэлцэнэ.

1) төрийн захиргаа, шүүх, прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаанд хуульд заасныг дагуу гаргасан гомдол;

2) шүүх шийдвэрлэхээр хуульд заасан бусад гомдол.

2. Гомдлоор авч хэлэлцэх хэргийг шүүх энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуулиар тогтоосон ерөнхий журмын дагуу хэлэлцэнэ.

**162 дугаар зүйл.** Гомдол гаргах

1. Энэ хуулийн 161 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гомдлыг хуулиар өөр харьяалал тогтоогоогүй бол шийдвэр гаргасан буюу үйл ажиллагаа явуулсан байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн албан тушаалтны оршин байгаа газрын шүүхэд гаргана.

2. Гомдолд ямар байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргаж байгаа, тухайн шийдвэр, үйл ажиллагаа ямар хууль тогтоомжид харшилж байгаа, түүнийг хууль бус гэж үзсэн үндэслэл, нотолгоог заана.

3. Гомдлыг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлүүлэхээр хуульд заасан бол уг шаардлагыг хангасан нөхцөлд шүүх түүнийг хүлээн авч хэлэлцэнэ.

**163 дугаар зүйл.** Гомдлыг хянан хэлэлцэх

1. Гомдлоор хэрэг хянан хэлэлцэхдээ шүүх гомдол гаргагч болон холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөгчийг оролцуулна.

2. Гомдол гаргагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй бол гомдлыг буцаах тухай шүүгчийн захирамж гаргана. Шүүх хуралдаанд байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөгч ирээгүй явдал хэргийг хэлэлцэхэд саад болохгүй.

3. Гомдол гаргагч нь гомдол, түүний хууль зүйн үндэслэл, нотолгоог гаргах; байгууллага, аж ахуйн нэгжийн төлөө-

лөөлөгч нь гомдлыг зөвшөөрч байгаа эсэх, хэрэв зөвшөөрөхгүй байвал татгалзал, түүний хууль зүйн үндэслэлээ нотлох үүрэгтэй.

4. Шүүх нь байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа хуульд нийцэж буй эсэх, шийдвэрийг зохих эрх бүхий этгээд гаргасан эсэх, гомдол үндэслэлтэй эсэхийг тогтоно.

**164 дүгээр зүйл.** Шүүхийн шийдвэр

Шүүх гомдлыг хянан хэлэлцээд дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

1) хуульд заасан тохиолдолд байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааг хүчингүй болгох, эсхүл тодорхой үйл ажиллагаа явуулахыг үүрэг болгох, шийдвэр, үйл ажиллагаанаас учирсан хохирлыг гомдол гаргагчид нөхөн олгох;

2) гомдлыг хэрэгсэхгүй болгох.

## АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ

## Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

**165 дугаар зүйл.** Давж заалдах гомдол, эсэргүүцэл бичих

1. Анхан шатны журмаар хэрэг хянан хэлэлцээд гаргасан шүүхийн шийдвэрт гарсан өдрөөс нь хойш 30 хоногийн дотор зохигчид, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд, иргэдийн төлөөлөгч давж заалдах гомдол гаргах, шүүх хуралдаанд оролцсон прокурор эсэргүүцэл бичих эрхтэй.

2. Давж заалдах гомдол, эсэргүүцлийг сум болон сум дундын, дүүргийн шүүхийн шийдвэрийн талаар зохих аймаг, нийслэлийн шүүхийн болон Улсын дээд шүүхийн шийдвэрийн талаар Улсын дээд шүүхэд тухайн шийдвэр гаргасан шүүхээр дамжуулан гаргана.

**166 дугаар зүйл.** Давж заалдах гомдол, эсэргүүцлийн агуулга

1. Давж заалдах гомдол, эсэргүүцэлд дараахь зүйлийг заана:

1) гомдол, эсэргүүцлийг ямар шүүхэд гаргаж байгаа;

2) гомдол, эсэргүүцэл бичиж буй этгээдийн нэр, хаяг, эсхүл албан тушаал;

3) аль шүүхийн, ямар шийдвэрийг давж заалдаж байгаа;

4) шийдвэрийн чухам ямар заалтыг зөвшөөрөхгүй байгаа үүний үндэслэл;

5) гомдол, эсэргүүцэл бичиж буй этгээдийн хүсэлт;

6) хавсаргасан бичиг баримтын жагсаалт.

2. Давж заалдах гомдол, эсэргүүцэлд түүнийг гаргасан этгээд гарын үсгээ зурна.

3. Давж заалдах гомдол, эсэргүүцлийн үндэслэлд анхан шатны шүүхээр хянан хэлэлцээгүй шинэ нотлох баримт заах эрхгүй.

**167 дугаар зүйл.** Давж заалдах гомдол, эсэргүүцэлд тайлбар өгөх

1. Давж заалдах гомдол, эсэргүүцлийг хэргийг шийдвэрлэсэн шүүгч буюу шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хүлээн авч зохигчид, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, шаардлагатай бол гуравдагч этгээдэд танилцуулна.

2. Зохигчид, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд нь гомдол, эсэргүүцлийн талаар өөрийн тайлбарыг гаргах эрхтэй.

**168 дугаар зүйл.** Давж заалдах гомдол, эсэргүүцлээс татгалзах

1. Давж заалдах гомдол, эсэргүүцэл гаргасан этгээд шүүх хуралдаанаас өмнө гомдол, эсэргүүцлээсээ татгалзвал шүүх түүнийг гомдол, эсэргүүцэл гаргаагүйд тооцно.

2. Давж заалдах гомдол, эсэргүүцэл гаргасан этгээд гомдол, эсэргүүцлээсээ татгалзсан нь бусдын эрх, эрх чөлөө, хууль ёс ажиллагааны улмаас хийгдсэн тухай нотлох баримт илэрхийлэн тохиолдолд энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт хамаарахгүй бөгөөд хэргийг ерднийн журмаар хянан хэлэлцэнэ.

**169 дүгээр зүйл.** Хуралдаанд биеэр оролцох

1. Зохигчид, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд, прокурор, гомдол гаргасан иргэдийн төлөөлөгч давж заалдах хуралдаанд оролцохыг хүсвэл шүүх тэдгээрт хуралдаанд биеэр оролцох эрхийг нь хангах, хуралдаан эзээ, хаана болохыг мэдэгдэх үүрэгтэй.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээд шүүх хуралдаанд ирээгүй явдал хэргийг хэлэлцэхэд саад болохгүй.

**170 дугаар зүйл.** Хэргийг хянан хэлэлцэх

1. Шүүх давж заалдах гомдол, эсэргүүцэлтэй хэргийг 30 хоногт багтаан хянан хэлэлцэнэ.

2. Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч буюу түүний томилсон шүүгч даргална.

3. Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдол, эсэргүүцэлд дурдсан үндсээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзэх үүрэгтэй.

4. Шүүх хуралдаанд хэргийг нэг шүүгч нь илтгэн танилцуулна. Дараа нь нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд харилцан асуулт тавих, прокурор, иргэдийн төлөөлөгч хүсвэл тайлбар гаргаж болох ба хэргийн материалыг судалснаар хуралдааныг завсарлан, шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөнө.

**171 дүгээр зүйл.** Шүүхийн магадлал

1. Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүх дараахь байдлаар шийдвэрлэж, магадлал гаргана:

1) анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, давж заалдах гомдол, эсэргүүцлийг хангахгүй орхих;

2) анхан шатны шүүхийн шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах;

3) анхан шатны шүүхийн шийдвэрийн зарим хэсгийг хүчингүй болгож, бусад хэсгийг хэвээр үлдээх буюу өөрчлөх;

4) анхан шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох, хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаах.

2. Магадлалд анхан шатны шүүхийн шийдвэрийг тогтоох хэсгийн агуулга, давж заалдах гомдол буюу эсэргүүцлийн товч агуулга, гаргаж буй шийдвэр, түүний үндэслэлийг тусгана.

3. Магадлал нь уншиж сонсгомогц хуулийн хүчин төгөлдөр болно.

**172 дугаар зүйл.** Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох

1. Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг дараахь үндэслэлээр хүчингүй болгоно:

1) шүүх буруу хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй;

2) зохигчид, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн шүүх хуралдаанд биеэр оролцох эрхийг хангалгүй хэргийг шийдвэрлэсэн;

3) хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчдын бусад эрх ноцтой зөрчигдсөн;

4) хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг шийдвэрлэсэн;

5) хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэхэд нргэдийн төлөөлөгчийг оролцуулаагүй;

6) шүүхийн шийдвэрт шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч гарын үсэг зураагүй, эсхүл шүүх бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан;

7) хуурамч нотлох баримтын үндсэн дээр хэргийг шийдвэрлэсэн нь давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд илэрсэн.

2. Давж заалдах гомдол гаргасны дараа зохигчид эвлэрэн хэлэлцсэн, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэгчийн шаардлагыг зөвшөөрсөн бол давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгож магадлал гаргана.

**173 дугаар зүйл.** Хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаах

Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүх энэ хуулийн 172 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон бол хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаж болно.

**174 дүгээр зүйл.** Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн заалтыг заавал биелүүлэх

Шүүхийн магадлалд дурдсан заалтыг хэргийг дахин хэлэлцэж байгаа шүүх заавал биелүүлнэ. Гэхдээ давж заалдах журмаар хэрэг заагдаагүй буюу түүгээр няцаагдсан байдлыг өөрөө тогтоох ба нотлогдсон гэж үзэж, түүнчлэн уг хэргийг дахин хэлэлцээд ямар шийдвэр гаргавал зохихыг анхан шатны шүүхэд зааж өгөх эрхгүй.

**175 дугаар зүйл.** Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гомдол гаргах

1. Хэргийн оролцогч нь энэ хуулийн 37, 63, 67, 69, 74, 79, 93, 99, 102, 109, 120, 126, 129, 134, 137, 157, 159, 219, 228, 229 дүгээр зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүг-

чийн захирамж, шийтгэвэрт гарсан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор энэ хуулийн 165 дугаар зүйлийн 2, 166, 168 дугаар зүйлд заасан журмаар гомдол гаргаж болно.

**176 дугаар зүйл.** Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гаргасан гомдлыг хэлэлцэн шийдвэрлэх

1. Шүүх нь шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гаргасан гомдлыг энэ хуулийн 170 дугаар зүйлд заасан журмаар хянан хэлэлцээд дараахь байдлаар шийдвэрлэж, магадлал гаргана:

1) тогтоол, захирамж, шийтгэврийг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхих;

2) тогтоол, захирамж, шийтгэврийг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаах;

3) тогтоол, захирамж, шийтгэврийг хүчингүй болгож, асуудлыг өөрийн магадлалаар шууд шийдвэрлэх.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан магадлал нь эцсийн шийдвэр болно.

## АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

**177 дугаар зүйл.** Хяналтын журмаар эсэргүүцэл бичих

1. Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч анхан шатны шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэрт; Улсын дээд шүүхийн шүүгч давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлал, тогтоолд хэргийн оролцогчийн гомдлоор буюу өөрийн санаачилгаар эсэргүүцэл бичих эрхтэй.

2. Улсын ерөнхий прокурор давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлал, тогтоолд доод шатны прокурорын саналыг үндэслэн хяналтын эсэргүүцэл бичих эрхтэй.

3. Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч, эсэргүүцлээ хяналтын журмаар хянан хэлэлцэхээс өмнө; Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор нь бичсэн эсэргүүцлээ Улсын дээд шүүхийн зөвлөлдөх хуралдааны шийдвэр гарахаас өмнө буцаан авч болно.

**1178 дугаар зүйл.** Эсэргүүцлийг хянан хэлэлцэх

1. Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгчийн бичсэн эсэргүүцлийг тухайн аймаг, нийслэлийн шүүх хяналтын журмаар хянан хэлэлцэнэ.

2. Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурорын бичсэн эсэргүүцлийг Улсын дээд шүүхийн зөвлөлдөх хуралдаанд хэлэлцүүлж, хяналтын журмаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

**1179 дүгээр зүйл.** Шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэх

Хэргийг хяналтын шүүх хуралдаанаар шийдвэрлэтэл анхан шатны буюу давж заалдах, хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн биелэгдээгүй хэсгийн биелэлтийг аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч захирамжаар түдгэлзүүлж болно.

**1180 дугаар зүйл.** Хэрэг татан авах

1. Аймаг, нийслэлийн болон Улсын дээд шүүхийн шүүгч ямар ч хэргийг доод шатны шүүхээс татан авах эрхтэй.

2. Улсын ерөнхий прокурор нь доод шатны прокурорын саналд бичсэн хэргийг шүүхээс татан авах эрхтэй.

**1181 дүгээр зүйл.** Эсэргүүцлийг Улсын дээд шүүхийн зөвлөлдөх хуралдаанаар хэлэлцэх журам

1. Улсын дээд шүүхийн зөвлөлдөх хуралдаанаар хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хэлэлцэж, эсэргүүцлийг үндэслэлтэй гэж үзвэл хэргийг хяналтын шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх, үндэслэлгүй гэж үзвэл эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгох тогтоол гаргаж, түүнд хуралдаанд оролцсон шүүгчид гарын үсэг зурна.

2. Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор зөвлөлдөх хуралдааны тогтоолыг эс зөвшөөрвөл дахин нэг удаа эсэргүүцэл бичих эрхтэй бөгөөд энэхүү эсэргүүцлийг өөр бүрэлдэхүүнтэй зөвлөлдөх хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

**1182 дугаар зүйл.** Хэрэг хянан хэлэлцэх хугацаа

Эсэргүүцэл бичигдсэнээс хойш 21 хоногоос хэтрүүлэлгүйгээр аймаг, нийслэлийн шүүхэд хяналтын шүүх хуралдаанд, Улсын дээд шүүхэд зөвлөлдөх хуралдаанд; зөвлөлдөх хуралдааны шийдвэр гарсан өдрөөс 15 хоногт багтаан хяналтын шүүх хуралдаанд хэргийг хэлэлцүүлнэ. Эдгээр хугацааг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч сунгаж болно.

**183 дугаар зүйл.** Хэргийн оролцогчдод мэдэгдэх

1. Хэргийн оролцогчид хяналтын шүүх хуралдаанд оролцохыг хүсвэл шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг тэдэнд мэдэгдэнэ.

2. Хэргийн оролцогчид шүүх хуралдаанд ирээгүй явдал хэргийг хянан шийдвэрлэхэд саад болохгүй.

**184 дүгээр зүйл.** Хяналтын шүүх хуралдаан

1. Аймаг, нийслэлийн шүүхийн хяналтын шүүх хуралдааныг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч буюу түүний томилсон шүүгч даргална.

2. Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдааныг Ерөнхий шүүгч, түүний эзгүйд шүүгчээр хамгийн олон жил ажилласан, хэрэв ажилласан хугацаа адил бол насаар хамгийн ахмад шүүгч нь даргална.

3. Хэргийг нэг шүүгч нь илтгэнэ. Илтгэгч хэргийн байдал, шийдвэр, магадлал, тогтоол, эсэргүүцлийн агуулгыг танилцуулна. Шүүгчид илтгэгчид асуулт тавьж болно.

4. Хэргийг Улсын ерөнхий прокурорын эсэргүүцлээр хэлэлцэж байгаа бол гэрээр шүүх хуралдаанд оролцож, эсэргүүцлээ дэмжиж тайлбар өгч болно.

5. Хуралдаанаас тогтоол гарах ба түүнд хуралдаан даргалагч, хуралдаанд оролцсон бүх шүүгч гарын үсэг зурна. Тогтоолд анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, эсэргүүцлийн агуулга, гаргаж буй шийдвэр, түүний үндэслэлийг тусгана.

**185 дугаар зүйл.** Хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн тогтоол

1. Хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүх дараахь байдлаар шийдвэрлэж, тогтоол гаргана:

1) шийдвэр, магадлал, тогтоолыг хэвээр үлдээж эсэргүүцлийг хангахгүй орхих;

2) шийдвэр, магадлал, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах;

3) магадлал, тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөх;

4) шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох, эсхүл хэргийг энэ хуулийн 173 дугаар зүйлд заасны дагуу дахин хянан шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцаах.

2. Хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн тогтоол нь гармагц хуулийн хүчин төгөлдөр болно.

**186 дугаар зүйл.** Шүүхийн магадлал, тогтоолыг хүчингүй болгох үндэслэл

Хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүх магадлал, тогтоолыг энэ хуулийн 172 дугаар зүйлд заасан үндэслэлээр хүчингүй болгоно.

**187 дугаар зүйл.** Улсын дээд шүүхийн хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн тогтоолыг дахин хянах

1. Улсын дээд шүүхийн хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн тогтоол нь эцсийн шийдвэр болно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тогтоол хуульд харшилсан гэж үзвэл Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч түүнд нэг удаа эсэргүүцэл бичиж хэлэлцүүлэх эрхтэй.

## АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ

### Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах

**188 дугаар зүйл.** Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах үндэслэл

1. Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэр (анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлал, тогтоол)-ийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүх дахин хянан үзэж болно.

2. Шүүхийн шийдвэрийг дараахь үндэслэлээр дахин хянана:

1) шүүхийн шийдвэр гарах үед хэргийн оролцогчдод мэдэгдээгүй буюу мэдэгдэх боломжгүй байсан нотлох баримт илэрвэл;

2) шүүхийн шийдвэр гаргах үндэслэл болсон нотлох баримт худал хуурамч, эсхүл шүүгч, иргэдийн төлөөлөгч, прокурор, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, гэрч, шинжээч, орчуулагч, хэргийн оролцогчийн уг хэргийг шийдвэрлэх үед гаргасан үйлдэл (эс үйлдэл) эрүүгийн гэмт хэрэг

болох нь хуулийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолоор тогтоогдвол;

3) шүүхийн шийдвэр гарах үндэслэл болсон шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол буюу шийдвэр, эсхүл төр, захиргааны болон бусад байгууллагын шийдвэр нь хууль бус байсны улмаас хүчингүй болсон бол.

**189 дүгээр зүйл.** Шийдвэрийг дахин хянуулах тухай хүсэлт гаргах

1. Шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянуулах тухай хүсэлтийг тийнхүү хянах үндэс бий болсноос эхлэн зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, прокурор гаргах эрхтэй.

2. Сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлтийг аймаг, нийслэлийн шүүхэд; аймаг, нийслэлийн болон Улсын дээд шүүхийн шийдвэрийг хянуулах хүсэлтийг Улсын дээд шүүхэд тус тус гаргана.

**190 дүгээр зүйл.** Хүсэлтийг шийдвэрлэх

1. Шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянуулах тухай хүсэлтийг энэ хуулийн 170, 184 дүгээр зүйлд заасан журмаар шүүх хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

2. Шүүх хуралдаанд хүсэлт гаргагч оролцохыг хүсвэл түүнд мэдэгдэх ба түүний ирээгүй явдал хүсэлтийг хэлэлцэхэд саад болохгүй.

3. Шүүх хүсэлтийг хянан хэлэлцээд түүнийг хангах буюу эсхүл хангахаас татгалзах тухай тогтоол гаргана.

4. Шүүх хүсэлтийг хангах тухай тогтоол гаргавал уг тогтоолоор урьд гаргасан шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг ердийн журмаар хэлэлцүүлэхээр зохих шүүхэд шилжүүлнэ.

## АРВАН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

### Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа

**191 дүгээр зүйл.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар гүйцэтгэх шийдвэр

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар дараахь шийдвэрийг гүйцэтгэнэ:

1) иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр;

2)) эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийн торгох, эд хөрөнгө хураах ял болон эд хөрөнгө гаргуулах заалт;

3)) захиргааны зөрчил гаргасан этгээдээс торгууль, төлбөр гаргуулах талаар гарсан шийтгэвэр;

4)) Монгол Улсын олон улсын гэрээнд зааснаар биелүүлбэл зохих гадаад улсын шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэр, холбогдох баримт бичиг;

5)) арбитрын шийдвэр.

**192 дугаар зүйл.** Шийдвэр гүйцэтгэх харьяалал

1. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг төлбөр төлөгчийн оршин суугаа (оршин байгаа) буюу ажиллаж байгаа, эсхүл эд хөрөнгө нь байгаа газрын шүүхийн гүйцэтгэгч гүйцэтгэнэ.

2. Төлбөр төлөгч нь өөр орон нутагт шилжсэн бөгөөд хаяг нь тодорхой бол гүйцэтгэх бичиг баримтыг түүний шилжин очсон газрын шийдвэр гүйцэтгэлийн албанд шилжүүлж, энэ тухай төлбөр авагчид мэдэгдэнэ.

**193 дугаар зүйл.** Гүйцэтгэх бичиг баримт

1. Энэ хуулийн 191 дүгээр зүйлд заасан шийдвэрийг гүйцэтгэж эрх зүйн үндэс нь гүйцэтгэх бичиг баримт болно. Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг гүйцэтгэх бичиг баримтгүйгээр явуулж болохгүй.

2. Гүйцэтгэх бичиг баримтад дараахь бичиг баримт орно:

1) шүүхийн шийдвэрийн үндсэн дээр олгогдсон гүйцэтгэх хуудас;

2) энэ хуулийн 191 дүгээр зүйлийн 3, 4, 5-д заасан шийтгэвэр, шийдвэр, бусад бичиг баримт.

**194 дүгээр зүйл.** Гүйцэтгэх хуудасны агуулга

1. Гүйцэтгэх хуудсанд дараахь зүйлийг заана:

1) гүйцэтгэх хуудас олгосон шүүхийн нэр;

2) шийдвэр гаргасан огноо, шийдвэрийн дугаар;

3) ямар хэргийн шийдвэрийг үндэслэж гүйцэтгэх хуудас олгосон;

4) шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн заалт;

5) шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон огноо;

6) гүйцэтгэх хуудас бичсэн шүүгчийн нэр, олгосон огноо;

7) төлбөр төлөгч, төлбөр авагчийн овог, нэр, ажлын болон гэрийн хаяг (аж ахуйн нэгж, байгууллагын оноосон нэр, үйл ажиллагаагаа явуулж байгаа газрын хаяг);

8) шаардлагатай тохиолдолд төлбөр төлөгчийн биеийн зургийг хавсарган, иргэний паспортын болон регистрийн дугаар, аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн дугаар зэргийг бичнэ.

2. Гүйцэтгэх хуудас нь сүлд бүхий хэвлэмэл хуудас байна.

3. Гүйцэтгэх хуудсанд шүүгч гарын үсэг зурж, тамга дарна.

**195 дугаар зүйл.** Гүйцэтгэх хуудас бичих, олгох

1. Шүүгч нь шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болмогц гүйцэтгэх хуудас бичнэ. Харин даруй биелүүлэх шийдвэрийн гүйцэтгэх хуудсыг гарсан өдөрт нь бичнэ.

2. Шийдвэр өөр өөр газар гүйцэтгэгдэх, эсхүл хэд хэдэн төлбөр төлөгч буюу төлбөр авагчтай бол гүйцэтгэх хуудсыг тэдгээрийн тоогоор бичнэ.

3. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга гүйцэтгэх бичиг баримтыг бүртгэж, ийнхүү бүртгэснээс хойш 3 хоногийн дотор ахлах гүйцэтгэгчид шууд олгох буюу эсхүл төлбөр авагчид хүргүүлнэ. Гүйцэтгэгч нь шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг хавсран хийж байгаа бол гүйцэтгэх бичиг баримтыг шүүгч олгоно.

4. Ахлах гүйцэтгэгчид дараахь гүйцэтгэх хуудсыг шууд олгоно:

1) төлбөрийг улсын төсвийн орлогод оруулах бол;

2) төлбөр төлөгч, авагчийн аль нэг нь өөр улс, аймаг, хот, сум, дүүрэгт оршин суудаг (оршин байдаг) бол;

3) бусдын амь нас, эрүүл мэндэд учирсан гэм хорыг нөхөн төлүүлэх бол;

4) хуулийн дагуу эд хөрөнгийг битүүмжилсэн бол;

шийдвэрийг даруй биелүүлэх бол;

5. Төлбөр авагч хүсвэл гүйцэтгэх хуудсыг ахлах гүйцэтгэгчид шууд өгч болно.

6. Ахлах гүйцэтгэгч хүлээн авсан гүйцэтгэх бичиг баримтыг бүртгэж, гүйцэтгэгчдэд хуваарилна.

7. Гүйцэтгэх хуудсанд шүүхийн шийдвэр, битүүмжилсэн буюу хураасан эд хөрөнгийн акт, иргэдийн хувийн хадгаламж, хуулийн этгээдийн харилцах дансны зарлагын гүйлгээг хаасан баримт бичиг, тодорхойлолт зэргийг хавсаргана.

**196 дугаар зүйл.** Бусад гүйцэтгэх бичиг баримтыг хүлээн авах

Гүйцэтгэх хуудаснаас бусад гүйцэтгэх бичиг баримтыг төлбөр төлөгчийн оршин суугаа (оршин байгаа) газрын шүүхийн ахлах гүйцэтгэгч хүлээн авна.

**197 дугаар зүйл.** Гүйцэтгэх хуудсыг дахин олгох

Гүйцэтгэх хуудсыг үрэгдүүлсэн тохиолдолд түүнийг туайн шүүхийн шүүгчийн захирамжаар хүчингүйд тооцож, ахин бичиж олгоно.

**198 дугаар зүйл.** Гүйцэтгэгчийг татгалзах

Гүйцэтгэгч нь төлбөр төлөгч, төлбөр авагчийн аль нэгний өрөл садан буюу түүнтэй хувийн харилцаатай бол нөгөө ал нь түүнийг татгалзаж болно. Энэ тухай хүсэлтийг туайн шүүхийн тамгын хэлтэст бичгээр гаргах ба түүнийг 3 оногийн дотор шийдвэрлэнэ.

**199 дүгээр зүйл.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр төлөгч, төлбөр авагчийн эдлэх эрх

1. Төлбөр төлөгч, төлбөр авагч нь шүүхийн шийдвэр гүйэтгэх ажиллагаа явагдах үед байлцах, шийдвэр гүйцэтгэх жиллагаатай холбогдсон акт, бусад баримт бичигтэй тайлцах, хуулбарыг авах эрхтэй.

2. Төлбөр төлөгч, төлбөр авагч нь гүйцэтгэгчийн ажиллагааг зөвшөөрөхгүй бол ажиллагаа явагдсан өдрөөс уг жиллагаа хэзээ, хаана явагдахыг мэдээгүй бол мэдсэн өдөөс хойш 14 хоногийн дотор энэ тухай гомдлоо шүүхэд аргаж болно.

**200 дугаар зүйл.** Шийдвэрийг сайн дураар биелүүлэх

1. Шүүгч нь гүйцэтгэх хуудсыг төлбөр авагчид хүргүүлэийн хамт шийдвэрийг сайн дураар биелүүлэхийг шаардан, өлбөр төлөгчид хугацаатай мэдэгдэл өгнө.

2. Төлбөр авагч гүйцэтгэх хуудсыг хүлээн аваад түүнийг ийн дураар биелүүлэхийг төлбөр төлөгчөөс шаардаж болно.

3. Гүйцэтгэгч хүлээж авсан гүйцэтгэх бичиг баримтын гуу хугацаатай мэдэгдэл бичиж, шийдвэрийг сайн дураар елүүлэхийг төлбөр төлөгчөөс шаардана.

4. Шийдвэрийг сайн дураар биелүүлэх хугацааг хуульд өөр заагаагүй бол 90 хүртэл хоногоор тогтооно.

**201 дүгээр зүйл.** Шийдвэрийг албадан гүйцэтгэх

Төлбөр төлөгч тогтоосон хугацаанд шийдвэрийг сайн дураар гүйцэтгээгүй буюу гүйцэтгэхээс татгалзвал гүйцэтгэгч ийдвэрийг албадан гүйцэтгэхээр дараахь арга хэмжээ авна:

1) төлбөр төлөгчийн хөрөнгө, биед үзлэг, нэгжлэг хийх,

эд хөрөнгийг бүтүүмжлэх, барьцаалах, хураах, худалдан бор луулах;

2) төлбөр төлөгчийн цалин, бусад орлогоос суутгал хийл гүүлэх;

3) төлбөр төлөгчийн бусдад байгаа эд хөрөнгө, мөнгөнөө төлбөр гаргуулах;

4) шийдвэрт нэр заасан тодорхой зүйлийг төлбөр төлөг чөөс гаргуулж төлбөр авагчид шилжүүлэх;

5) тодорхой үйлдэл гүйцэтгүүлэх;

6) хуульд заасан бусад арга хэмжээ.

**202 дугаар зүйл.** Төлбөр төлөгчийн эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгийг бүтүүмжлэх, барьцаалах, хураах

1. Төлбөр төлөгчийн эд хөрөнгийн хэмжээг тогтоох зо рилгоор түүний өөрт нь болон бусдын эзэмшилд байгаа эд хөрөнгөд нэг бүрчлэн үзлэг хийнэ.

2. Төлбөр төлөгчийн эд хөрөнгөд үзлэг хийх, бүтүүмжлэх барьцаалах, хураах явцад түүний биедээ буюу ямар нэг га зар, бусад этгээдэд нуусан эд хөрөнгийг илрүүлэх зорилгоо тэдгээрийн биед болон тухайн газарт нэгжлэг хийж болно.

3. Шаардлагатай гэж үзвэл гүйцэтгэгч нь төлбөр төлөг чийн банкин дахь дансны зарлагын хөдөлгөөнийг тухай банкинд мэдэгдэл өгөх замаар төлбөр төлөх хүртэл хугацаа гаар зогсоож болно.

4. Төлбөр төлөгчийн эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийж түүний хөрөнгийн хэмжээг тогтоосны дараа тухайн эд хөрөн гөнөөс төлбөрийг төлөхөд хүрэлцэхүйц хэмжээний эд хөрөн гийг бүтүүмжлэх буюу барьцаалж, төлбөр төлөх хугацаа тогтоож өгнө.

5. Тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй бол бүтүүм жилсэн, барьцаалсан эд хөрөнгийг уг хугацаа дуусахаа өмнө чөлөөлөх тухай шүүхийн шийдвэр гарсан бол эд хөрөн гийг буцааж олгоно.

**203 дугаар зүйл.** Эд хөрөнгөнд үзлэг, нэгжлэг хийх, түүнийг бүтүүмжлэх, барьцаалах, хураах ажиллагаа явуулах журам

1. Төлбөр төлөгчийн эд хөрөнгөнд үзлэг, нэгжлэг хий түүнийг бүтүүмжлэх, барьцаалах, хураах ажиллагааг явуу лахад уг хэрэгт хувийн сонирхолгүй, эрх бүхий бүрэн ча дамжтай, хөндлөнгийн 2 гэрчийг байлцуулна. Хөндлөнгий гэрч нь уг ажиллагааны явц, агуулгыг баталж өгөх үүрэгтэ

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажиллагааг явуулахад элбэр төлөгч, эсхүл түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, өмгөөлөгч, хэрэв боломжгүй бол зохих нутгийн захиргааны байгууллагын төлөөлөгчийг байлцуулна.

3. Төлбөр төлөгч нь хуулийн этгээд байвал уг байгууллагын төлөөлөгчийг байлцуулна.

4. Гүйцэтгэгч нь эд хөрөнгөнд үзлэг, нэгжлэг хийх, түүнийг битүүмжлэх, барьцаалах, хураах ажиллагааны явцад өмдэглэл хөтөлж, байлцсан этгээдүүдээр гарын үсэг зуруулна. Тэмдэглэлд засвар оруулахаар санал гаргах эрхтэйг гүйцэтгэгч тэдэнд тайлбарлаж өгнө.

**204 дүгээр зүйл.** Эд хөрөнгөнөөс төлбөр гаргуулах

1. Төлбөрийг төлбөр төлөгч иргэний хувийн өмчөөс гаргуулна. Төлбөр төлөгч хуулийн этгээдийн төлбөрийг түүний банк дахь дансанд байгаа мөнгөн хөрөнгө, түүнчлэн үл хөдлөх ба хөдлөх эд хөрөнгөнөөс гаргуулна.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд хөрөнгө нь төлбөр бүлөхөд хүрэлцэхгүй байвал төлбөр төлөгчийн дундаа хэсэгээр буюу хамтран өмчлөх эд хөрөнгийн түүнд оногдох хэсгээс гаргуулна.

3. Төлбөр төлөгч ямар эд хөрөнгөө төлбөрт өгөх хүсэлээ тавих эрхтэй. Шийдвэр гүйцэтгэхэд саад болохгүй бол тэр хүсэлтийг харгалзан үзнэ.

**205 дугаар зүйл.** Төлбөрт гаргуулж болохгүй эд хөрөнгө

Төлбөр төлөгч иргэний зайлшгүй хэрэгцээт дараахь эд хөрөнгийг төлбөрт авч болохгүй:

1) төлбөр төлөгчийн байнга амьдран суугаа орон сууц;

2) зайлшгүй хэрэгцээт хоол, хүнсний зүйл;

3) улирал бүрийн нэг ээлжийн хувцас;

4) хүйтний улиралд түлээ түлш.

**206 дугаар зүйл.** Эд хөрөнгийг үнэлэх

Гүйцэтгэгч нь төлбөр төлөгчийн эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураахдаа түүний чанар, хэрэгцээ, элэгдэл байдал болон төлбөр төлөгчийн саналыг харгалзан орон нутгийн зах зээлийн тухайн үеийн ханшаар үнэлж, энэ тухай тэмдэглэл үйлдэнэ.

**207 дугаар зүйл.** Эд хөрөнгийг хадгалах

1. Гүйцэтгэгч нь битүүмжилсэн, барьцаалсан, хураасан хөрөнгийг төлбөр төлөгч болон бусад этгээдэд хадгалуулж болно.

2. Хадгалагч эд хөрөнгийг хэвийн байдлаар арчлан хадгалах үүрэгтэй.

3. Эд хөрөнгө хадгалагч нь төлбөр төлөгч буюу түүний гэр бүлийн гишүүн биш бол хадгалсны хөлсийг тохиролцсоны дагуу авна. Мал, амьтан хадгалуулсны хөлсийг тэдгээрт зарцуулсан зардлыг тооцон авна.

4. Төлбөр төлөгчөөс хураасан үнэт металл, эрдэнийн чулуу, гадаад валютыг банкинд хадгалуулна.

**208 дугаар зүйл.** Эд хөрөнгийг худалдан борлуулах үнэлж худалдана.

1. Хураагдсан эд хөрөнгийг гүйцэтгэгч орон нутагтаа өөрөө шууд худалдах буюу бусдаар зуучлуулан, түүнчлэн дэлгүүр, үнэ хаялцуулах худалдаагаар худалдаж болно.

2. Үнэт металл, эрдэнийн чулуу, гадаад валют, үнэт цаасыг хууль тогтоомжид заасан журмын дагуу худалдана.

3. Галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх зүйлс, химийн бодис зэрэг тусгай зөвшөөрөлтэйгээр олж авах зүйлийг холбогдох байгууллагад худалдах буюу шүүхийн шийдвэрийн дагуу шилжүүлнэ.

4. Эд хөрөнгийг, түүнийг хураахад тогтоосон үнийг харгалзан орон нутгийн зах зээлийн тухайн үеийн ханшаар үнэлж худалдана. Шаардлагатай бол холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан үнэлж болно. Үнийн талаар гарсан гомдлыг шүүх шийдвэрлэнэ.

5. Эд хөрөнгийг хураан авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, хүнсний болон хурдан гэмтэж муудах зүйлийг нэн даруй худалдана. Энэ хугацаанд худалдагдаагүй эд хөрөнгийг төлбөр авагчид төлбөртөө тооцон авахыг санал болгож буюу төлбөр төлөгчид мэдэгдэн үнэ хямдруулан худалдах болно. Төлбөр авагч авахаас татгалзсан буюу худалдагдаагүй эд хөрөнгийг төлбөр төлөгчид буцаан өгнө.

**209 дүгээр зүйл.** Албадан гүйцэтгэх ажиллагааг баримтжуулах

1. Гүйцэтгэгч нь төлбөр төлөгчийн эд хөрөнгөд үзлэг нэгжлэг хийх, түүнийг битүүмжлэх, барьцаалах, хураан үнэлэх, худалдах, шилжүүлэх, хариуцагчийг барилга, орц суушнаас албадан нүүлгэх зэрэг ажиллагаа явуулах бүрт акт үйлдэн (шаардлагатай үед жагсаалтыг хавсарган) тэмдэглэл хөтөлж, уг ажиллагаанд оролцсон, байлцсан бүх этгээдээр гарын үсэг зуруулна.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан актын загварыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.

**210 дугаар зүйл.** Гүйцэтгэх ажиллагааны явцад холбогдох этгээдийг дуудах, мэдэгдэл өгөх

1. Гүйцэтгэгч нь албадан гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч, төлбөр авагч, холбогдох бусад этгээдийг шүүхийн мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлж асуух, тэдгээрээс баримт бичиг гаргуулан авч болох ба төлбөр төлөхийг шаардах, цалин, хөлс, орлогоос суутгал хийх хугацаатай мэдэгдлийг өгнө.

2. Шүүгч, гүйцэтгэгч нь төлбөр төлөгчийг дуудан ирүүлж шийдвэрийг сайн дураар биелүүлэх мэдэгдлийг гардуулан өгнө.

3. Мэдэгдлийг гардуулан өгөх боломжгүй бол баталгаат шуудангаар илгээх буюу биечлэн хүргүүлнэ. Дуудах, мэдэгдэл хүргүүлэхэд энэ хуулийн 76 дугаар зүйлд заасан журмыг баримтлана.

**211 дүгээр зүйл.** Төлбөр төлөгчийн цалин, хөлс, бусад орлогоос төлбөр гаргуулах

1. Төлбөр нь төлбөр төлөгчийн сарын дундаж цалин, хөлс, бусад орлогын 50 хувиас хэтрэхгүй, тэрээр эд хөрөнгөгүй нь тогтоогдсон, эд хөрөнгө нь төлбөрийг бүрэн төлж хүрэлцэхгүй байвал түүний цалин, хөлс, бусад орлогоос төлбөр, тэтгэлгийг гаргуулна.

2. Цалин, хөлс, тэтгэвэр, тэтгэмжээс өөр орлогын эх үүсвэргүй төлбөр төлөгчийн сарын цалин, хөлс, тэтгэвэр, тэгэмжийн 50 хувиас хэтрүүлэн суутгал хийж болохгүй. Үүнд шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор засан хүмүүжүүлэх ажил хийх ял эдэлж байгаа төлбөр төлөгчийн цалин, хөлснөөс суутгаж байгаа суутгал хамаарахгүй.

**212 дугаар зүйл.** Төлбөр, тэтгэлэг гаргуулж болохгүй орлого

Төлбөр төлөгчийн дараахь орлогоос төлбөр, тэтгэлэг гаргуулж болохгүй:

1) байгалийн гэнэтийн аюул, онцгой нөхцөл байдлын улмаас үзүүлж буй тусламж, хандив;

2) албан томилолт болон өөр газар шилжин очсоны зардал;

3) нэг удаагийн буцалтгүй олгосон эд хөрөнгийн болон мөнгөн тусламж;

4) Тэтгэмжийн хуулийн дагуу олгож байгаа хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмжээс бусад тэтгэмж;

5) донор болон эхийн сүүнд олгож буй нэхэн олговор;

6 нэмэгдэл хоол, амралт, сувиллын эмчилгээ, хиймэл эрхтэн хийлгэх, өвчтөн сахихад олгосон зардал;

7) тахир дутуугийн нэгдүгээр зэргийн тэтгэвэр авагчийн асрамжид зориулсан нэмэгдэл;

8) хүүхдийн тэтгэлгийн мөнгө.

**213 дугаар зүйл.** Цалин, хөлс, бусад орлогоос төлбөр гаргуулах журам

1. Гүйцэтгэгч нь төлбөр төлөгчийн цалин, хөлс, бусад орлогоос нь суутгал хийлгүүлэхээр түүний ажиллаж, суралцаж, тэтгэвэр авч байгаа аж ахуйн нэгж, байгууллагад мэдэгдлийг хүргүүлнэ.

2. Аж ахуйн нэгж, байгууллага мэдэгдлийг хүлээн авмагц төлбөр төлөгчөөс суутгалыг сар тутам зохих хувиар хийж, суутгасан мөнгийг суутгал хийснээс хойш 3 хоногийн дотор төлбөр авагчид шууд олгох буюу мэдэгдэл өгсөн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дансанд шилжүүлнэ.

3. Шүүхийн шийдвэрийн дагуу гаргуулах төлбөр, тэтгэлгийг бусад төлбөрийн өмнө тэргүүн ээлжинд суутгана.

4. Төлбөр төлөгч ажлаас халагдвал халагдсан өдрөөс хойш 7 хоногийн дотор аж ахуйн нэгж, байгууллага нь түүнээс төлбөр, тэтгэлэгт суутгасан мөнгөний хэмжээ, тэрээр хаана шилжсэнийг мэдэгдэлд тэмдэглэж гүйцэтгэгчид буцаана.

4. Хоригдож байгаа этгээдийн төлбөрийг түүний хөрөнгө байгаа газраар гүйцэтгэсний дараа дутуу хэсгийг гүйцэтгүүлэхээр гүйцэтгэх бичиг баримтыг уг этгээдийн байгаа хорих ангийн захиргаанд явуулж хөдөлмөрийн хөлснөөс нь суутгуулна. Хоригдож байх хугацаанд төлбөрийг бүрэн төлж дуусаагүй бол түүний суллагдсаны дараа гүйцэтгэх бичиг баримт, бусад холбогдох материалыг уг этгээдийн байнга оршин суух газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид шилжүүлнэ. Хоригдож байгаа этгээдийн хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийх журмыг хорих байгууллагуудыг удирдах газар батална.

**214 дүгээр зүйл.** Мөнгөн хөрөнгөнөөс төлбөр гаргуулах журам

1. Хуулийн этгээдийн банкны дансан дахь мөнгөн хөрөнгөнөөс төлбөр гаргуулах мэдэгдлийг гүйцэтгэгч зохих банкинд хүргүүлэх бөгөөд түүнийг үндэслэн банк нь төлбөр төлөгчийн данснаас төлбөрийг гаргаж, заасан хугацаанд төлбөр авагчид олгох буюу мэдэгдэл өгсөн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дансанд шилжүүлнэ.

2. Төсөвт байгууллагын дансанд байгаа мөнгө нь төлбөрт хүрэлцэхгүй бол түүнийг санхүүжүүлдэг байгууллагад төлбөрийг гаргуулах мэдэгдлийг хүргүүлэх буюу дараагийн төсөвт нэгж тусгахыг шаардана.

**215 дугаар зүйл.** Хуулийн этгээдийн үйл ажиллагаа зогсоогдох үед төлбөр гаргуулах

1. Төлбөр төлөгч хуулийн этгээд татан буугдах, өөрчлөн байгууллагдах зэргээр үйл ажиллагаа нь зогсоогдох үед гүйцэтгэх бичиг баримтыг татан буулгах комисс буюу хэрэг гүйцэтгэгчид шилжүүлнэ.

2. Татан буулгах комисс буюу хэрэг гүйцэтгэгч нь гүйцэтгэх бичиг баримтыг хүлээн авмагц төлбөрийг тэргүүн ээлжинд гаргуулан төлбөр авагчид, эсхүл гүйцэтгэх бичиг баримт өгсөн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дансанд шилжүүлнэ.

**216 дугаар зүйл.** Төлбөр төлөгчийн бусдад байгаа эд хөрөнгө, мөнгөнөөс төлбөр гаргуулах

1. Гүйцэтгэгч нь төлбөр төлөгчийн эд хөрөнгө, мөнгө бусдад байгаа эсэхийг тодруулж, хэрэв байвал түүнээс төлбөрт шаардагдах хэмжээгээр гаргуулна.

2. Төлбөр төлөгчийн банкин дахь данс, хадгаламжид байгаа үнэт металл, эрдэнийн чулуу, үнэт цаас, мөнгө, түүнчлэн төлбөр төлөгчөөс бусдад, бусдаас төлбөр төлөгчид бэлэн ба бэлэн бусаар шилжүүлсэн хоорондын төлбөр тооцооны мөнгөнөөс төлбөрт авч болно.

**217 дугаар зүйл.** Таслан шийдвэрлэх тогтоолын эд хөрөнгө хураах болон бусад заалтыг гүйцэтгэх ажиллагааны онцлог

1. Гүйцэтгэгч нь эд хөрөнгө хураах ялыг гүйцэтгэхдээ гүйцэтгэх бичиг баримтыг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор энэ хуульд заасан журмын дагуу эд хөрөн-

гийг битүүмжилж, бусад ажиллагааг 30 хоногийн дотор дуусгавар болгоно.

2. Дундаа хэсгээр буюу хамтран өмчлөх эд хөрөнгөнөөс тодорхой эд хөрөнгийг хураахаар таслан шийдвэрлэх тогтоолд нэрлэн заасан бол түүнийг хураана.

**218 дугаар зүйл.** Тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэхээр хариуцагчид даалгасан шийдвэрийг биелүүлэх

1. Барилга, орон сууцнаас нүүлгэн гаргах, хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид шилжүүлэх зэрэг тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх шийдвэрийг хариуцагч нь шүүхээс тогтоосон хугацанд биелүүлээгүй бол гүйцэтгэгч албадан гүйцэтгэнэ.

2. Хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжих байгууллагын төлөөлөгчийг байлцуулна.

3. Барилга, орон сууцнаас нүүлгэн гаргах тухай хугацаатай мэдэгдлийг сайн дураар биелүүлээгүй бол гүйцэтгэгч нь албадан нүүлгэх өдөр, цагийг тогтоосон мэдэгдлийг нүүн гарвал зохих этгээдэд өгнө.

4. Нүүлгэн гаргах ажиллагааг нүүн гарч байгаа этгээд, хөндлөнгийн 2 гэрчийг байлцуулан, шаардлагатай бол цагдаа, орон сууц ашиглалтын байгууллагын төлөөлөгчийг оролцуулан гүйцэтгэнэ.

5. Нүүн гарах этгээд албадан нүүлгэх мэдэгдэлд заасан хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэртээ байхгүй байвал түүний эзгүйд эд хөрөнгийг нь битүүмжлэн, зохих этгээдэд хадгалуулахаар хүлээлгэн өгч, барилга, орон сууцыг чөлөөлнө.

6. Шийдвэр биелүүлэх явцад барилга, орон сууцнаас албадан нүүлгэх боломжгүй нөхцөл байдал илэрвэл гүйцэтгэгч энэ тухай акт үйлдэж гүйцэтгэх бичиг баримтыг шүүхэд буцаана.

7. Шүүхийн шийдвэрээр аль ч улиралд албадан нүүлгэнэ.

8. Орон сууцнаас нүүн гарч байгаа этгээдэд өөр орон сууц олгохоор шийдвэрт заасан бол гүйцэтгэгч тухайн байгууллагад уг шийдвэрийг гүйцэтгэх хугацаатай мэдэгдэл явуулна.

**219 дүгээр зүйл.** Ажилтныг урьдах ажил, албан тушаалд нь эргүүлэн тогтоох тухай шийдвэрийг биелүүлээгүйн холбогдол

Буруугаар халагдсан буюу шилжүүлэгдсэн ажилтныг ажилд нь буюу урьдах албан тушаалд нь эргүүлэн тогтоох тухай шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй бол тухайн ажилтны ажилгүй байсан хугацааны цалин, хөлс буюу бага цалин, хөлстэй ажил хийж байсны зөрүүг шийдвэр гарсан өдрөөс түүнийг биелүүлэх өдөр хүртэлх хугацаанд шийдвэр биелүүлээгүй буруутай албан тушаалтнаас гаргуулан олгуулахаар энэ хуулийн 128 дугаар зүйлд заасан журмын дагуу шүүгч захирамж гаргана.

**220 дугаар зүйл.** Гаргуулсан төлбөр, тэтгэлгийг олгох журам

Гүйцэтгэгч нь гаргуулсан төлбөрийн мөнгийг хуулийн этгээдийн банк дахь дансанд бэлэн буюу бэлэн бусаар хийнэ. Дансны дугаар мэдэгдэхгүй байвал уг мөнгийг шийдвэр гүйцэтгэлийн дансанд оруулна.

2. Гүйцэтгэгч нь төлбөрт бэлнээр гаргуулсан мөнгийг төлбөр авагч иргэнд бэлнээр олгох буюу түүний хадгаламжийн дансанд шилжүүлнэ. Хэрэв төлбөр авагч ирэхгүй буюу хадгаламжийн данс нь мэдэгдэхгүй байвал мөнгийг шийдвэр гүйцэтгэлийн дансанд оруулна. Төлбөр төлөгчөөс илүү төлөгдсөн мөнгийг түүнд буцаан олгоно.

3. Гадаадад оршин суугаа (оршин байгаа) төлбөр авагчид төлбөр, тэтгэлгийн мөнгийг шийдвэр гүйцэтгэлийн данснаас банкаар дамжуулан гадаад төлбөр тооцооны журмаар олгоно. Энэ журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл Монголбанктай хамтран батална.

**221 дүгээр зүйл.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн данснаас мөнгө олгох

1. Ахлах гүйцэтгэгч нь дансанд мөнгө шилжиж ирсэн тохиолдолд төлбөр авагчид мэдэгдэх, мөнгийг олгох ажиллагааг 14 хоногийн дотор гүйцэтгэх бөгөөд төлбөр авагчийн овог, нэр, хаяг тодорхойгүй буюу буруу хаягаар шилжиж ирсэн бол тодруулах ажиллагаа хийнэ.

2. Дансанд мөнгө шилжүүлэгч нь төлбөр төлөгч, төлбөр авагчийн овог, нэр, хаягийг үнэн зөв, тодорхой бичих үүрэгтэй. Овог, нэр, хаягийг буруу бичсэнээс гарсан нэмэгдэл зардлыг буруутай этгээд хариуцна.

**222 дугаар зүйл.** Хүүхдийн тэтгэлгийн мөнгийг олгох

Хүүхдийн тэтгэлгийн мөнгийг дараахь журмаар олгоно:

1) тэтгэлэг төлөгчийн цалин, хөлс, бусад орлогоос суут-

гал хийсэн аж ахуйн нэгж, байгууллагаас төлбөр авагчид шууд бэлнээр олгох буюу төлбөр авагчийн хадгаламжид шилжүүлнэ;

2) шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дансанд орж ирсэн тэтгэлгийн мөнгийг банкаар дамжуулан тэтгэлэг авагчид бэлнээр олгох буюу түүний хадгаламжийн дансанд, эсхүл өөрийнх нь заасан хуулийн этгээдийн дансанд шилжүүлнэ.

**223 дугаар зүйл.** Төлбөрийг бодитой биелүүлсэнд тооцох

Төлбөр төлөгчөөс гаргуулсан эд хөрөнгө, мөнгийг төлбөр авагчид хуульд заасан журмаар олгосны төлбөрийг бодитой биелүүлсэнд тооцож, гүйцэтгэх бичиг баримтыг хаана.

**224 дүгээр зүйл.** Төлбөр авагчдын шаардлагыг хангах дараалал

1. Төлбөр төлөгчөөс гаргуулсан эд хөрөнгө, мөнгө нь хэд хэдэн төлбөр авагчийн шаардлагыг нэгэн зэрэг хангахад хүрэлцэхгүй байвал гүйцэтгэх бичиг баримтыг хүлээн авсан дарааллыг баримтлан төлбөр авагчдын шаардлагыг хангана.

2. Хэд хэдэн гүйцэтгэх хуудсыг нэг өдөр хүлээн авсан бол төлбөр авагч нэг бүрийн авах төлбөрийн хэмжээгээр хувь тэнцүүлэн бодно.

3. Хүүхдийн тэтгэлэг, бусдын амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлын төлбөрийг тэргүүн ээлжинд олгоно.

**225 дугаар зүйл.** Хаяг тодруулах буюу эрэн сурвалжлах ажиллагаа

1. Төлбөр төлөгч шүүхийн шийдвэрт заасан хаягаа өөрчилснөө мэдэгдээгүйгээс түүний хаяг тодорхойгүй болсон тохиолдолд гүйцэтгэгч нь иргэний бүртгэл мэдээллийн, татварын, зохих нутгийн захиргааны болон холбогдох бусад байгууллагаас лавлагаа авч, тухайн хүний эцэг, эх, эхнэр, нөхөр, төрөл садангийн хүмүүсийг дуудан ирүүлж тайлбар гаргуулан хаягийг тодруулна.

2. Төлбөр төлөгчийн хаягийг тогтоох боломжгүйгээс шүүхийн шийдвэр биелэгдэхгүйд хүрвэл гүйцэтгэгч нь холбогдох материалыг бүрдүүлж шүүгчид өгнө. Шүүгчийн захирамжаар төлбөр төлөгчийг эрэн сурвалжлах ажиллагааг цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ.

**226 дугаар зүйл.** Гүйцэтгэх бичиг баримтыг төлбөр авагчид буцаах

1. Гүйцэтгэх бичиг баримтыг төлбөр авагчид дараахь тохиолдолд буцаана:

1)) төлбөр авагчийн хүсэлтээр;

2)) төлбөр гаргуулж болох эд хөрөнгө, орлого төлбөр төлөгчид байхгүй бол;

3)) төлбөр авагч нь шүүхийн шийдвэрт нэрлэн заасан эд хөрөнгийг авахаас, түүнчлэн төлбөрт гаргуулсан худалдаагүй эд хөрөнгийг төлбөрт тооцон авахаас татгалзсан.

2. Төлбөр авагчийн хүсэлээр буцааснаас бусад тохиолдолд гүйцэтгэх бичиг баримтыг шүүгчийн зөвшөөрснөөр буцаана. Төлбөрт гаргуулж болох эд хөрөнгө, орлого төлбөр төлөгчид байхгүй тухай гүйцэтгэгчийн тэмдэглэлийг шүүгч батлан зөвшөөрөхдөө төлбөр төлөгчийн эд хөрөнгийг зохих ёсоор битүүмжилсэн, хураасан, бүрэн борлуулсан эсэх, нуусан эд хөрөнгийг олж илрүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авсан эсэхийг хянах үүрэгтэй.

3. Гүйцэтгэх бичиг баримтыг төлбөр авагчид буцаасан нь шийдвэрийг гүйцэтгүүлэхээр дахин ирүүлэхэд саад болохгүй.

**227 дугаар зүйл.** Гүйцэтгэх бичиг баримтыг шүүхэд буцаах

Гүйцэтгэх бичиг баримт буруу бичигдсэнээс шийдвэрийг биелүүлэх боломжгүй тохиолдолд гүйцэтгэх хуудсыг шүүхэд, бусад гүйцэтгэх бичиг баримтыг ирүүлсэн этгээдэд нь буцаана.

**228 дугаар зүйл.** Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх

1. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шүүгч дараахь үндэслэлээр түдгэлзүүлнэ:

1) төлбөр төлөгч, төлбөр авагч ирэн нас барсан буюу хуулийн этгээдийн үйл ажиллагаа зогссон үед тэдгээрийн эрх, үүрэг бусдад шилжих ёстой бол ийнхүү шилжих хүртэл;

2) төлбөр төлөгч нь хүнд өвчний учир эмнэлэгт хэвтэж эмчлүүлж байгаа бол эмнэлгээс гарах хүртэл;

3) төлбөр төлөгчийн хаягийг тодруулах буюу эрэн сурвалжилж байгаа бол олох хүртэл;

4) битүүмжилсэн эд хөрөнгийг чөлөөлүүлэх тухай нэхэмжлэл гарсан бол шийдвэр гартал;

5) шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар гомдол гарсан бол түүнийг хянан шийдвэрлэх ажиллагаа дуустал.

2. Гүйцэтгэгч нь энэ зүйлийн 1дэх хэсэгт заасан үндэслэлийг илэрвэл шүүгчид мэдэгдэнэ.

3. Түдгэлзүүлэх шалтгаан арилмагц төлбөр авагчийн буюу гүйцэтгэгчийн хүсэлтээр шүүгч захирамж гарган гүйцэтгэх ажиллагааг сэргээнэ.

**229 дүгээр зүйл.** Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгсэхгүй болгох

1. Шүүгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дараахь тохиолдолд захирамж гарган хэрэгсэхгүй болгоно:

1) төлбөр авагч нь төлбөр авахаас татгалзвал түүний хүсэлтээр;

2) төлбөр төлөгч, төлбөр авагч хоорондоо эвлэрвэл тэдгээрийн гаргасан тодорхойлолтоор;

3) төлбөр төлөгч, төлбөр авагч иргэн нас барсан, хуулийн этгээдийн үйл ажиллагаа зогссоны дараа түүний эрх, үүрэг нь эрх залгамжлагчид шилжээгүй бол;

4) шийдвэр хүчингүй болбол.

2. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгсэхгүй болговол гүйцэтгэх бичиг баримтад энэ тухай тэмдэглэл үйлдэж төлбөр авагчид хүргүүлнэ.

3. Нэгэнт хэрэгсэхгүй болгосон гүйцэтгэх ажиллагааг дахин сэргээхгүй.

**230 дугаар зүйл.** Гүйцэтгэгч бэлэн мөнгө хүлээн авах, олгох

1. Гүйцэтгэгч төлбөрт бэлэн мөнгө хүлээн авах, түүнийг төлбөр авагчид олгохдоо баримтыг тухай бүр хоёр хувь үйлдэж, үйлдсэн огноог бичиж, гарын үсэг зуруулан, нэг хувийг нь төлбөр төлөгч буюу төлбөр авагчид өгнө.

2. Бэлэн мөнгө хүлээн авсан баримт нь ямар нэгэн засваргүй байна. Бэлэн мөнгө хураах баримт нь нэгдсэ дугааргай хэвлэмэл маягт байна.

3. Гүйцэтгэгч нь хүлээн авсан бэлэн мөнгийг нийслэл, дүүрэг, хороодод буюу аймаг, сумын төвд 24 цаг, бусад газарт 7 хоногийн дотор төлбөр авагчид олгох буюу шийдвэр гүйцэтгэлийн дансанд шилжүүлнэ.

**231 дүгээр зүйл.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн данс

1. Шүүхийн тамгын газар, аймаг, нийслэлийн шүүхийн тамгын хэлтэс нь банкинд шийдвэр гүйцэтгэлийн данстай байна.

2. Тамгын хэлтсээс алслагдсан сум, сум дунд, дүүргийн шүүх нь банкинд шийдвэр гүйцэтгэлийн данстай байж болно.

3. Шүүхийн тамгын газар нь банкинд гадаад төлбөр тооцооны данстай байна.

4. Шийдвэр гүйцэтгэлийн дансны мөнгөн баримтад нэгдүгээр гарын үсгийг Улсын ерөнхий гүйцэтгэгч, аймаг, нийслэлийн шүүхийн тамгын хэлтсийн дарга, хоёрдугаар гарын

үсгийг ахлах гүйцэтгэгч зурна. Сум, сум дунд, дүүргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дансны мөнгөн баримтад нэгдүгээр гарын үсгийг аймаг, нийслэлийн шүүхийн тамгын хэлтсийн эрх бүхий ажилтан, хоёрдугаар гарын үсгийг ахлах гүйцэтгэгч зурна.

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн данс, бүртгэлийн хөтлөлт, тайлан тэнцлийг нягтлан бодох бүртгэлийн хууль болон хуульь тогтоомжийн дагуу гаргасан заавар, журмыг баримтлан хөтлөнө. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажлын онцлогийг тусгасан данс, бүртгэл, тайлан тэнцлийн зааврыг Шүүхийн ерөнхий зөвлөл Сангийн яамтай зөвшилцөн батална.

**23:2 дугаар зүйл.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дансанд мөнгө хадгалах

1. Төлбөр авагчийн хаяг тодорхойгүйгээс олгогдоогүй мөнгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дансанд, нийтэд зарласнаас хойш дараахь хугацаанд хадгална:

1) иргэнд олгох бол 3 жил;

2) хуулийн этгээдэд шилжүүлэх бол 1 жил.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дансанд байгаа мөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд мөнгийг улсын төсвийн орлогод шилжүүлнэ.

**23:3 дугаар зүйл.** Шийдвэр гүйцэтгэлийн албадах ажиллагааны зардал

1. Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэхтэй холбогдсон бүх зардлыг шүүхийн төсвөөс санхүүжүүлнэ.

2. Төлбөр төлөгчийн эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэх, худалдан борлуулах, нуусан эд хөрөнгийг илрүүлэх зэрэг ажиллагааны зардлыг төлбөр төлөгчөөс нөхөн гаргуулж, шүүхийн тамгын хэлтсийн дансанд оруулна.

3. Гүйцэтгэгч энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан ажиллагааны тэмдэглэлд уг ажиллагааны үед гарсан зардлыг тооцож төлбөр төлөгчөөр гарын үсэг зуруулна.

4. Төлбөр төлөгч нь зардлын хэмжээг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.

**234 дүгээр зүйл.** Гүйцэтгэгдсэн шийдвэрийг цуцлах

1. Гүйцэтгэгдсэн шийдвэр хүчингүй болсон бол хүчингүй болсон шийдвэрээр төлбөр авагчид олгогдсон бүх зүйлийг

эгүүлэн гаргуулж төлбөр төлөгчид буцаан олгох буюу тийм боломжгүй бол буцаан олгох үеийн ханшаар үнийг төлнө.

2. Шийдвэрийг давж заалдах буюу хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүх хүчингүй болгож байгаа бол гүйцэтгэгдсэн шийдвэрийг цуцлах тухай асуудлыг өөрөө шийдвэрлэх, эсхүл анхан шатны шүүхээр шийдвэрлүүлэхээр шилжүүлэх үүрэгтэй.

## АРВАН ДОЛДУГААР БҮЛЭГ

### Олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа

**235 дугаар зүйл.** Монгол Улсын олон улсын гэрээ

Монгол Улсын олон улсын гэрээнд иргэний хэргийг хянан шийдвэрлэх талаар Монгол Улсын хууль тогтоомжид зааснаас өөр журам тогтоосон бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**236 дугаар зүйл.** Монгол Улсын шүүхэд үл хамаарах эрх

Гадаад улсаас туг улсад суугаа дипломат эрх ямба, дархан эрх эдэлдэг иргэн нь сайн дураар захирагдсанаас бусад тохиолдолд Монгол Улсын шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарагдахгүй.

**237 дугаар зүйл.** Шүүхэд эрх олгох

Монгол Улсын шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааны эрх хэмжээнд хамаарагдахгүй эд хөрөнгийн маргааныг тус улсын шүүхийн эрх хэмжээнд хамаарууулах тухай зохигчид хэлэлцэн тохирч болно.

**238 дугаар зүйл.** Шүүхийн харьяалал

Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн хийсэн гадаад хэлцлээс үүссэн маргааны шүүхийн газар нутгийн ба шүүхийн харьяаллыг зохигчид харилцан тохиролцсоноор өөрчилж болно.

**239 дүгээр зүйл.** Олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх

Монгол Улсын Үндсэн хуульд харшлахгүй бол шүүх энэ хуулийн 237 дугаар зүйлийн дагуу маргааныг хянан шийд-

эрлээхдээ олон улсын нийтээр зөвшөөрсөн хэм хэмжээг төсөөтэй хэрэглэж болно.

**240 дүгээр зүйл.** Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх

Монгол Улсын шүүхийн болон гадаад улсын шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх журам нь Монгол Улсын хууль тогтоомж, гадаад улстай байгуулсан буюу Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр тодорхойлогдоно.

## АРВАН НАЙМДУГААР БҮЛЭГ

### Бусад зүйл

**241 дүгээр зүйл.** Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1. Шүүх хуралдааны журам зөрчиж хуралдаан даргалагчаас сануулга авсан этгээд зөрчил дахин гаргасан бол шүүгч түүнд 200—5000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

2. Шүүхэд хуурамч бичмэл баримт гаргаж өгсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч гэм буруутай этгээдэд 10000—25000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

**242 дугаар зүйл.** Хууль хүчин төгөлдөр болох

1. Энэ хуулийг 1994 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2. Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдөр ажиллагаанд хэргийг тухайн шатаар хянан шийдвэрлэхэд энэ хуулийг буцаан хэрэглэхгүй.

**Монгол Улсын Их Хурлын дарга** **Н. БАГАБАНДИ**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 5 дугаар сарын 9-ний өдөр

Улаанбаатар хот

## ХУУЛЬ, ЗАРЛИГ, ЗАРЛИГИЙН ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хууль батлагдсантай холбогдуулан дараахь хууль, зарлиг, зарлигийн заалтыг хүчингүй болсонд тооцсугай:

1) БНМАУ-ын Ардын Их Хурлын 1967 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн тогтоолоор батлагдсан БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хууль;

2) «БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай» Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1977 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 97 дугаар зарлиг;

3) «БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай» Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1979 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 379 дүгээр зарлигийн 2 дугаар зүйл;

4) «БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай» 1991 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн хууль;

5) «Иргэний байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай» 1992 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хууль;

6) «Иргэний байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай» 1993 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн хууль;

7) Гэр бүлийн хуулийн 27 дугаар зүйл;

8) Улсын Нотариатын хуулийн 13 дугаар зүйлийн 12, 15 дугаар зүйлийн 11 дэх заалт, 66, 67, 68, 70, 71, 72 дугаар зүйл.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1994 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**Монгол Улсын Их Хурлын дарга** **Н. БАГАБАНДИ**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 5 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### Нийтлэг үндэслэл

**1 дүгээр зүйл.** Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь нийгмийн даатгалын төрөл, хэлбэр, хамрах хүрээг тогтоож, нийгмийн даатгалд даатгуулж шимтгэл төлөх, нийгмийн даатгалын санг бүрдүүлэх, зарцуулах болон нийгмийн даатгалын байгууллага, нийгмийн даатгалын байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.** Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж

1. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл.** Нийгмийн даатгал, түүний төрөл

1. Нийгмийн даатгал нь иргэн (цаашид «даатгуулагч» гэх) олон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, жилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан хэмжээгээр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ мөн.

2. Нийгмийн даатгал дараахь төрлөөс бүрдэнэ:

1) тэтгэврийн даатгал;

2) тэтгэмжийн даатгал;

3) эрүүл мэндийн даатгал;

4) үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал;

5) ажилгүйдлийн даатгал.

**4 дүгээр зүйл.** Нийгмийн даатгалын хэлбэр, хамрах хүрээ

1. Нийгмийн даатгал нь заавал даатгуулах, сайн дураар даатгуулах гэсэн хэлбэртэй байна.

2. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн (цаашид «ажил олгогч» гэх)-тэй хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч нийгмийн даатгалд заавал даатгуулна.

Аж ахуйн нэгж, байгууллагын болон иргэний малыг тэдэнтэй байгуулсан гэрээний дагуу маллаж байгаа малчин энэ заалтад заасан «хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч»-д хамаарна.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад иргэн үйлдвэрлэл, ажил үйлчилгээ эрхэлж байгаа бол энэ хуульд заасан болзол, журмын дагуу нийгмийн даатгалд даатгуулах эсэх, түүний ямар төрлийг сонгохоо өөрөө шийдвэрлэнэ.

4. Монгол Улсад байнга оршин суудаг, тус улсын аль нэгэн байгууллагад ажиллаж байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, түүнчлэн тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулж байгаа гадаадын байгууллага, аж ахуйн нэгжид ажилладаг Монгол Улсын иргэн Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид хамаарна.

**5 дугаар зүйл.** Нийгмийн даатгалд даатгуулах гэрээ

Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт хамрагдах даатгуулагч даатгагчтай энэ хуулийн болзол журмын дагуу нийгмийн даатгалд даатгуулсан тухайгаа гэрээ байгуулна.

**6 дугаар зүйл.** Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх

1. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан болзол журмын дагуу шимтгэл төлж нийгмийн даатгалд даатгуулсан иргэн хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж авах эрхтэй.

2. Ажил олгогчийн буруугаас нийгмийн даатгалын шимтгэл төлөгдөөгүй нь тухайн даатгуулагч болон түүний гэр бүлийн гишүүдэд тэтгэвэр, тэтгэмж олгохгүй байх үндэслэл болохгүй.

3. Нийгмийн даатгалын сангаас гухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгохгүй байх нөхцөлийг хуулиар тогтоож болно.

### 7 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж сонгон авах

Даатгуулагчид нийгмийн даатгалын нэг төрлийн сангаас тэтгэвэр буюу тэтгэмжийг давхардуулж олгохгүй. Хэрэв давхардахаар байвал даатгуулагч аль нэгийг нь сонгон авах эрхтэй.

### 8 дугаар зүйл. Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох шийдвэр

1. Даатгуулагчийн өргөдөл, хуульд заасан бусад баримт бичгийг үндэслэн даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох тухай шийдвэрийг нийгмийн даатгалын байгууллага гаргана.

2. Өргөдөл шийдвэрлэх хугацааг хуулиар тогтооно.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

## Нийгмийн даатгалын сан

### 9 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангийн төрөл

Нийгмийн даатгалын төрөл тус бүр нь дараахь мөнгөн хөрөнгийн сантай байна:

1) тэтгэврийн даатгалын сан;

2) тэтгэмжийн даатгалын сан;

3) эрүүл мэндийн даатгалын сан;

4) үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан;

5) ажилгүйдлийн даатгалын сан.

### 10 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангийн орлогын эх үүсвэр

1. Нийгмийн даатгалын сангийн орлого дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

1) даатгуулагчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл;

2) ажил олгогчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл;

3) сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү;

4) нийгмийн даатгалын шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэнд оногдуулсан алданги;

5) улсын төвлөрсөн төсвөөс олгох хөрөнгө;

6) бусад эх үүсвэр.

2. Нийгмийн даатгалын сангийн орлого бүх төрлийн татвар, хураамжаас чөлөөлөгдөнө.

**11 дүгээр зүйл.** Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт

1. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг хууль тогтоомжид заасан болзол журмын дагуу дор дурдсан зориулалтаар зарцуулна:

1) тэтгэвэр, тэтгэмж олгох;

2) нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх;

3) хууль тогтоомжид заасан бусад төлбөр, зардлыг санхүүжүүлэх.

2. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол нэг төрлийн сангийн хөрөнгийг өөр төрлийн санд шилжүүлэн зарцуулах, зориулалтын бус чиглэлээр ашиглах, байршуулахыг хориглоно.

Харин зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд нэг төрлийн сангийн хөрөнгөөс өөр төрлийн санд 3 хүртэл сарын хугацаагаар түр шилжүүлэн ашиглаж болно.

**12 дугаар зүйл.** Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийг батлах

1. Нийгмийн даатгалын сан тус бүрийн жилийн орлого, зарлагын төсвийг нийгмийн даатгалын орон нутгийн байгууллагын саналыг харгалзан нийгмийн даатгалын төв байгууллага боловсруулах бөгөөд уг төсвийг нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар батална.

2. Нийгмийн даатгалын тодорхой төрлийн санд улсын төвлөрсөн төсвөөс энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө үүссэн үүргийн дагуу тэтгэвэр, тэтгэмжид олгох хөрөнгийг жил бүр Төсвийн тухай хуулиар тогтооно.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар батлагдсан хөрөнгийг Сангийн яам сарын хуваарийн дагуу тухайн сарын эхний 10 хоногт багтаан зохих санд шилжүүлж байна.

**13 дугаар зүйл.** Нийгмийн даатгалын сангийн тайлан тэнцэл гаргах, тайлагнах

1. Нийгмийн даатгалын төв байгууллага нь нийгмийн даатгалын сан тус бүрийн орлого, зарлагын байдалд хяналт тавьж, тайлан тэнцлийг дор дурдсан хугацаанд улирал, жилээр нэгтгэн гаргаж Үндэсний зөвлөлд тайлагнаж байна:

1) нийгмийн даатгалын сан тус бүрийн орлого, зарлагын тайланг сум, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага улирлын дараа сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагад, аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын байгууллага тухайн улирлын дараа сарын 20-ны дотор нийгмийн даатгалын төв байгууллагад тус тус ирүүлнэ;

2) нийгмийн даатгалын төв байгууллага нь нийгмийн даатгалын сан тус бүрийн улирлын нэгдсэн тайланг дараа улирлын хоёр дахь сарын 5-ны дотор; жилийн эцсийнхийг дараа оны 2 дугаар сарын 20-ны дотор тус тус нэгтгэн санал, дүгнэлтийн хамт Үндэсний зөвлөлд оруулна;

3) Үндэсний зөвлөл нь улирлын тайланг дараагийн улирлын сүүлийн сарын 10-ны дотор, жилийн тайланг дараагийн жилийн 1 дүгээр улиралд багтааж хянан хэлэлцэнэ.

2. Нийгмийн даатгалын сан тус бүрийн орлогын зарцуулагдаагүй үлдэгдэл (зарлагаас давсан орлого)-ийг зайлшгүй шаардлагатай тохиолдолд нийгмийн даатгалын зохих дээд шатны байгууллага тухайн төрлийн санд нь улиралд 1 удаа зөвлөрүүлж болно. Хэрэв уг үлдэгдлийн дараагийн сар, улиралд шилжүүлэн зарцуулах шаардлагатай бол нийгмийн даатгалын зохих дээд шатны байгууллагын зөвшөөрөл авна.

**14 дүгээр зүйл.** Нийгмийн даатгалын сангийн бүртгэл, тайлан

1. Нийгмийн даатгалын орон нутгийн байгууллага даатгалын бүх төрлийн санд төлсөн шимтгэлийн хэмжээг ажил олгогч, даатгуулагч тус бүрээр тэдэнд олгосон нийгмийн даатгалын дэвтэр, гэрчилгээг үндэслэн бүртгэнэ.

2. Нийгмийн даатгалын санд хөрөнгө төвлөрүүлэх, сангийн хөрөнгийг зарцуулах анхан шатны бүртгэлийн маягт, түүнийг хөтлөх, тайлан гаргах журмыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Нийгмийн даатгалын шимтгэл

**15 дугаар зүйл.** Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, төлөх хугацаа

1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө:

| Даатгалын төрөл | Төлөх шимтгэлийн хувь хэмжээ (хувиар) | |
|---|---|---|
| | ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос | даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос |
| 1) тэтгэврийн даатгал | 13,5 | 5,5 |
| 2) тэтгэмжийн даатгал | 1,0 | 1,0 |
| 3) үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал | 1,0 ба 2,0 | — |
| 4) ажилгүйдлийн даатгал | 0,5 | 0,5 |

2. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлвөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас батлагдсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дор дурдсан хувиар тооцсон дүнгээс багагүй байна:

1) тэтгэврийн даатгал 9,5 хувь
2) тэтгэмжийн даатгал 1,0 хувь
3) үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал 1,0 хувь

3. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл (хураамж)-ийн хувь хэмжээг Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулиар тогтооно.

4. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хамаарагдах даатгуулагчийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг ажил олгогч бүрэн төлнө.

5. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний

даатгалын шимтгэлийг 2,0 хувиар төлөх ажил олгогчийн жагсаалтыг Засгийн газар батална.

**16 дугаар зүйл.** Нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам

1. Ажил олгогч нь даатгуулагчийн төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг түүнд хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого олгох бүртээ энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр тооцон суутгаж, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын байгууллагын төвлөрсөн харилцах дансанд шилжүүлнэ.

2. Шимтгэлийн тайлан буюу ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, шимтгэл тодорхойлох хуудсыг үндэслэн шимтгэлийн тооцоог хийх бөгөөд төлбөрийг бэлэн бус тооцооны журмаар гүйцэтгэнэ. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагч шимтгэлийг бэлнээр төлж болно.

3. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сарын төлөх шимтгэлийг дараа сарын 5-ны дотор төлсөн байна. Шимтгэл төлөх, тайлагнах эцсийн хугацаа нийгмийн даатгалын төрөл бүрт нэг адил байна. Хэрэв энэ хугацаа долоо хоног бүрийн амралт, нийтээр амрах баярын өдөртэй давхацвал дараагийн ажлын өдөр шимтгэлийг төлж тайлагнана.

4. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн шимтгэл төлөх тооцоог тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодогч, мөн зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн шимтгэл төлөх тооцоог нийгмийн даатгалын байгууллагын ажилтан гүйцэтгэнэ.

5. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын байгууллага нь монголын харьяат ажиллагчдын төлөх шимтгэлийг хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулж төлнө.

6. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагч шимтгэлээ даатгагчтай байгуулсан гэрээнд заасны дагуу өөрөө төлнө.

**17 дугаар зүйл.** Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэл төлөх үүрэг

1. Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ:

1) хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;

2) шимтгэл оногдуулах, төлөхтэй холбогдсон мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гаргаж даатгалын байгууллагад ирүүлэх;

3) нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцэл гаргах;

4) нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд уг зөрчлийг арилгах талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх.

2. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэл төлөх талаар даатгагчтай байгуулсан гэрээнд заасан үүрэг хүлээнэ.

**18 дугаар зүйл.** Шимтгэл төлөх үүрэг дуусгавар болох, бусдад шилжих, уг үүргийг түдгэлзүүлэн зогсоох

1. Шимтгэл төлөх үүрэг дараахь тохиолдолд дуусгавар болно:

1) даатгуулагч нас барсан, нас барсанд тооцогдсон;

2) ажил олгогч татан буугдсан, дампуурсан;

3) даатгалын гэрээний хугацаа дуусгавар болсон;

4) хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон.

2. Ажил олгогч нэгдэх, салах буюу бусад хэлбэрээр өөрчлөн байгуулагдвал шимтгэл төлөх үүрэг нь шинээр бий болсон этгээдэд шилжинэ.

3. Энэ хуулийн 19 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу даатгуулагч гомдол гаргах нь шимтгэл төлөх үүргийг зогсоох буюу дуусгавар болгох үндэслэл болохгүй. Гагцхүү уг гомдлыг хянаж байгаа тухайн шатны шүүхийн шийдвэрээр шимтгэл төлөхийг түдгэлзүүлэн зогсоож болно.

4. Ажил олгогч дампуурсан буюу өөр үндэслэлээр татан буугдсан бол татан буулгах комисс буюу нэхэмжлэгчдийн зөвлөл нь төлөгдөөгүй шимтгэлийг уг ажил олгогчийн эд хөрөнгөөс хуульд заасан журмаар гаргуулж нийгмийн даатгалын зохих санд оруулна.

**19 дүгээр зүйл.** Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэл төлөх талаар эдлэх эрх

Ажил олгогч, даатгуулагч шимтгэл төлөх талаар дараахь эрх эдэлнэ:

1) нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-ын шалгалтын акттай танилцах, шаардлагатай бол тайлбар хийх;

2) шимтгэл оногдуулалт, төлөлт, шалгалтын дүнгийн талаар тайлбар авах буюу өгөх;

3) нийгмийн даатгалын байгууллага, түүний ажилтны буруугаар учирсан хохирлыг хуульд заасан журмын дагуу нөхөн төлүүлэх;

4) илүү төлсөн шимтгэлийг эргүүлэн авах буюу дараа төлөх шимтгэл тооцон суутгуулах;

5) нийгмийн даатгалын байгууллага, түүний ажилтны хууль бус ажиллагаа, шийдвэрийн талаарх гомдлоо эрх бүхийн дээд шатны байгууллага, албан тушаалтанд, улмаар тэдгээрийн шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гаргах.

**20 дугаар зүйл.** Хариуцлага

1. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол нийгмийн даатгалын шимтгэл төлөгчид дараахь хариуцлага хүлээлгэнэ:

1) ажил олгогч шимтгэл оногдох хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогыг нуусан буюу хэмжээг нь санаатай бууруулсан бол нуусан буюу бууруулсан орлогод оногдох шимтгэлийг нөхөн төлүүлж, гэм буруутай этгээдэд 10000—25000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна;

2) дутуу төлөгдсөн буюу хугацаандаа төлөгдөөгүй шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0,3 хувийн алданги ногдуулах боловч алдангийн нийт хэмжээ нь дутуу буюу хугацаандаа төлөгдөөгүй шимтгэлийн 50 хувиас хэтэрч болохгүй;

3) тооцооны алдаа гаргаснаас шимтгэлийг дутуу төлсөн бол дутуу төлсөн шимтгэлийг нөхөн төлүүлж, уг шимтгэлийн дүнгээс тооцооны алдаа гарснаас хойшхи хугацааны хоног тутамд 0,1 хувийн алданги ногдуулах боловч алдангийн нийт хэмжээ дутуу төлсөн шимтгэлийн 30 хувиас хэтэрч болохгүй;

4) хууль тогтоомжид заасан бусад хариуцлага.

2. Жуурамч баримт бичиг бүрдүүлэх, худал мэдээлэх зэргээр тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг үндэслэлгүй, эсхүл илүү тогтоолгож авсан бол үндэслэлгүй буюу илүү авсан тэтгэгэр, тэтгэмж, төлбөрийг нөхөн төлүүлж 5000—25000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

3. Тэтгэвэр, тэтгэмжийг хугацаанд нь олголгүй сааттуулсан бол уг тэтгэвэр, тэтгэмжийн дүнгээс саатуулсан хэмжээг тухайн даатгуулагчийн тэтгэвэр тэтгэмжийг олгож байгаа банкны иргэдийн хадгаламжийн (хугацаагүй) тухайн үеийн хүүгээр бодож алданги олгоно.

4. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчид энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 2, 3 дахь хэсэг хамаарна.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Нийгмийн даатгалын байгууллага

**21 дүгээр зүйл.** Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо

1. Нийгмийн даатгалын байгулулагын тогтолцоо нь нийгмийн даатгалын төв байгууллага (Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар), аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага (хэлтэс), сумын нийгмийн даатгалын тасаг (ажилтан)-аас бүрдэнэ.

2. Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын дэргэд нэг талаас ажил олгогч, даатгуулагч, нөгөө талаас нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан санал зөрөөг хянаж шийдвэрлэх гомдлын шаардлагын зөвлөл (орон тооны бус) ажиллана.

3. Нийгмийн даатгалын байгууллагын болон энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан зөвлөлийн дүрмийг Засгийн газар батална.

**22 дугаар зүйл.** Нийгмийн даатгалын байгууллагын удирдлага

1. Нийгмийн даатгалын төв байгууллага нь нийгмийн даатгалын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний орон нутгийн байгууллага нь тухайн шатны Засаг дарга болон нийгмийн даатгалын дээд шатны байгууллагын удирдлагын дор ажиллана.

2. Нийгмийн даатгалын төв байгууллага нь орон нутгийн байгууллага мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

3. Нийгмийн даатгалын төв байгууллагын даргыг нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлтэй зөвшилцөж нийгмийн даатгалын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн, орон нутгийн байгууллагын даргыг нийгмийн даатгалын дээд

шатны байгууллагын даргатай зөвшилцөж тухайн шатны Засаг дарга томилно.

**23 дугаар зүйл.** Нийгмийн даатгалын байгууллага, нийгмийн даатгалын байцаагчийн үйл ажиллагааны зарчим

Нийгмийн даатгалын байгууллага өөрийгөө санхүүжүүлэх, нийгмийн даатгалын байцаагч хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах, даатгуулагч, ажил олгогчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэн хамгаалах зарчим баримтлана.

**24 дүгээр зүйл.** Нийгмийн даатгалын байгууллагын чиг үүрэг

Нийгмийн даатгалын байгууллага дараахь үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1) нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;

2) нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах;

3) нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах;

4) улсын нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх;

5) доод шатны байгууллагынхаа үйл ажиллагаанд хяналт тавих;

6) хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

**25 дугаар зүйл.** Нийгмийн даатгалын байгууллагын эрх

1. Нийгмийн даатгалын байгууллага дараахь эрх эдэлнэ:

1) анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөөгүйгээс хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох боломжгүй болсон ажил олгогчид түүнтэй адилтгах үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа ажил олгогчийн жишгээр шимтгэл оногдуулах;

2) тогтоосон хугацаанд шимтгэл төлөөгүй ажил олгогчийн банкин дахь харилцах дансны зарлагын гүйлгээг шимтгэлээ төлж дуустал түр зогсоох;

3) нийгмийн даатгалын байцаагчаас тавьсан актад заасан шимтгэл, алданги, хүү, торгуулийг хугацаанд нь төлөөгүй бол

уг шимтгэл, алданги, хүү, торгуультай тэнцэх хэмжээний хөрөнгийг зохих хууль тогтоомжийн дагуу гаргуулах;

4) илүү төлсөн шимтгэлийг дараагийн сар, улирал, жилийн төлбөл зохих шимтгэлд суутган тооцох буюу шимтгэл төлөгч хүсвэл тооцоо хийснээс хойш 30 хоногийн дотор эгүүлэн олгох;

5) шимтгэл, алданги, хүү, торгууль төлөхөөс зайлсхийсэн, шимтгэлийн мэдээ тайланг хугацаанд нь ирүүлээгүй, нийгмийн даатгалын байгууллагын хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ аваагүй ажил олгогчид хуульд заасан хариуцлага хүлээлгэх;

6) нийгмийн даатгалын доод шатны байгууллагын гаргасан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл хүчингүй болгох буюу өөрчлөх;

7) нийгмийн даатгалын хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, бусад холбогдох баримт бичгийг ажил олгогч болон даатгуулагчаас үнэ төлбөргүй гаргуулах.

**26 дугаар зүйл.** Нийгмийн даатгалын байцаагчийн эрх, хариуцлага

1. Нийгмийн даатгалын байгууллагад 3-аас доошгүй жил ажиллаж мэргэшсэн, мэргэжлийн өндөр зэрэгтэй нийгмийн даатгалын байгууллагын ажилтанд нийгмийн даатгалын төв байгууллагын саналыг үндэслэн нийгмийн даатгалын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний шийдвэрээр нийгмийн даатгалын байцаагчийн эрх олгоно.

Нийгмийн даатгалын байцаагчийн дүрмийг Засгийн газар батална.

2. Нийгмийн даатгалын байцаагч дараахь эрх эдэлнэ:

1) шимтгэл оногдуулах, төлөхтэй холбогдсон данс бүртгэл, тайлан тэнцэл болон санхүүгийн бусад баримтад хяналт шалгалт хийх, тайлбар, лавлагаа гаргуулж авах;

2) зөвхөн нийгмийн даатгалын хяналт шалгалтад шаардагдах магадлагаа, баримтын хуулбарыг ажил олгогчийн харилцагч банк, санхүүгийн байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулах;

3) шимтгэл оногдох орлого нууцыг гэрчлэх баримтыг ажил олгогч болон даатгуулагчаас түр хугацаагаар хураан авах, хуулбарлах;

4) ажил олгогч нь бусдад олгосон хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод оногдох шимтгэлийг суутган авч

нийгмийн даатгалын санд төлөөгүй байвал зохих шимтгэлийг ажил олгогчийн өөрийнх нь хөрөнгөөс нөхөн төлүүлэх;

5) ажил олгогч болон даатгуулагчид энэ хуульд заасан хариуцлага хүлээлгэх;

6) даатгуулагч, ажил олгогч хууль бус үйл ажиллагаа явуулж байгааг албан үүргээ гүйцэтгэх явцад илрүүлэн холбогдох байгууллагад мэдэгдэх.

3. Шимтгэл төлөхтэй холбогдсон хууль бус үйл ажиллагааг нууух, шимтгэлийн орлогыг хувийн зорилгод ашиглах, хээл хахууль авах, эрхээ хэтрүүлэх зэргээр албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нийгмийн даатгалын байцаагчид хууль тогтоомжид заасан сахилгын, захиргааны, эд хөрөнгийн болон эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

27 **дугаар зүйл.** Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл

1. Даатгагч, даатгуулагч, ажил олгогчийг тус тус төлөөлсөн гишүүдээс бүрдсэн нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл (орон тооны бус)-ийг байгуулж ажиллуулна. Гурван талын төлөөлөгчийн тоо адил байна.

2. Үндэсний зөвлөлийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн тэргүүлэх бөгөөд бүрэлдэхүүнийг нь Засгийн газар батална.

3. Үндэсний зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлт болон нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын байдалд хөндлөнгийн хяналт тавих;

2) нийгмийн даатгалын үйл ажиллагааны талаар нийгмийн даатгалын байгууллагын тайлан, мэдээллийг сонсон хэлэлцэж санал, дүгнэлт гаргах, шаардлагатай асуудлыг холбогдох байгууллагад оруулж шийдвэрлүүлэх;

3) нийгмийн даатгалын асуудлаар зөвлөмж гаргах;

4) эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс болон гомдлын шаардлагын зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, иргэдээс гаргасан гомдлыг барагдуулах арга хэмжээ авах;

5) хууль тогтоомжид заасан бусад тодорхой бүрэн эрх.

4. Үндэсний зөвлөлийн дүрмийг Засгийн газар батална.

5. Үндэсний зөвлөлийн гишүүдэд ажлын оролцоог харгалзан уллирал тутам цалингийн нэмэгдэл олгож болно. Цалингийн нэмэгдлийн дээд хэмжээг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтоно.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Эмнэлэг хөдөлмөрийн магадлагаа

**28 дугаар зүйл.** Эмнэлэг хөдөлмөрийн магадлагааны тухай ойлголт

Хүмүүсийн оюун ухаан, мэдрэхүй, бие бялдрын хэвийн үйл ажиллагаа нь алдагдаж тахир дутуу (хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу хагас (хэсэгчлэн) алдсан) болсон шалтгаан, түүний хувь хэмжээ, хугацааг тогтоох мэргэжлийн үйл ажиллагааг эмнэлэг хөдөлмөрийн магадлагаа гэнэ.

**29 дүгээр зүйл.** Эмнэлэг хөдөлмөрийн магадлагаа тогтоох ажлыг эрхлэх байгууллага

1. Эмнэлэг хөдөлмөрийн магадлагаа тогтоох ажлыг нарийн мэргэжлийн эмч, нийгмийн даатгалын болон эзэд, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөгчдөөс бүрдсэн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс эрхлэн гүйцэтгэнэ.

2. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь ердийн өвчин, ахуйн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалт, түүний хувь хэмжээ, хугацааг тогтооно.

3. Нийгмийн даатгалын төв байгууллагын дэргэд эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс, аймгийн болон нийслэлийн дүүргийн нийгмийн даатгалын байгууллагын дэргэд эмнэлэг хөдөлмөрийн магадлах орон нутгийн комисс ажиллана.

Суманд эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс байгуулан ажиллуулж болно.

4. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрмийг Засгийн газар батална.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

### Бусад заалт

**30 дугаар зүйл.** Нийгмийн даатгалын баримт бичиг

1. Даатгуулагч улсын дугаар бүхий нийгмийн даатгалын дэвтэртэй байна.

2. Татварын албаны төв, орон нутгийн байгууллагад хууль ёсоор бүртгэгдэж, шимтгэл төлдөг ажил олгогч улсын дугаар бүхий нийгмийн даатгалын бүртгэлийн гэрчилгээтэй байна.

**31 дүгээр зүйл.** Нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх

1. Нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нийгмийн даатгалын шимтгэлийн орлогоос санхүүжүүлнэ.

2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогоос нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх нормативыг Улсын Их Хурал тогтооно.

**32 дугаар зүйл.** Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дундажыг тодорхойлох

Даатгуулагчийн шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүн, дундажыг тодорхойлох журмыг Засгийн газар тогтооно.

**33 дугаар зүйл.** Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих

Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ.

**Монгол Улсын Их Хурлын дарга** **Н. БАГАБАНДИ**

**МОНГОЛ УЛСЫН**
**ХУУЛЬ**

1994 оны 6 дугаар сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

# НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

## Нийтлэг үндэслэл

**1 дүгээр зүйл.** Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу шимтгэл төлж тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.** Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн төрөл

1. Тэтгэврийн даатгалын сангаас даатгуулагчид олгох тэтгэмж дор дурдсан төрөлтэй байна:

1) өндөр насны тэтгэвэр;

2) тахир дутуугийн тэтгэвэр;

3) тэжээгчээ алдсаны тэтгэвэр.

2. Тэтгэмжийн даатгалын сангаас даатгуулагчид олгох тэтгэмж дор дурдсан төрөлтэй байна:

1) хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж;

2) оршуулгын тэтгэмж.

**3 дугаар зүйл.** Шимтгэл төлсөн хугацаа

1. Энэ хуулийн дагуу олгох тэтгэвэр, тэтгэмжийг шимтгэл төлсөн хугацааг харгалзан тогтооно.

2. Шимтгэл төлсөн нийт хугацааг тодорхойлохдоо тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын шимтгэлийг ажил олгогчоос болон даатгуулагч өөрөө төлсөн нийт хугацааны дээр шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцохоор хуульд заасан бусад хугацааг нэмж тооцно.

3. Төр, аж ахуйн нэгж, байгууллагаас дараахь хугацааны шимтгэлийг тэтгэвэрийн болон тэтгэмжийн даатгалын санд төлсөнн тохиолдолд эдгээр хугацааг шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцно:

1) хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч болон төрийн албан хаагч аж ахуйн нэгж, байгууллагын захиалгаар ажлаас чөлөөгдөөж суралцсан хугацаа;

2) цэргийн жинхэнэ албыг байлдагч, түрүүчээр хаасан хугацаа;

3) тэтгэмжтэй чөлөө авч хүүхдээ асарсан хугацаа;

4) хууль бусаар ажлаас зайлуулагдан мөрдөгдсөн, хилс хэргээр хорих ял эдэлсэн хугацаа;

5) хууль бусаар ажлаас халагдсан хугацаа;

6) иргэний хамгаалалтын болон бусад дайчилгааны хугацаа;

7) хуульд заасан бусад хугацаа.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацааны шимтгэл төлөх журмыг Засгийн газар тогтооно.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Өндөр насны тэтгэвэр

**4 дүгээр зүйл.** Өндөр насны тэтгэвэр авах эрх

1. Нийтдээ 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

2. Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан өрөв, түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол өсгөсөн эх 0-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн, 0 нас хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

3. Газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд эхцөлд ажилласан даатгуулагч дор дурдсан болзлыг хангасан бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй:

1) нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 10-аас доошгүй жил нь газрын дор ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 55 нас хүрсэн бол;

2) нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 10-аас доошгүй жил нь хөдөлмөрийн хортой, халуун нөхцөлд ажиллаж тэт-

гэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 50 нас хүрсэн, түүнчлэн нийтдээ 20-иос доошгүй жил, түүнээс 7 жил 6 сараас доошгүй хугацаагаар мөн нөхцөлд ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй 45 нас хүрсэн бол;

3) нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 12 жил 6 сараас доошгүй хугацаагаар хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 55 нас хүрсэн, түүнчлэн нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс, 10-аас доошгүй жил нь мөн нөхцөлд ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй 50 нас хүрсэн бол.

4. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нас хүрээгүй даатгуулагч мөн хэсэгт заасан шимтгэл төлөх хугацааг хаингаад цаашид тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхөө зогссоосон байхад түүний уг насанд хүрээд өндөр насны тэтгэврээ тогтоолгон авах эрх нь хадгалагдана.

5. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10-аас 20 хүртэл жил төлсөн 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй шимтгэл төлсөн нийт хугацаандаа ногдох өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож авах эрхтэй.

**5 дугаар зүйл.** Өндөр насны тэтгэврийн хэмжээ, нэмэгдэл

1. Өндөр насны тэтгэврийг даатгуулагчийн сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого (цаашид «хөдөлмөрийн хөлс» гэх)ын 45 хувиар тогтооно.

2. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 жилээс илүү төлсөн жил тутамд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон хөдөлмөрийн хөлсний 1,5 хувиар бодож нэмэгдэл олгоно.

3. Тахир дутуугийн тэтгэвэр авч байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон даатгуулагчийн тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан жил тутамд нь 1 хувиар бодож нэмэгдүүлнэ.

4. Өндөр насны тэтгэврийн доод хэмжээ нь Засгийн газраас тогтоосон сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (цаашид «хөдөлмөрийн баталгаат хөлс» гэх)-ийн 75 хувиас багагүй байна.

**6 дугаар зүйл.** Өндөр насны тэтгэвэр олгох хугацаа

Өндөрр насны тэтгэврийг даатгуулагч өргөдлөө тэтгэвэр тогтоолгох насанд хүрэхээс өмнө гаргасан бол уг насанд хүрсэн өдрөөс, хэрэв тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэнээс хойш гаргасан бол өргөдлийг даатгагч хүлээн авсан өдрөөс эхлэн, нас барсны дараагийн сар дуустал олгоно.

# ГУРАВДУГААР БҮЛЭГ

## Тахир дутуугийн тэтгэвэр

**7 дугаар зүйл.** Тахир дутуугийн тэтгэвэр авах эрх

1. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 20-иос доошгүй жил, эсхүл тахир дутуу болохын өмнөх 5 жилийн 3 жилд нь төлсөн даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа байнга буюу удаан хугацаагаар алдаж тахир дутуу болсон бол тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шимтгэл төлөх хугацааг хангаагүй даатгуулагч нийтдээ 3-аас доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байвал шимтгэл төлсөн нийт хугацаандаа ногдох тахир дутуугийн тэтгэврийг хувь хэнцүүлэн тогтоолгож авах эрхтэй.

**8 дугаар зүйл.** Тахир дутуу болсныг тогтоох

1. Тахир дутуу болсныг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан, хагас (хэсэгчлэн) алдсан гэж ангилна.

2. Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, түүний хугацааг эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс тогтооно.

3. Тахир дутуу болсныг тогтооход баримтлах өвчний жагсаалтыг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

**9 дүгээр зүйл.** Тахир дутуугийн тэтгэврийн хэмжээ

1. Даатгуулагч хөдөлмөрийн чадвараа бүрэн алдаж тахир дутуу болсон бол тахир дутуугийн тэтгэврийг түүний хөдөлмөрийн хөлснөөс энэ хуулийн 5 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан хувь хэмжээгээр тогтооно.

2. Даатгуулагч хөдөлмөрийн чадвараа хагас алдаж тахир дутуу болсон бол тахир дутуугийн тэтгэврийг түүний хөдөлмөрийн хөлсний энэ хуулийн 5 дугаар зүйлийн 1,2 дахь хэсэгт заасан хувь хэмжээнд ногдох хэсгээс хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээгээр бодож тогтооно.

3. Тахир дутуугийн тэтгэврийн доод хэмжээ өндөр насны тэтгэврийн доод хэмжээтэй адил байна.

**10 дугаар зүйл.** Тахир дутуугийн тэтгэвэр олгох хугацаа

Тахир дутуугийн тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа алдсан өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл,

хэрэв тэтгэвэр авагч нас барвал нас барсны дараагийн сар дуустал олгоно.

**11 дүгээр зүйл.** Тахир дутуу болсныг нөхөн тогтоож, тэтгэврийг нөхөн олгох

1. Хүндэтгэх шалтгаанаар эмнэлэг хөдөлмөрийн магадлагаа тогтоолгож чадаагүй даатгуулагчийн тахир дутуу болсныг нөхөн тогтоосон бол 2 сараас хэтрэхгүй хугацааны тэтгэврийг нөхөн олгоно.

2. Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээгдэхгүй болсны улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан хугацааг сунгасан буюу нөхөн тогтоосон бол тухайн хугацааны тэтгэврийг нөхөн олгож болно. Хэрэв энэ хугацаанд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ өөрчлөгдвөл урьд тогтоогдсон тэтгэврийн хэмжээг баримтлан тэтгэврийг нөхөн олгоно.

3. Тахир дутуугийн тэтгэвэр авч байсан даатгуулагч хөдөлмөрийн чадвараа нөхөн сэргээгдсэнээс хойш 6 сарын дотор дахин тахир дутуу болсон тохиолдолд түүнд урьд тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгоход баримталсан хөдөлмөрийн хөлсний хэмжээ, шимтгэл төлсөн хугацааг үндэслэн тэтгэвэр тогтооно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Тэжээгчээ алдсаны тэтгэвэр

**12 дугаар зүйл.** Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх

1. Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шимтгэл төлөх хугацааг хангасан тэжээгч ердийн өвчний ахуйн ослын улмаас нас барвал түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй дор дурдсан гишүүд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй:

1) хууль ёсоор тэжээх өөр хүн байгаа эсэхийг харгалзахгүйгээр төрүүлсэн буюу үрчлэн авсан 16 нас (сургууль, суралцаж байгаа бол 19 нас) хүрээгүй хүүхэд (үүнд эцэг нас барснаас хойш мэндэлсэн, төрсөн хүүхэд нь хамаарна);

2) хууль ёсоор тэжээх өөр хүнгүй 16 нас хүрээгүй ач, зээ, төрсөн дүү;

3) тэжээгчийн асрамжид байсан төрөлхийн тахир дутуу буюу 16 нас хүрээгүй байхдаа тахир дутуу болсон хүүхэд ач, зээ, төрсөн ах, эгч, дүү;

4) эрэгтэй нь 60, эмэгтэй нь 55 нас хүрсэн буюу эсхүл ахир дутуу болсон эцэг, эх, эхнэр, нөхөр, хууль ёсоор тэхээх өөр хүнгүй өвөг эцэг, эмэг эх, төрсөн ах, эгч, дүү;

5) гнайман нас хүрээгүй хүүхэд, хууль ёсоор асрах хүнгүй эрсөн дүү, ач, зээг нь асарч ажил хийгээгүй байгаа эцэг, х буюу нөхөр, эхнэрийн аль нэг (нас, хөдөлмөрийн чадвагыг харгалзахгүйгээр).

2. Дор дурдсан иргэд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэр үлийнн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн нэгэн адил тэхээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй:

1) өндөр насны, эсхүл тахир дутуугийн тэтгэвэр авч байаад нас барсан, түүнчлэн нас барахын өмнөх саруудад хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан даатгуулагчийн гэр бүийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд;

2) дагавар хүүхэд нь тэжээгч байгаад нас барсан бол ойт эцэг, эх нь төрсөн эцэг, эхийн адил;

3) төрсөн эцэг, эхээс шүүхийн шийдвэрээр тэтгэлэг авдагүй хүүхэд хойт эцэг буюу эхийгээ нас барахад төрсөн хүүхийн адил;

4) даатгуулагч сураггүй алга болсон нь шүүхийн шийдэрээр тогтоогдож, уг шийдвэр хүчинтэйд тооцогдсон тохиололд түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд.

3. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 5-аас доошгүй жилл, үүнээс сүүлийн 1 жил нь тасралтгүй төлсөн тэхээгч нас барсан бол гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй ишүүд нь түүний шимтгэл төлсөн нийт хугацаанд ногдох хжээгчээ алдсаны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож ах эрхтэй.

**13 дугаар зүйл.** Тахир дутуу иргэнд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоох

Тэжээгч нь нас барсан бөгөөд өөр төрлийн тэтгэвэр авдагй тахир дутуу иргэнд хөдөлмөрийн чадвараа бүрэн алдн хугацаанд нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоон олгожлно.

**14 дүгээр зүйл.** Тэжээгчээ алдсаны тэтгэврийн хэмжээ, нэмэгдэл

1. Тэжээгчээ алдсаны тэтгэврийг нас барсан даатгуулагйн авч байсан хөдөлмөрийн хөлсний энэ хуулийн 5 дугаар ялийн 1,2 дахь хэсэгт заасан хувь хэмжээнд ногдох хэсс дор дурдсан хувь хэмжээгээр бодож тогтооно:

| Гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоо | тэтгэвэр бодох хувь хэмжээ (хувиар) |
|---|---|
| 3, түүнээс дээш | 100 |
| 2 | 75 |
| 1 | 50 |

2. Тахир дутуугийн тэтгэвэр авч байсан тэжээгч нас барсан бол тэжээгчээ алдсаны тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан жил тутамд нь 1,0 хувиар бодож нэмэгдүүлнэ.

**15 дугаар зүйл.** Тэжээгчээ алдсаны тэтгэвэр олгох хугацаа

Тэжээгчээ алдсаны тэтгэврийг тэжээгч нь нас барсан өдрөөс эхлэн хүүхдэд 16 нас (сургуульд суралцаж байгаа бол 19 нас) хүртэл, тахир дутуу иргэнд хөдөлмөрийн чадвараа алдсан хугацаанд нь, тэтгэврийн насанд хүрсэн иргэнд нас барсны дараагийн сар дуустал тус тус олгоно.

**16 дугаар зүйл.** Тэжээгчээ алдсаны тэтгэврийг нэгтгэн тогтоох

Тэжээгчээ алдсаны тэтгэврийг гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй бүх гишүүнд нэгтгэн нэг тэтгэвэр тогтооно. Харин тогтоосон тэтгэврийг тэдний хүсэлтээр хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд адил хэмжээгээр хуваан олгож болно.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж

**17 дугаар зүйл.** Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрх

1. Ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдахаас өмнө 3, түүнээс дээш сарын хугацаагаар тэтгэмжийн даатгалын шимтгэл төлж ажилласан даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрхтэй.

2. Хүүхдээ 196 хоног хүртэл тээгээгүй дутуу төрүүлсэн буюу үр хөндүүлсэн эмэгтэйчүүд (даатгуулагч) хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрхтэй.

**18 дугаар зүйл.** Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн хэмжээ

1. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг харгалзан түүний сүүлийн бүтэн ажилласан гурван сарын хөдөлмөрийн хөлснөөс дор дурдсан хувь хэмжээгээр бодож олгоно:

| Шимтгэл төлж ажилласан хугацаа (жилээр) | Тэтгэмж бодох хувь хэмжээ (хувиар) |
|---|---|
| 5 хүртэл жил | 45 |
| 5-аас 14 жил | 55 |
| 15, түүнээс дээш жил | 75 |

2. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажлын өдрөөр тооцно.

**19 дүгээр зүйл.** Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох хугацаа

1. Хөдөлмөрийн чадвар түр хугацаагаар алдсан эхний 6 өдрийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажил олгогчоос, 7 дахь өдрөөс эхлэн чадвар нь сэргээгдэх, эсхүл тахир дутуугийн тэтгэвэр авах эрх үүсэх хүртэл хугацааны тэтгэмжийг тэтгэмжийн даатгалын сангаас тус тус олгоно.

2. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох хугацааны нэг удаагийн дээд хязгаар нь хөдөлмөрийн чадвар алдсан эхний 6 хоногийг оролцуулан 78 хоногоос хэтрэхгүй байна. Харин хорт хавдар болон сүрьеэгээр анх өвчлөхөд 156 хоногийн хугацаанд тэтгэмж олгож болно.

3. Даатгуулагч хуанлийн жилд удаа дараа өвчилсөн тохиолдолд хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг нийтээ 156 хоногоос илүүгүй хугацаанд олгоно.

4. Даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж өвч дуусаны дараа тэтгэмжийн даатгалын санд 3 сараас доошгүй хугацаагаар шимтгэл төлсөн нөхцөлд дахин тэтгэмж авах эрх үүснэ.

5. Хөдөлмөрийн чадвар түр алдсан хугацааг мэргэжлийн хяналтын байгууллагын эмчилгээний чанарын хяналтын комисс, уг комисс байхгүй бол ерөнхий эмч, эрхлэгч, их эмч олгоно.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

### Оршуулгын тэтгэмж

**20 дугаар зүйл.** Оршуулгын тэтгэмж авах эрх

1. Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг нийтдээ 36 сараас доошгүй хугацаагаар төлсөн даатгуулагч ердийн өвчин, гахуйн ослын улмаас нас барвал түүний оршуулгад зориулан оршуулгын тэтгэмж олгоно.

2. Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан бол оршуулгын тэтгэммжийг шимтгэл төлсөн хугацааг харгалзахгүйгээр олгоно.

3. Нийгмийн даатгалын тухай хуульд заасан тэтгэвэрр, тэтгэмж авч байсан иргэн нас барвал түүний оршуулгадд зориулан оршуулгын тэтгэмж олгоно.

**21 дүгээр зүйл.** Оршуулгын тэтгэмжийн хэмжээ

Оршуулгын тэтгэмжийн хэмжээ нь хөдөлмөрийн батаалгаат хөлсний 6 сарын нийлбэртэй тэнцүү байна.

## ДОЛООДУГААР БҮЛЭГ

### Тэтгэвэр, тэтгэмж тогтоох, олгох

**22 дугаар зүйл.** Тэтгэвэр тогтоолгох хөдөлмөрийн хөлсийг тодорхойлох

1. Тэтгэвэр тогтоолгох хөдөлмөрийн хөлсийг даатгуулагч тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх аль дуртай дараалсан 5 жилд төлсөн шимтгэлээс тооцож гаргасан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос дор дурдсан журмаар бодож тодорхойлно:

1) даатгуулагч сар бүр шимтгэл төлж байсан бол таван жилийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийг мөн хугацаанд шимтгэл төлсөн нийт сарын тоонд хуваана;

2) даатгуулагч сар бүр шимтгэл төлөх боломжгүй байсан бол таван жилийн туршид авсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийг 60-д хуваана.

2. Даатгуулагч 5 жилээс доош хугацаанд шимтгэл төлсөн байх болзлоор тэтгэвэр тогтоолгох тохиолдолд тэтгэвэр тогтоолгох хөдөлмөрийн хөлсийг тодорхойлохдоо төлсөн шимт

өлээс нь тооцож гаргасан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийг шимтгэл төлсөн нийт сарын тоонд хуваажк бодно.

3. Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж хөдөлмөрийн хөлийг 19991 оноос өмнөх үеийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос бодож тодорхойлохдоо даатгуулагч тэтгэвэр тогтоолгохоор хүсэлт гаргасан үеийн болон 1991 оны хөдөлмөрийн баталгаат хөлсийг харьцуулж гаргасан индексээр тэтгэвэр тогтоолгогчийн 1991 оноос өмнөх үеийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг өөрчлөн тооцно.

**23 дугаар зүйл.** Тэтгэврийг хувь тэнцүүлэн бодох

Тэтгэврийг хувь тэнцүүлэн бодохдоо энэ хуульд заасан шимтгэлл төлөх хугацааг бүрэн хангасан нөхцөлд тухайн даатгуулагчинд тогтоогдвол зохих сарын тэтгэврийг шимтгэл төлөөл зохих хугацааны нийт сарын тоонд хуваж, шимтгэл төлсөн нийт сарын тоогоор үржүүлж тооцно.

**24 дүгээр зүйл.** Тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох өргөдөл гаргах, шийдвэрлэх хугацаа

1. Тэтгэвэр тогтоолгох өргөдөл, хуульд заасан холбогдох баримт бичгийг дор дурдсан хугацаанд бүрдүүлж нийгмийн даатгалын байгууллагад өгнө:

1) өндөр насны тэтгэвэр тогтоолгох даатгуулагч тэтгэвэр тогтоолгон авахыг хүссэн хугацаандаа;

2) тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгох даатгуулагч тахир дутуу болсноос хойш 14 хоногийн, хэрэв хүндэтгэх шалтгаантай байсан бол 3 сарын дотор;

3) тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд тэжээгчээ нас барснаас хойш 1 хоногийн, хэрэв хүндэтгэх шалтгаантай байсан бол 3 сарын дотор.

2. Ажил олгогч өөрөөсөө шаардагдах баримт бичгийг саадгүй бүрдүүлж өгөх үүрэгтэй.

3. Нийгмийн даатгалын байгууллага тэтгэвэр тогтоох үндэслэлтэй өргөдөл, холбогдох баримт бичгийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

4. Тэтгэмж авах өргөдөл, хуульд заасан холбогдох баримт бичгийг дор дурдсан хугацаанд бүрдүүлж нийгмийн даатгалын байгууллагад өгнө:

1) хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсан өдрөөс хойш 4 до-

лоо хоногийн, хэрэв хүндэтгэх шалтгаантай байсан бол 6 сарын дотор;

2) оршуулгын тэтгэмж авах иргэн даатгуулагчийг нас барснаас хойш 4 долоо хоногийн, хэрэв хүндэтгэх шалтгаантай байсан бол 6 сарын дотор.

5. Нийгмийн даатгалын байгууллага тэтгэмж авах өргөдлийг хүлээж авснаас хойш хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох асуудлыг 21 хоногийн дотор, оршуулгын тэтгэмж олгох асуудлыг 24 цагийн дотор шийдвэрлэнэ.

**25 дугаар зүйл.** Тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичиг

1. Тэтгэвэр тогтоолгоход дор дурдсан баримт бичиг бүрдүүлнэ:

1) нийгмийн даатгалын дэвтэр;

2) даатгуулагч 1995 оноос өмнө ажиллаж байсан бол хөдөлмөрийн дэвтэр;

3) даатгуулагч 1995 оноос өмнө ажилласан хугацаанд авсан хөдөлмөрийн хөлснөөс тэтгэвэр тогтоолгохыг хүсвэл хөдөлмөрийн хөлсний тодорхойлолт;

4) тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын тухай эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр;

5) тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн төрсний гэрчилгээ, ам бүлийн тодорхойлолт;

6) энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан болзлоор тэтгэвэр тогтоолгоход хүүхдүүдийн төрсний гэрчилгээ.

2. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг нийгмийн даатгалын дэвтэр, эмнэлгийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудсыг, оршуулгын тэтгэмжийг нас барсан тухай гэрчилгээг үндэслэн олгоно.

3. Тэтгэвэр, тэтгэмж тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журмыг нийгмийн даатгалын төв байгууллага тогтооно.

**26 дугаар зүйл. Тэтгэвэр, тэтгэмж олгох**

1. Нийгмийн даатгалын байгууллага тэтгэврийг үйлчлэгч банкаар дамжуулан сар бүр олгоно.

2. Нас хөгширсөн, өвчилсөн гэх мэт хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр тэтгэврээ авах чадваргүй болсон иргэний тэтгэврийг хууль ёсны итгэмжлэгдсэн хүнд нь

ьсхүл нийгмийн даатгалын байгууллага гэрээр нь хүргэн өгч үйлчилнэ.

3. Сэтгэл мэдрэлийн өвчтэй иргэнд болон 16-гаас доош насны хүүхдэд тогтоогдсон тэтгэврийг тэдний эцэг эхэд, эсхүл асран хамгаалагчид нь олгоно. Хэрэв эдгээр хүмүүс байхгүй бол хууль ёсны харгалзан дэмжигчид нь олгож болно.

4. Асрамжийн газарт асруулж байгаа тэтгэвэр авагчид урьд тогтоогдсон тэтгэврийнх нь 30 хувийг олгож болно.

5. Нийгмийн даатгалын байгууллага өөрийнх нь хүсэлтээр тэтгэврийг тэтгэвэр авагчийн хадгаламжинд шилжүүлэн олгож болно.

6. Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг нийгмийн даатгалын байгууллага ажил олгогчоор дамжуулан олгож төлвөл зохих шимтгэлээс нь суутган тооцно.

7. Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, түүнчлэн оршуулгын тэтгэмжийг нийгмийн даатгалын байгууллагаас олгоно.

8. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны нэг сараас дээш хугацааны тэтгэмжийг 14 хоног тутам бодож олгоно.

**27 дугаар зүйл.** Тэтгэвэр, тэтгэмж олголтыг түдгэлзүүлэн зогсоох

Хуурамч бичиг баримт бүрдүүлснээс тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсээгүй байхад тэтгэвэр буюу тэтгэмж тогтоолгон авсан нь тогтоогдвол түүний олголтыг түдгэлзүүлэн зогсооно.

## НАЙМДУГААР БҮЛЭГ

### Бусад заалт

**28 дугаар зүйл.** Тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтоох

1. Дор дурдсан тохиолдолд тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтооно:

1) авч байгаа тэтгэврийг нь тогтооход баримталсан шимтгэл төлсөн хугацаа, хөдөлмөрийн хөлсний хэмжээ өөрчлөгдөх үндэслэлтэй болсон нь тогтоогдож тэтгэвэр авагч хүсэлтээ гаргасан;

2) хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоо өөрчлөгдсөн.

2. Нийгмийн даатгалын байгууллага тэтгэврийн хэмжээг өөрчлөх асуудлыг өргөдөл, холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэх бөгөөд өргөдлийг тухайн сарын 15-наас өмнө хүлээж авсан бол мөн сарын 1-нээс, тухайн сарын 15-наас хойш хүлээж авсан бол дараа сарын 1-нээс тус тус эхлэн өөрчлөгдсөн тэтгэврийг олгоно.

3. Тэтгэвэр авагч нь энэ зүйлийн 1 дэх хэгийн 2-т заасан өөрчлөлтийн талаар нийгмийн даатгалын байгууллагад тухай бүр мэдэгдэх үүрэгтэй.

**29 дүгээр зүйл.** Тэтгэвэр, тэтгэмжээс суутгал хийх

1. Тэтгэвэр, тэтгэмжээс дор дурдсан үндэслэлээр суутгал хийж болно:

1) тэтгэвэр, тэтгэмж авагч хуурамч бичиг баримт бүрдүүлснээс болон энэ хуулийн 28 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан үүргээ өөрийн буруугаас болж биелүүлээгүйгээс үндэслэлгүй буюу илүү авсан тэтгэвэр, тэтгэмжийг төлүүлэх тухай шүүхийн эсхүл нийгмийн даатгалын байгууллагын шийдвэр гарсан бол;

2) тэтгэвэр, тэтгэмж авагчийн төлвөл зохих энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаас бусад төлбөрийг түүний тэтгэвэр буюу тэтгэмжээс нь төлүүлэхээр шүүхийн шийдвэр гарсан бол.

2. Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны алдаагаар буруу олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийг гэм буруутай албан тушаалтан хариуцна.

3. Нэг удаагийн суутгалын хэмжээ нь тэтгэмжийн болон сарын тэтгэврийн 50 хувиас хэтэрч болохгүй.

4. Энэ зүйлд зааснаас бусад тохиолдолд тэтгэвэр, тэтгэмжээс суутгал хийхийг хориглоно.

**30 дугаар зүйл.** Тэтгэврийн хэмжээг өөрчлөх индекс

Аньжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан тэтгэврийн хэмжээг өөрчлөх индексийг нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

**31 дүгээр зүйл.** Гадаад улсаас ирсэн Монгол Улсын иргэн болон гадаадын харьяат иргэнд тэтгэвэр тогтоох

Хувийн журмаар гадаадад байнга оршин суух байгаад эх орондоо байнга амьдрахаар бүрмөсөн ирсэн болон мөн жур-

маар гадаадад байнга оршин суугаа Монгол Улсын иргэд, түүнчлэн Монгол Улсад байнга оршин суухаар ирснээс хойш тус улсад ажиллаагүй гадаадын харьяат иргэдэд тэтгэвэр тогтоох, олгох асуудлыг Монгол улсаас тухайн улстай байгуулсан нийгэм хангамжийн хэлэлцээр болон олон улсын гэрээний дагуу шийдвэрлэнэ.

**Монгол Улсын Их Хурлын дарга** **Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 6 дугаар сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

# НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### Нийтлэг үндэслэл

**1 дүгээр зүйл.** Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгох, төлбөр өгөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.** Үйлдвэрлэлийн осол

1. Даатгуулагч хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлд-

вэрлэлийн хүчин зүйлийн үйлчлэлд өртөж эрүүл мэндээр хохирох, амь насаа алдахыг «үйлдвэрлэлийн осол» гэнэ.

2. Дараахь нөхцөл байдалд гарсан үйлдвэрлэлийн осолд даатгуулагч өртсөн тохиолдолд энэ хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгоно:

1) ажлын байрандаа болон бусад газарт ажил үүргээ гүйцэтгэх явцад;

2) ажил эхлэхийн өмнө ажилд бэлтгэх буюу дууссаны дараа ажлын байр, багаж хэрэгслээ эмхлэж цэгцлэх үед;

3) ажилдаа ирэх, буцах замд.

3. Даатгуулагч хөдөлмөрлөх үүргээ гүйцэтгэвэл зохих хугацаанд дур мэдэн өөр ажил гүйцэтгэх болон ажлын байраа орхиж яваад, түүнчлэн согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсний болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимыг санаатай зөрчсөний улмаас осолд өртсөн, гэмт хэрэг үйлдэх үедээ өөрийн биед гэмтэл учруулсан нь нотлогдсон тохиолдолд түүнд энэ хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгохгүй.

4. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан тохиолдлыг сум, дүүргийн Засаг даргын томилсон байнгын комисс (орон тооны бус) судлан тогтооно.

Уг комиссын бүрэлдэхүүнд даатгагч, даатгуулагч, ажил олгогчийн ашиг сонирхлыг тэнцүү тоогоор төлөөлсөн төлөөлөгчдийн болон ослын шинж чанартай холбогдсон мэргэжлийн ажилтныг оролцуулж, төрийн захиргааны байгууллагын төлөөлөгчөөр ахлуулна.

5. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан комиссын дүрмийг Засгийн газар батална.

**3 дугаар зүйл.** Мэргэжлээс шалтгаалсан өвчин

1. Даатгуулагч хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалан өвчилснийг «мэргэжлээс шалтгаалсан өвчин» гэнэ.

2. Мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалтыг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

**4 дүгээр зүйл.** Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагчид дор дурдсан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгоно:

1) тахир дутуугийн тэтгэвэр;
2) тэжээгчээ алдсаны тэтгэвэр;
3) хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж;
4) хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Тахир дутуугийн тэтгэвэр

**5 дугаар зүйл.** Тахир дутуугийн тэтгэвэр авах эрх

1. Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа удаан хугацаагаар буюу байнга алдаж тахир дутуу болсон бол тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

2. Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс тогтооно.

**6 дугаар зүйл.** Тахир дутуугийн тэтгэврийн хэмжээ

1. Тахир дутуугийн тэтгэврийг даатгуулагчийн сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого (цаашид «хөдөлмөрийн хөлс» гэх)-оос хөдөлмөрийн чадвараа 10 хүртэл хувиар алдсан бол 10 хувиар, 10-аас дээш хувиар алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээгээр тогтооно.

2. Хөдөлмөрийн чадвараа 30, түүнээс дээш хувиар алдаж тахир дутуу болсон даатгуулагчийн тахир дутуугийн тэтгэврийн хэмжээ нь Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй байна.

**7 дугаар зүйл.** Тахир дутуугийн тэтгэвэр олгох хугацаа

Энэ хуульд заасан тахир дутуугийн тэтгэврийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан хугацаанд олгоно.

**8 дугаар зүйл.** Тахир дутуугийн тэтгэвэр олгох

1. Тахир дутуугийн тэтгэврийг нийгмийн даатгалын байгууллага үйлчлэгч банкаар дамжуулан сар бүр олгоно.

2. Хөдөлмөрийн чадвараа 30 хүртэл хувиар байнга алдсан даатгуулагчийн 6 жилд ногдох, удаан хугацаагаар алдсан даатгуулагчийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоос тогтоосон хугацаанд ногдох тахир дутуугийн тэтгэврийг өө-

рийнх нь хүсэлтээр нэг удаа олгож болно. Энэ тохиолдолд уг тэтгэврийг тогтоолгосон шалтгаанаар тахир дутуугийн тэтгэвэр авах эрх дуусгавар болно.

**9 дүгээр зүйл.** Тахир дутуу болсныг нөхөн тогтоох, тэтгэврийг нөхөн олгох

1. Эмнэлэг хөдөлмөрийн магадлагааг хүндэтгэн үзэх шалтгаанаар тогтоолгож чадаагүй байсан даатгуулагчийн тахир дутуу болсныг нөхөн тогтоосон бол 6 сараас илүүгүй хугацааны тэтгэврийг нөхөн олгоно.

2. Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар нь нөхөн сэргээгдэхгүйгээр тогтоогдсон бол тухайн хугацааны тэтгэврийг бүрэн нөхөж олгоно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Тэжээгчээ алдсаны тэтгэвэр

**10 дугаар зүйл.** Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх

1. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас даатгуулагч нас барсан бол түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

2. Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах гэр бүлийн гишүүдийг тогтоохдоо Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийг баримтална.

**11 дүгээр зүйл.** Тэжээгчээ алдсаны тэтгэврийн хэмжээ

Тэжээгчээ алдсаны тэтгэврийг нас барсан даатгуулагчийн авч байсан хөдөлмөрийн хөлснөөс дор дурдсан хувь хэмжээгээр тогтооно:

1) хөдөлмөрийн чадваргүй хүний тоо 3 ба түүнээс дээш бол 100 хувь;

2) хөдөлмөрийн чадваргүй хүний тоо 2 бол 75 хувь;

3) хөдөлмөрийн чадваргүй хүний тоо 1 бол 50 хувь.

**12 дугаар зүйл.** Тэжээгчээ алдсаны тэтгэвэр олгох хугацаа

Энэ хуульд заасан тэжээгчээ алдсаны тэтгэврийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан хугацаанд олгоно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж

**13 дугаар зүйл.** Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрх

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдсан даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрхтэй.

**14 дүгээр зүйл.** Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн хэмжээ

1. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдсан даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг шимтгэл төлж ажилласан хугацааг үл харгалзан хөдөлмөрийн хөлсний 100 хувиар бодож олгоно.

2. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажлын өдрөөр тооцно.

**15 дугаар зүйл.** Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох хугацаа

1. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хөдөлмөрийн чадвар алдсан өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх, эсхүл тахир дутуугийн тэтгэвэр тогтоогдох эрх үүсэх хүртэл хугацаанд олгоно.

2. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох хугацааны дээд хязгаар нь дараалсан 12 сарын дотор 180 хоногоос хэтрэхгүй байна.

3. Хөдөлмөрийн чадвар түр алдсан хугацааг мэргэжлийн эмнэлгийн байгууллагын эмчилгээний чанарын хяналтын комисс, уг комисс байхгүй бол эмнэлгийн ерөнхий эмч, эрхлэгч, их эмч тогтооно.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр

**16 дугаар зүйл.** Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр авах эрх

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа 30 ба түүнээс дээш хувиар

алдсан даатгуулагч хиймэл эрхтэн, засал эмчилгээ (протез, ортопед) хийлгэх, рашаан сувилалд эмчлүүлэхэд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр авах эрхтэй.

**17 дугаар зүйл.** Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, түүнийг олгох

1. Монгол Улсад хийдэг хиймэл эрхтэн, засал эмчилгээ (протез, ортопед) хийлгэсний эхний удаагийн үнийг 100 хувь, 2 удаагийн үнийн 50 хувийг олгоно.

2. Зайлшгүй шаардлагаар мэргэжлийн (гэмтлийн) эмнэлгийн байгууллагын дүгнэлтийн дагуу засал эмчилгээ (протез, ортопед)-г гадаад оронд хийлгэхэд түүний нэг удаагийн үнийг олгож болно.

3. Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас рашаан сувилалд эмчлүүлж сувилуулбал үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас жилд нэг удаа төлбөр гаргуулж болно.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

### Бусад заалт

**18 дугаар зүйл.** Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичиг

Тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан баримт бичиг болон үйлдвэрлэлийн ослын акт буюу мэргэжлээс шалтгаалсан өвчний тодорхойлолтыг бүрдүүлнэ.

**19 дүгээр зүйл.** Даатгалын хөнгөлөлт

1. Үйлдвэрлэлийн ослыг багасгах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах талаар зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авсны дүнд ажил олгогч 5 жил дараалан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас төлбөр гаргуулаагүй бол дараагийн жилд төлөх даатгалын шимтгэлийг 10 хувиар хөнгөлж болно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан болзлыг үргэлжлүүлэн хангасан тохиолдол бүрт хөнгөлөлт 10 хувиар нэмэгдэх боловч түүний дээд хэмжээ нь жилд төлөх шимтгэлийн 50 хувиас хэтэрч болохгүй.

**20 дугаар зүйл.** Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр тогтоож олгохтой холбогдсон бусад харилцааг зохицуулах

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр тогтоож олгохтой холбогдсон энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн холбогдох заалтаар зохицуулна.

**Монгол Улсын Их Хурлын дарга** **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ

1994 оны 6 дугаар сарын 9-ний өдөр

Улаанбаатар хот

# НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу шимтгэл төлж ажилгүйдлийн даатгалд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.** Ажилгүйдлийн тэтгэмж авах эрх

1. Даатгуулагч ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажилгүй болохоосоо өмнө 24 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 9 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд ажилгүйдлын тэтгэмж авах эрх анх үүснэ.

2. Урьд нь ажилгүйдлийн тэтгэмж авсан даатгуулагч ажилгүйдлийн даатгалын шимтгэл 6 сар төлсөн нөхцөлд тэтгэмж авах эрх нь дахин үүснэ.

**3 дугаар зүйл.** Ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ

1. Ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг харгалзан сүүлийн 3 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас дор дурдсан хувь хэмжээгээр тооцож олгоно:

| Шимтгэл төлж ажилласан хугацаа (жилээр) | Тэтгэмж бодох хувь хэмжээ (хувиар) |
|---|---|
| 1. 5 хүртэл жил | 45 |
| 2. 5—10 хүртэл жил | 50 |
| 3. 10—15 хүртэл жил | 60 |
| 4. 15, түүнээс дээш | 70 |

2. Ажилгүйдлийн тэтгэмжийн доод хэмжээ Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй байна.

**4 дүгээр зүйл.** Ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацаа

Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг Хөдөлмөрийн хуульд зааснаар ажлаас халагдсаны тэтгэмж авч байгаа бол түүнийг авч дууссаны дараагийн өдрөөс, хэрэв ажлаас халагдсаны тэтгэмж олгогдоогүй бол энэ хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлснийй дараагийн өдрөөс тус тус эхлэн ажлын 76 өдөр дуустал хугацаанд олгоно.

**5 дугаар зүйл.** Ажилгүй болсноо бүртгүүлэх

Ажлаас халагдсан даатгуулагч ажил олгогчтойгоо тооцоо хийж дууссанаас хойш 14 хоногийн дотор оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ хөдөлмөрийн биржид, уг бирж байхгүй бол нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй.

**6 дугаар зүйл.** Ажилгүйдлийн тэтгэмж авах өргөдөл гаргах, шийдвэрлэх хугацаа

1. Даатгуулагч ажил олгогчтой хууль тогтоомжийн дагуу тооцоо хийж дууссаны дараа ажилгүйдлийн тэтгэмж авах өргөдлөө хуульд заасан холбогдох баримт бичгийн хамт оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ хөдөлмөрийн биржид, уг бирж байхгүй бол нийгмийн даатгалын байгууллагад гаргана.

2. Хөдөлмөрийн бирж буюу нийгмийн даатгалын байгууллага нь ажилгүйдлийн тэтгэмж олгох асуудлыг өргөдөл, холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

**7 дугаар зүйл.** Ажилгүйдлийн тэтгэмж олгох

Ажилгүйдлийн тэтгэмжийг хөдөлмөрийн бирж, уг бирж байхгүй бол нийгмийн даатгалын байгууллага сард 2 удаа тооцож олгоно.

**8 дугаар зүйл.** Ажилгүйдлийн тэтгэмжийг хасах

Дараахь нөхцөлд даатгуулагчид олговол зохих ажилгүйдлийн тэтгэмжээс ажлын 36 өдөрт оногдохыг нь хасна:

1) өөрийн хүсэлтээр хөдөлмөрийн гэрээгээ цуцалсан;

2) хөдөлмөрийн сахилгыг удаа дараа буюу ноцтой зөрчсөний улмаас захиргааны санаачлагаар ажлаас халагдсан.

**9 дүгээр зүйл.** Ажилгүйдлийн тэтгэмжийг зогсоох

1. Дараахь нөхцөлд даатгуулагчид олгож байгаа ажилгүйдлийн тэтгэмжийг зогсооно:

1) хөдөлмөрийн биржээс боловсролын түвшин, мэргэжлийн чиглэлийг нь харгалзан санал болгосон ажлын байранд ажиллахаас 2 удаа татгалзсан;

2) хөдөлмөрийн бирж, нийгмийн даатгалын байгууллага, ажил олгогчоос зохион байгуулсан цалин хөлстэй түр ажилд хүндэтгэх шалтгаангүйгээр ороогүй;

3) даатгалын байгууллагаас сургалтын зардлыг нь хариуцаж зохион байгуулсан мэргэжлийн сургалтанд ороогүй;

4) хорих ял эдлүүлэх тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон.

2. Хөдөлмөрийн биржээс санал болгосон дор дурдсан ажлын байранд даатгуулагч ажиллахаас татгалзах нь ажилгүйдлийн тэтгэмжийг зогсоох үндэслэл болохгүй:

1) хөдөлмөрийн хамтын маргааны улмаас түр чөлөөлөгдсөн ажлын байранд;

2) эрүүл мэндээр тэнцэхгүй болсон, ажил олгогч татан буугдсан, орон тоо нь хасагдсан, ажилтны тоог цөөрүүлсэн үндэслэлээр захиргааны санаачилгаар ажлаас халагдсан даатгуулагчийн урьд хамрагдаж байсан хамтын гэрээний нөхцөлөөс дордсон нөхцөлтэй ажлын байранд.

3. Даатгуулагч энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2-т зааснаар болон бусад хэлбэрээр түр ажил, хөдөлмөр эрхэлсэн бол түүний тэтгэмжийг түдгэлзүүлэн зогсоож тэтгэмж олгох хугацааг уг ажил, хөдөлмөр гүйцэтгэсэн хоногоор сунгана.

**10 дугаар зүйл.** Ажилгүйдлийн тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичиг

Даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж тогтоолгоход дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

1) өргөдөл;

2) нийгмийн даатгалын дэвтэр;

3) ажлаас халсан тухай шийдвэр.

**11 дүгээр зүйл.** Ажилгүйдлийн даатгалын хөнгөлөлт

1. Ажил олгогч болон даатгуулагч 5 жил дараалан ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж гаргуулаагүй бол дараагийн жилд төлөх даатгалын шимтгэлийг 10 хувиар хөнгөлнө.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан болзлыг үргэлжлүүлэн хангасан тохиолдол бүрт хөнгөлөлт 10 хувиар нэмэгдэх боловч түүний дээд хэмжээ нь жилд төлөх шимтгэлийн 50 хувиас хэтэрч болохгүй.

**12 дугаар зүйл.** Мэргэжлийн сургалтанд хамруулах Хөдөлмөрийн бирж, нийгмийн даатгалын байгууллага нь ажилгүйдлийн тэтгэмж авч байгаа даатгуулагчийг мэргэжлийн болон давтан сургалтанд хамруулж, холбогдох зардлыг ажилгүйдлийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.

**Монгол Улсын Их Хурлын дарга** **Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Улаанбаатар хот

## ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ХУУЛЬ, ХУУЛИЙН ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Тэтгэмжийн хуулийн 5 дугаар зүйлийн «Хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг БНМАУ-ын Тэтгэврийн сангаас,» гэснийг хасаж, «хүүхэд асарсны» гэсний дараа «жирэмсний болон амаржсаны» гэж нэмж оруулсугай.

**2 дугаар зүйл.** Тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн «хөдөлмөрийн чадвар түр алдсаны» гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.** Дараахь хууль, хуулийн заалтыг хүчингүй болсонд тооцсугай:

1) Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль;

2) Тэтгэмжийн хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 6, 7, 8, 9 дүгээр зүйл;

3) Тэтгэврийн хуулийн 73 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 27, 44, 47, 48 дугаар зүйлээс бусад зүйл, заалтууд.

**4 дүгээр зүйл.** Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хууль 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

**Монгол Улсын Их Хурлын дарга** **Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 7 дугаар сарын 5-ны өдөр

Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИУДЫГ ХЭРЭГЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хууль хүчин төгөлдөр болох

Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулиуд (цаашид «Нийгмийн даатгалын тухай хуулиуд» гэх)-ыг 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**2 дугаар зүйл.** Хөнгөлөлттэй тэтгэвэр тогтоолгох эрх хадгалагдах

Дор дурдсан иргэн өөрөө хүсвэл 1998 оны 1 дүгээр сарын 1 хүртэлх хугацаанд хөдөлмөрийн гэрээгээ дуусгавар болгож Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй:

1) нийтдээ 32 жил ажилласан 55 нас хүрсэн эрэгтэй, 27 жил ажилласан 50 нас хүрсэн эмэгтэй;

2) мэргэжлийн урлагийн байгууллагад гоцлол дуучин, бүжигчин, агаарын болон хэрэглэлийн гимнастик, акробат, тэнцвэр, уран нугаралт, хүнд жингийн үзүүлбэрийн жүжигчин, зэрлэг араатан, ан амьтан сургаж тоглуулагч, хөөмийчин, найрал хөгжмийн үлээвэр хөгжимчнөөр 20-иос доошгүй жил, эсхүл нийтдээ 25-аас доошгүй жил, түүнээс 15-аас доошгүй жил уг мэргэжлээрээ ажилласан иргэн;

3) төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын албан хаагч, иргэний агаарын тээврийн нисэх бүрэлдэхүүн, инженер, техник, диспетчерийн албаны албан тушаалын зэрэглэлтэй ажилтнаар 25-аас доошгүй жил ажилласан иргэн;

4) эрэгтэй нь 15-аас доошгүй жил ажилласан 45 нас хүрсэн, эмэгтэй нь 10-аас доошгүй жил ажилласан 40 нас хүрсэн бүрэн хараагүй болон дүлий, одой иргэн;

5) төрсөн болон 3 хүртэл настайд нь үрчилж авсан 16 хүртэл насны 4, түүнээс дээш өнчин хүүхэдтэй үлдэж хүүхдээ 6 настай болтол нь дангаараа өсгөж хүмүүжүүлсэн 20-иос доошгүй жил ажилласан 50 нас хүрсэн эрэгтэй.

**3 дугаар зүйл.** Нийгмийн даатгалд даатгуулсанд тооцох

Нийгмийн даатгалын тухай хуулиуд хүчин төгөлдөр болох хүртэл хугацаанд ажиллагчдын цалингийн сангаас нийгмийн даатгалын шимтгэл төлсөн төр, хувийн өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага, түүний дотор хоршооллын байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажилласан бүх иргэнийг мөн хугацаанд нийгмийн даатгалд (ажилгүйдлийн даатгалаас бусад төрөлд) даатгуулсанд тооцож уг хугацааг тухайн иргэний шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцно. Үүнд хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүдийн нэгдэлдээ ажилласан хугацаа нэгэн адил хамаарна.

**4 дүгээр зүйл.** Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**Монгол Улсын Их Хурлын дарга** **Н. БАГАБАНДИ**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 6 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

## ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### Нийтлэг үндэслэл

**1 дүгээр зүйл.** Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Зэвсэгт хүчин, хилийн болон дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, хорих ял эдлүүлэх байгууллагын генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч (энэ хуульд цаашид «цэргийн албан хаагч» гэх) нарт тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.** Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль тогтоомж

Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

**3 дугаар зүйл.** Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн төрөл

1. Цэргийн тэтгэвэр дор дурдсан төрөлтэй байна:

1) цэргийн жинхэнэ алба болон тагнуул, цагдаа, хорих ял эдлүүлэх байгууллагад алба хаасны тэтгэвэр (цаашид «цэргийн алба хаасны тэтгэвэр» гэх);

2) тахир дутуугийн тэтгэвэр;

3) тэжээгчээ алдсаны тэтгэвэр.

2. Цэргийн тэтгэмж дор дурдсан төрөлтэй байна:

1) хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж;

2) оршуулгын тэтгэмж;

3) нэг удаагийн тэтгэмж.

**4 дүгээр зүйл.** Цэргийн тэтгэвэр, тэтгэмж авах албан хаагч

Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийг дор дурдсан албан хаагч авах эрхтэй:

1) Зэвсэгт хүчний цэргийн жинхэнэ албаны генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч;

2) хилийн цэргийн жинхэнэ албаны генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч;

3) дотоодын цэргийн жинхэнэ албаны генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч;

4) тагнуулын байгууллагын генерал офицер, ахлагч;

5) цагдаагийн болон хорих ял эдлүүлэх байгууллагын генерал, офицер, ахлагч, байлдагч;

6) дайчилгааны сургууль цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн.

**5 дугаар зүйл.** Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийг санхүүжүүлэх эх үүсвэр

Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийг улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлнэ.

**6 дугаар зүйл.** Цэргийн тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах хугацаа

Цэргийн тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах хугацаанд цэргийн жинхэнэ алба болон тагнуул, цагдаа, хорих ял эдлүүлэх байгууллагад алба хаасан нийт хугацааг тооцно.

**7 дугаар зүйл.** Цэргийн тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын дундаж цалин хөлсийг тодорхойлох

Цэргийн тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын дундаж цалин хөлсийг тодорхойлох журмыг Засгийн газар тогтооно.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Цэргийн алба хаасны тэтгэвэр

**8 дугаар зүйл.** Цэргийн алба хаасны тэтгэвэр авах эрх

1. Зэвсэгт хүчин, хилийн болон дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, хорих ял эдлүүлэх байгууллагад 25-аас доошгүй жил алба хаасан эрэгтэй, 20-иос доошгүй жил алба хаасан эмэг-

тэй, байлдааны нисдэг тэрэгний нисгэгчээр 23-аас доошгүй жил, байлдааны тийрэлтэт сөнөөгч онгоцны жинхэнэ нисгэгчээр 20-иос доошгүй жил алба хаасан генерал, офицер, ахлагч, байлдагч нас харгалзахгүйгээр цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааг хангаагүй боловч 10-аас доошгүй жил цэргийн жинхэнэ алба болон тагнуул, цагдаа, хорих ял эдлүүлэх байгууллагад алба хаасан цэргийн албан хаагч дор дурдсан шалтгаанаар халагдсан бол цэргийн алба хаах насны хязгаарт хүрээд цэргийн алба хаасны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож авах эрхтэй:

1) орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлтөөр;
2) биеийн эрүүл мэндээр;
3) цэргийн алба хаах нас хэтэрч.

**9 дүгээр зүйл.** Цэргийн алба хаасны тэтгэврийн хэмжээ, нэмэгдэл

1. Цэргийн алба хаасны тэтгэврийг тэтгэвэр тогтоолгогчийн сарын дундаж цалин хөлсний 60 хувиар тогтооно.

2. Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан хугацаанаас илүү алба хаасан жил тутамд тэтгэвэр тогтоолгосон дундаж цалин хөлснөөс 1,0 хувиар бодож нэмэгдэл олгоно.

3. Цэргийн алба хаасны тэтгэврийн доод хэмжээ нь Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй байна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Тахир дутуугийн тэтгэвэр

**10 дугаар зүйл.** Тахир дутуугийн тэтгэвэр авах эрх

1. Дор дурдсан шалтгаанаар тахир дутуу болсон цэргийн албан хаагч тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй:

1) байлдааны талбарт үүрэг гүйцэтгэх, байлдааны онгоцоор нислэг үйлдэх, байлдааны галт хэрэгслэлээр буудлага хийх, тэсэрч дэлбэрэх, хорт бодистой үүргийнхээ дагуу харьцах үед гарсан ослын, түүнчлэн улсын хил хамгаалах, тагнуул, цагдаа, хорих ял эдлүүлэх байгууллагын албан үүрэг гүйцэтгэж яваад гэмт халдлагад өртсөний болон мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас;

2) энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаас бусад албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон ослын улмаас;

3) албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдолгүй осол, ердийн өвчний улмаас.

2. Цэргийн үүрэгтэн дайчилгааны сургууль, цугларалтад оролцож байхдаа, цэргийн жинхэнэ албанаас халагдсан байлдагч, түрүүч орон нутагтаа хүргэгдэх үед тахир дутуу болсон бол энэ хуульд заасны дагуу тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

**11 дүгээр зүйл.** Тахир дутуу болсныг тогтоох

Цэргийн албан хаагчийн тахир дутуу болсон шалтгаан, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс тогтооно.

**12 дугаар зүйл.** Тахир дутуугийн тэтгэврийн хэмжээ

1. Энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2-т заасан шалтгаанаар тахир дутуу болсон цэргийн албан хаагч (байлдагч, түрүүчээс бусад)-ид тэдний сарын дундаж цалин хөлснөөс хөдөлмөрийн чадвараа 10 хүртэл хувиар алдсан бол 10 хувиар, 10-аас дээш хувиар алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувиар бодож тахир дутуугийн тэтгэвэр тогтооно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар тогтоосон тахир дутуугийн тэтгэвэр дээр энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан шалтгаанаар тахир дутуу болсон бол тэтгэвэр тогтоолгосон дундаж цалин хөлсний 15 хувиар, мөн зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан шалтгаанаар тахир дутуу болсон бол 10 хувиар бодож тэтгэврийн нэмэгдэл олгоно.

3) Цэргийн албан хаагч (байлдагч, түрүүчээс бусад) энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан шалтгаанаар тахир дутуу болж хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан бол сарын дундаж цалин хөлсний 60 хувиар тахир дутуугийн тэтгэвэр тогтоож, 20-иос илүү алба хаасан жил тутамд тэтгэвэр тогтоолгосон сарын дундаж цалин хөлсний 1,0 хувиар тэтгэврийн нэмэгдэл олгоно. Хэрэв хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн алдсан бол сарын дундаж цалин хөлсний 60 хувьд ногдох хэсгээс хөдөлмөрийн чадвар алдалтын хувиар бодож тахир дутуугийн тэтгэвэр тогтооно.

4. Цэргийн жинхэнэ албаны байлдагч, түрүүч, түүнчлэн дайчилгааны сургууль цугларалтад оролцож байгаа цэргийн

үүрэгтэн тахир дутуу болсон бол тэдэнд цэргийн албанд татагдахын өмнө авч байсан сарын дундаж цалин хөлснөөс, хэрэв ажил хөдөлмөр эрхэлж байгаагүй бол Засгийн газраас тогтоосон тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс энэ зүйлийн 1—3 дахь хэсэгт заасан хувь хэмжээгээр тахир дутуугийн тэтгэвэр тогтооно.

5. Тахир дутуугийн тэтгэврийн доод хэмжээ нь Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй байна.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Тэжээгчээ алдсаны тэтгэвэр

**13 дугаар зүйл.** Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх

1. Цэргийн албан хаагч, түүнчлэн дайчилгааны сургууль цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн нас барахад түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрхтэй.

2. Энэ хуульд заасны дагуу тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийг баримтлан тогтооно.

**14 дүгээр зүйл.** Тэжээгчээ алдсаны тэтгэврийн хэмжээ

1. Цэргийн албан хаагч (байлдагч, түрүүчээс бусад) энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2-т заасан шалтгаанаар нас барсан бол түүний авч байсан сарын дундаж цалин хөлснөөс дор дурдсан хувиар бодож тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтооно:

1) хөдөлмөрийн чадваргүй 3, түүнээс дээш хүнтэй бол 100 хувь;

2) хөдөлмөрийн чадваргүй 2 хүнтэй бол 75 хувь;

3) хөдөлмөрийн чадваргүй 1 хүнтэй бол 50 хувь.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар тогтоосон тэжээгчээ алдсаны тэтгэвэр дээр энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан шалтгаанаар нас барсан бол тэтгэвэр тогтоолгосон цалин хөлсний 15 хувиар, мөн зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан шалтгаанаар нас барсан бол 10 хувиар бодож нэмэгдэл олгоно.

3. Цэргийн албан хаагч (байлдагч, түрүүчээс бусад) энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан шалтгаанаар нас барсан бол түүний авч байсан сарын дундаж цалин хөлсний 50 хувьд ногдох хэсгээс энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр бодож тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтооно.

4. Цэргийн жинхэнэ албаны байлдагч, түрүүч, дайчилгааны сургууль цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн нас барсан бол цэргийн албанд татагдахын өмнө авч байсан сарын дундаж цалин хөлснөөс, хэрэв ажил хөдөлмөр эрхэлж байгаагүй бол Засгийн газраас тогтоосон тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс энэ зүйлийн 1—3 дахь хэсэгт заасан хувь хэмжээгээр бодож тахир дутуугийн тэтгэвэр тогтооно.

5. Тэжээгчээ алдсаны тэтгэврийн доод хэмжээ нь Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй байна.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж

**15 дугаар зүйл.** Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрх

1. Цэргийн албан хаагч өвчилсөн, осолд өртсөний улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдахад хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрхтэй.

2. Цэргийн албан хаагч эмэгтэй хүүхдээ 196 хоног хүртэл тээгээгүй дутуу төрүүлсэн буюу үр хөндүүлсэн бол хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрхтэй.

**16 дугаар зүйл.** Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох хугацаа

1. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хөдөлмөрийн чадвараа алдсан өдрөөс эхлэн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл тахир дутуу болсон нь тогтоогдох хүртэлх хугацаанд олгоно.

2. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох хугацааны нэг удаагийн дээд хязгаар нь 13 долоо хоногоос хэтрэхгүй байна. Харин хорт хавдар болон сүрьеэгээр анх өвчлөхөд 26 долоо хоногийн хугацаанд хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгож болно.

3. Цэргийн албан хаагч хуанлийн жилд удаа дараа өвчилсөн тохиолдолд хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг нийтдээ 26 долоо хоногоос илүүгүй хугацаанд олгоно.

4. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажлын өдрөөр тооцож олгоно.

**17 дугаар зүйл.** Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн хэмжээ

1. Цэргийн албан хаагч энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2-т заасан шалтгаанаар хөдөлмөрийн чадвараа түр алдвал түүний сүүлчийн бүтэн ажилласан 3 сарын цалин хөлсний сарын дундажтай тэнцүү хэмжээгээр хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгоно.

2. Цэргийн албан хаагч энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан шалтгаанаар хөдөлмөрийн чадвар түр алдвал хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг түүний сүүлийн бүтэн ажилласан 3 сарын цалин хөлсний сарын дунджаас дор дурдсан хувь хэмжээгээр бодож олгоно:

| Алба хаасан нийт хугацаа (жилээр) | Тэтгэмж бодох хувь хэмжээ (хувиар) |
|---|---|
| 5 хүртэл жил | 50 |
| 5—14 жил | 60 |
| 15, түүнээс дээш | 80 |

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

### Нэг удаагийн тэтгэмж

**18 дугаар зүйл.** Нэг удаагийн тэтгэмж авах тохиолдол

1. Цэргийн албан хаагч нас барах, тэтгэвэрт гарах, орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр болон цэргийн алба хаах нас хэтэрч халагдах тохиолдолд нэг удаагийн тэтгэмж олгоно.

**19 дүгээр зүйл.** Нэг удаагийн тэтгэмжийн хэмжээ

1. Цэргийн албан хаагч эрэгтэй 25-аас доошгүй, эмэгтэй 20-иос доошгүй жил алба хаагаад цэргийн алба хаасны тэтгэвэрт гарахад тэдний ажиллаж байсан нөхцөл, ажлын үр

дүн, амьдралын нөхцөл байдлыг харгалзан 18—36 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно.

2. Цэргийн албан хаагч, түүнчлэн дайчилгааны сургууль цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан шалтгаанаар амь насаа алдвал 3 жилийн цалин хөлстэй тэнцэх тэтгэмжийг тухайн албан хаагчийн сарын цалин хөлсний дунджаар, хэрэв байлдагч, түрүүч, цэргийн үүрэгтэн амь насаа алдсан бол ахлагчийн сарын цалин хөлсний дунджаар тооцож тэдний ар гэрт нэг удаа олгоно.

3. Цэргийн албан хаагч орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэнд, цэргийн алба хаах насны хязгаарт хүрч халагдсан, түүнчлэн энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан шалтгаанаар нас барсан тохиолдолд түүний ажиллаж байсан нөхцөл, ажлын үр дүн, амьдралын нөхцөл байдлыг харгалзан алба хаасан 2 жил тутамд 1—2 сарын цалин хөлстэй тэнцэх тэтгэмжийг нэг удаа олгоно. Энэхүү тэтгэмжийн дээд хэмжээ нь тухайн албан хаагчийн 18 сарын цалин хөлсний нийлбэрээс илүүгүй байна.

4. Энэ зүйлийн 1, 3 дахь хэсэгт заасан нэг удаагийн тэтгэмж олгох журмыг Засгийн газар тогтооно.

## НАЙМДУГААР БҮЛЭГ

### Бусад заалт

**20 дугаар зүйл.** Оршуулгын тэтгэмж

1. Цэргийн албан хаагч, түүнчлэн дайчилгааны сургууль цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн нас барахад түүний оршуулгад зориулан оршуулгын тэтгэмж олгоно.

2. Оршуулгын тэтгэмж Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 6 сарын нийлбэртэй тэнцүү байна.

**21 дүгээр зүйл.** Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийг тогтоох, олгох байгууллага

1. Цэргийн албан хаагчийн тэтгэврийг тогтоох, олгох ажлыг нийгмийн даатгалын байгууллага эрхлэн гүйцэтгэнэ.

2. Цэргийн албан хаагчийн нэг удаагийн тэтгэмжийг төрийн захиргааны холбогдох төв байгууллага, хөдөлмөрийн өмнөх урьдчилсан шатны болон оршуулгын тэтгэмжийг тухайн нутаг дэвсгэрийн, байгууллага нь олгоно.

**22 дугаар зүйл.** Цэргийн алба хаасан хугацааг нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцох

1. Генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагчаар 10-аас доош жил алба хаасан бол уг хугацааг тухайн иргэний нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаагаар цэргийн алба хаасан иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрч өргөдлөө гаргасан нөхцөлд уг хугацаанд төлөгдсөн байвал зохих шимтгэлтэй тэнцэх хэмжээний хөрөнгийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу нийгмийн даатгалын санд шилжүүлэн төлнө.

**23 дугаар зүйл.** Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд дор дурдсан хариуцлага хүлээлгэнэ:

1) хуурамч бичиг баримт бүрдүүлэх, худал мэдээлэх зэргээр тэтгэвэр буюу тэтгэмжийг үндэслэлгүй, эсхүл илүү тогтоолгож авсан бол үндэслэлгүй буюу илүү авсан тэтгэвэр, тэтгэмжийг төлүүлж, 5000—25000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна;

2) алба хаасан хугацаа, цалин хөлсний хэмжээг санаатайгаар буруу тодорхойлсон нь тогтоогдсон бол 10000—25000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна;

3) хуульд заасан бусад хариуцлага.

**24 дүгээр зүйл.** Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийг тогтоож олгохтой холбогдсон бусад харилцааг зохицуулах

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийг тогтоож олгохтой холбогдсон энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн холбогдох заалтаар зохицуулна.

**25 дугаар зүйл.** Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**Монгол Улсын Их Хурлын дарга** **Н. БАГАБАНДИ**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 6 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

## ХУУЛИЙН ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль батлагдсантай холбогдуулан дор дурдсан хуулийн заалтуудыг хүчингүй болсонд тооцсугай:

1) Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 11 дэх хэсэг,

2) Хилийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэг;

3) Монгол Улсын аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 6, 7, 12 дахь хэсэг;

4) Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалт.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**Монгол Улсын Их Хурлын дарга** **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1994 оны 6 дугаар сарын 9-ний өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

# ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1) Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд бусад хууль тогтоомжийг нийцүүлэх;

2) Олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орох асуудлыг судлах.

2. Хуулийг тайлбарлан сурталчлах ажлыг зохион байгуулахыг Засгийн газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорт даалгасугай.

Дарга Н. БАГАБАНДИ

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1994 оны 6 дугаар сарын 9-ний өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

## МӨНГӨН ТЭМДЭГТИЙН ЗАГВАР, ТОДОРХОЙЛОЛТ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Банкны хуулийн 7 дугаар зүйл, Монголбанкны саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

«20 төгрөг», «50 төгрөг», «100 төгрөг», «200 төгрөг»-ийн зоосон мөнгөн тэмдэгтийн загвар, тодорхойлолтыг хавсралтын ёсоор тус тус баталсугай.

**Дарга** **Н. БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын 1994 оны 48 дугаар тогтоолын хавсралт

## ЗООСОН МӨНГӨН ТЭМДЭГТИЙН ЗАГВАР, ТОДОРХОЙЛОЛТ

1. Зооснуудын хэмжээ болон материал:

| | | |
|---|---|---|
| 20 төгрөг | 17,5 мм | хөнгөн цагааны хайлш |
| 50 төгрөг | 23,0 мм | хөнгөн цагааны хайлш |
| 100 төгрөг | 22,0 мм | никелийн хайлш |
| 200 төгрөг | 25,0 мм | никелийн хайлш |

2. Бүх зоосны ар талын төв хэсэгт нь Соёмбо зурж, «Монгол Улс, 1994 он» гэсэн бичгийг худам монгол үсэг, доогоор бичнэ.

3. «20 төгрөг»-ийн зооснь өвөр талд «20 төгрөг, Монголбанк» гэсэн бичгийг кирилл үсэг, араб тоогоор бичнэ.

4. «50 төгрөг»-ийн зооснь өвөр талд «50 төгрөг, Монголбанк» гэсэн бичгийг кирилл үсэг, араб тоогоор бичнэ.

5. «100 төрөг»-ийн зооснь өвөр талын голд нь Жанрайсэг сүмийн зураг байх бөгөөд «100 төгрөг, Монголбанк» гэсэн бичгийг кирилл үсэг, араб тоогоор бичнэ.

6. «200 төрөг»-ийн зооснь өвөр талын голд нь Төрийн ордны зураг байх бөгөөд «200 төгрөг, Монголбанк» гэсэн бичгийг кирилл үсэг, араб тоогоор бичнэ.

---

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1994 оны 6 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 49

Улаанбаатар хот

## АЖИЛД ТОМИЛОХ, ЦАЛИН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дашзэвэгийн Ганхуягийг Улсын Их Хурлын дэргэдэх Судалгааны төвийн захирлаар томилсугай.

2. Судалгааны төвийн захирлын сарын цалинг 19500 төгрөгөөр тогтоосугай.

Дарга Н. БАГАБАНДИ

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1994 оны 6 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

## УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ БҮРЭН ЭРХИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

Р. Одонбаатарыг Улсын Их Хурлын гишүүнээр нөхөн сонгогдсонд тооцсон тухай Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн Ерөнхий хорооны 1994 оны 01 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 17 дугаар тойргоос Улсын Их Хурлын гишүүнээр нөхөн сонгогдсон Ринчинсамбуугийн Одонбаатарын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй.

**Дарга** **Н. БАГАБАНДИ**

# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 6 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 67

Улаанбаатар хот

## ТӨРИЙН ТУГИЙГ ХҮНДЭТГЭН ЗАЛАХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

1. «Төрийн бэлгэ тэмдгийн тухай» Монгол Улсын хуулийн 10 дугаар зүйлийг үндэслэн «Монгол Улсын Төрийн тугийг хүндэтгэн залах журам»-ыг хавсралтын ёсоор батлагсугай.

2. Энэ зарлигийг 1994 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**Монгол Улсын Ерөнхийлөгч** **П. ОЧИРБАТ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1994 оны 67 дугаар зарлигийн хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ТУГИЙГ ХҮНДЭТГЭН ЗАЛАХ ЖУРАМ

### Нэг. **Ерөнхий зүйл.**

1. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу Монгол ардын хувьсгалын ойн баярын өдөр Төрийн тугийг баяр наадмын төв талбайд хүндэтгэн залахад энэ журмыг баримтлана.

2. Төрийн тугийг хүндэтгэн залах ажиллагааг төрийн хонжин, тэргүүн тугч, тугчид гүйцэтгэх бөгөөд төрийн ёслолын торгон цэрэг хамгаална. Төрийн тугийг хүндэтгэн залах

үед Төрийн хонжин энэ ажиллагаанд оролцож байгаа төрийн ёслолын торгон цэргийг захирна. Бүгд 32 морьтон оролцоно.

3. Монгол Улсын Зэвсэгт хүчний ерөнхий штабын дарга Төрийн хонжин, тэргүүн тугч, тугчдыг томилно.

4. Төрийн тугийг хүндэтгэн залахад хонжин эхэнд нь, дараа нь тэргүүн тугч, тугчид гурван эгнээгээр, удаах нь торгон цэргийн захирагч, түүний орлогч, торгон цэргүүд дөрвөн эгнээгээр цувран жагсаж явна.

5. Хонжин, тэргүүн тугч, тугчид зэрэг дэвээрээ ёслолын хувцастай, тэргүүн тугч, тугчид хуяг дуулгатай, хонжин, тэргүүн тугд цагаан зүсмийн азарга, тугчид шарга зүсмийн морь унасан байна.

Торгон цэргийн захирагч, түүний орлогч хар, цэргүүд хар, хээр, хүрэн зүсмийн морь унаж торгон цэргийн дүрэмт хувцастай сэлэм зүүсэн байна.

## ХоёР. **Төрийн тугийг Төрийн ордноос баяр наадмын төв талбайд хүндэтгэн залах**

6. Төрийн тугийг хүндэтгэн залах 32 морьтон Төрийн ордны зүүн өмнө жигүүрийн дэргэд ирээд хонжин «Мориноосоо» гээд буухад тэргүүн тугч, тугчид, торгон цэргийн захирагч, түүний орлогч, торгон цэргийн 2, 4 дүгээр цувааны цэргүүд мориноосоо нэгэн зэрэг бууна. Мориноосоо буусан торгон цэргүүд зүүн гартаа зэрэгцэж яваа 1, 3 дугаар цувааны цэрэгт мориныхоо цулбуурыг шилжүүлэн өгөөд хонжин, тэргүүн тугч, тугчдын морины цулбуурыг авч морь баригчийн үүрэг биелүүлнэ.

7. Хонжин «Тугчид миний хойноос» гээд өөрөө тэргүүлж тэргүүн тугч гурваар эгнэн жагссан тугчдийг дагуулж Төрийн ордны хүндэтгэлийн хаалга, Төрийн тугийн байранд нэгийн цуваагаар орж, хонжин үүдэн тус газар, тэргүүн тугч, тугчид Төрийн тугийг нар зөв тойрон тэргүүн тугч Их цагаан тугны дэргэд, тугчид оноот хөл тугны дэргэд байраа тус тус эзэлнэ.

Тугчид Төрийн ордонд орж ирэхэд Төрийн ордны хамгаалалтын тусгай тасгийн дарга угтана.

8. Хонжин, тэргүүн тугч, тугчид гурвантаа мэхийн ёсолсны дараа тугчид оноот хөл тугаа түшиж Их цагаан туганд мэхийлгэхэд тэргүүн тугч Их цагаан тугийг өргөж хонжинг

чиглэн явахад тугчид зүүн жигүүрээсээ эхлэн нар зөв эргэж явна.

9. Хонжин манлайлан тэргүүн тугч, тугчид дэслэн Төрийн тугийн байрнаас гарч гурваар эгнэн зогсоно. Хонжин «Тугчид миний хойноос» гээд Төрийн ордны хүндэтгэлийн хаалгаар гарахад тугчид гурван эгнээгээөр жагсан явж торгон цэргийн жагсаал руу очно.

10. Хонжин «мориндоо» гэхэд тугчид мордож эмээлийн урд бүүргэнд бэхэлсэн сууринд тугаа суурилуулна. Морийг нь барьж байгаа торгон цэргүүд тэдэнд тусалж жолоо, цулбуурыг өгөөд цуваагаар явж мориндоо мордоно. Хонжин манлайлан Төрийн ордныг нар зөв тойрон баяр наадмын төв талбай руу ергүүлэн одно.

11. Төрийн тугийг баяр наадмын төв талбайн зүүн урд жигүүрээр залан орж ирэхэд наадамчид суудлаасаа босож хүрайлж мэхийн ёсолж өнгөрөөнө. Хонжин, тэргүүн тугч, тугчид нар зөв тойрон тугийн суурь хүртэл дэвссэн цагаан эсгийний баруун захаар цувран, торгон цэрэг тус тусын тогтоосон газарт зогсоно.

12. Хонжин «Мориноосоо» гэхэд торгон цэргийн захирагч, түүний орлогч, 2, 4 дүгээр цувааны цэргүүд мориноосоо нэгэн зэрэг бууж зүүн гартаа зэрэгцэн яваа 1, 3 дугаар цувааны цэрэгт цулбууруа шилжүүлэн өгч, нэгийн цуваагаар эсгий дээгүүр алхалж хонжин, тэргүүн тугч, тугчдын дэргэд хүрч зогсон баруун тийш эргэн морьдын цулбуурыг авч мориноос нь түшиж эсгий дээр буулгана. Хонжин, «миний хойноос» гэхэд тэргүүн тугч, тугчид тугаа өргөж, хонжинг даган тугны суурь хүрч нар зөв тойрон тус тусын байранд очиж нэгэн зэрэг баруун тийш эргэнэ. Хонжин суурь өөд харж зогссон байна. Энэ үед тугийн харуул ирж суурийн дөрвөн талд зогсоно.

13. Хонжин «Их цагаан тугийг мандуул» гэхэд тэргүүн тугч суурийн ард байрлуулсан шатаар өгсөн Их цагаан тугийг зална. Тэргүүн тугч буумагц шатыг сууринаас холдуулна. Хонжин «хөл тугийг чагтал» гэхэд тугчид урагш алхаж хөл тугийг байрлуулна. Энэ үед төрийн их хэнгэрэг дэлдэж, харанга цохиж, хашгираа ихт бүрээ татна.

14. Тэргүүн тугч, тугчид баруун тийш зэрэг эргэж, тогтоосон дараалаар явж, торгон цэрэг жагсаалдаа хүрч мориндоо мордоцгооно. Хонжингийн морийг хөтөлсөн торгон цэргийн захирагч «алхуул» гэхэд нар зөв эргэн баяр наадмын төв талбайн баруун жигүүрээр гарч одно.

15. Төрийн тугийг баяр наадмын төв талбайд хүндэтгэн залсан үед шөнийн цагт солбисон гэрлээ гэрэлтүүлэн төрийн ёслолын торгон цэрэг хамгаална.

### Гурав. **Төрийн тугийг баяр наадмын төв талбайгаас Төрийн ордонд хүндэтгэн залах**

16. Монгол Улсын Ерөнхийлөгч баяр наадмын ажиллагааг хааж үг хэлсний дараа Төрийн тугийг баяр наадмын төв талбайгаас Төрийн ордонд хүндэтгэн зална. Баяр наадмын төв талбайн зүүн урд жигүүрээр хонжин, тэргүүн тугч, тугчид, торгон цэрэг ергүүлэн орж ирж нар зөв тойрон тус тусын байранд зогсоно. Хонжин «мориноосоо» гэхэд тэргүүн тугч, тугчид болон торгон цэргийн захирагч, түүний орлогч, 2, 4 дүгээр цувааны цэрэг нэгэн зэрэг мориноос бууж хонжин, тэргүүн тугч, тугчдын морьдыг барина.

17. Тугчид хонжингийн дохиогоор туг руу очиж оноот тугаа харж зогсоно. Хонжин «хөл тугийг түш» гэхэд тугчид урагш алхан ишнээс нь барин тугийг түшиж сууринаас нь өргөн авч Их цагаан туганд мэхийлгэнэ. Хонжин «Их цагаан тугийг түш» гэхэд тэргүүн тугч шатаар гарч Их цагаан тугийг өргөн бууж суурийн өмнө талд ирж зогсоно. Хонжин «мориндоо» гэхэд тугчид мордож эмээлийн урд бүүргэнд бэхэлсэн сууринд тугаа суурилуулна. Морийг нь барьж байгаа торгон цэргүүд тэдэнд тусалж жолоо, цулбуурыг нь өгөөд цуваагаар явж мориндоо мордоно.

Хонжин «алхуул» гэхэд нар зөв эргэж төв асрын өмнүүр явж баяр наадмын төв талбайн баруун жигүүрээр гарч одно. Энэ үед наадамчид босч хурайлан, төрийн их хэнгэрэг, харанга дэлдэж, хашгираа ихт бүрээ татаж үднэ.

18. Төрийн тугийг залж Төрийн ордны баруун өмнө жигүүрт ирэхэд Төрийн ордны хамгаалалтын тусгай тасгийн дарга угтана. Хонжин «мориноосоо» гэхэд торгон цэрэг буун хонжин, тугчдыг түшиж буулган, морьдыг нь барьж зогсоно. Хонжин «алхаад» гэхэд тэргүүн тугч, тугчдыг Төрийн ордны хүндэтгэлийн хаалгаар дагуулан орж, Төрийн тугийн байр руу очно. Хонжин «Их цагаан тугийг зал» гэхэд тэргүүн тугч Их цагаан тугийг сууринд нь зална. Хонжин «хөл тугийг чагтал» гэхэд тугчид тогтоосон дарааллаар тугийн байранд орж, хөл тугийг нэгэн зэрэг байрлуулна. Хонжин, тэргүүн тугч, тугчид Их цагаан туганд ёслоод Төрийн тугийн байрнаас гарна.

# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 6 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 68

Улаанбаатар хот

## ТӨРИЙН ТАМГЫГ ХАДГАЛАХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

1. «Төрийн бэлгэ тэмдгийн тухай» Монгол Улсын хуулийн 19 дүгээр зүйлийг үндэслэн «Монгол Улсын Төрийн тамгыг хадгалах журам»-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэ зарлигийг 1994 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**Монгол Улсын Ерөнхийлөгч** **П. ОЧИРБАТ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1994 оны 68 дугаар зарлигийн хавсралт

## ТӨРИЙН ТАМГЫГ ХАДГАЛАХ ЖУРАМ

1. Монгол Улсын Төрийн тамгыг хайрцагт нь хийж байнгын хамгаалалттай өрөөнд, зориулалтын төмөр шүүгээнд хадгална. Түлхүүрийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга нууцлан хадгална.

2. Монгол Улсын Төрийн тамга өөрчлөгдвөл хуучин тамгыг Улсын эрдэнэсийн санд албан ёсоор шилжүүлэн хадгалуулна.

3. Монгол Улсын Төрийн байгууллагууд шилжин байрлах тохиолдолд Төрийн тамгыг нууц байдалд залж хүргэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

1994 оны 3 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 71

Улаанбаатар хот

# ХҮНСНИЙ ЖИЛИЙН АЖЛЫН ДҮНГИЙН ТУХАЙ

НҮБ-аас 1993 оныг дэлхий нийтээр хүнсний хангамжийг сайжруулах он болгосныг Монгол Улсын Засгийн газар дэмжиж «Хүнсний жил» зарласан билээ.

Хүнсний жилийн ажлыг зохион байгуулах төв, орон нутгийн комиссын ажлын дүнгээс үзэхэд аймаг, нийслэл, хотууд хүнсний хөтөлбөр боловсруулан ажиллаж 90-ээд мянган айл өрхийг малтай болгож, 50 гаруй мянган айл өрхөөр тариалан эрхлүүлэн хүнсний 248 жижиг үйлдвэрийг ашиглалтад оруулсан байна.

Гэвч хүн амын хүнсний хангамжийг сайжруулахад бүх нийтийн анхаарлыг жигд төвлөрүүлэх, айл өрх бүрт хүнс үйлдвэрлэх нөхцөл бололцоог бүрдүүлэх, хүнс хөдөө аж ахуйн салбарын аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдүүлэх талаар дутагдалтай ажилласан байна.

Хүнсний жилд гарсан ажлын эхлэлийг бататган улмаар энэ ажлыг эрчимжүүлж хүнсний хангамжийг сайжруулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, хотуудын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны саналыг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуйн яам, Хүнсний жилийн ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссоос боловсруулсан «Монгол хүний хоол тэжээл» хөтөлбөрийг зүйтэй гэж үзэж, тус улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн Үндсэн чиглэлд тодорхой арга хэмжээг тодотгон тусгаж байхаар тогтоосугай.

2. Монгол Улсын сайд бөгөөд Үндэсний хөгжлийн газрын дарга (Ч. УЛААН), Хүнс, хөдөө аж ахуйн сайд (Ц. ӨӨЛД) нарт даалгах нь:

а) «Монгол хүний хоол тэжээл» хөтөлбөр, түүний дэд хөтөлбөрүүд (цаашид «хөтөлбөр» гэнэ)-д тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх үүргийг холбогдох яам, тусгай газар, тэрчлэн аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, хотуудын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанд хариуцуулж, аймаг, нийслэл, хотуудын эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиглэлд тусгуулах арга хэмжээ авч, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилласугай;

б) хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ Хоол тэжээлийн талаархи дэлхийн тунхаглал, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл, олон улсын бусад байгууллага, хандивлагч орнуудын зээл тусламж, дэмжлэгийн бодлоготой уялдуулан зохицуулж байсугай;

в) хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд чихрийн манжин, тосны ургамал тариалуулах, сүү, цагаан идээ, шим болон эрдэс бордоо бэлтгүүлэх зэрэг ажилд өмчийн олон хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, эмэгтэйчүүд, ахмад, залуучуудын зэрэг олон нийтийн үүсгэл санаачилгын байгууллага, иргэдийг өргөн оролцуулж, зохиож байгаа ажлын үр дүнг тооцож бүртгэн хагас жил тутам мэдээлж байсугай;

г) хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор «Хүнс, хөдөө аж ахуйн сан» байгуулж, түүнд гадаад орнуудын зээл, тусламжийн хөрөнгө, олон улсын болон дотоодын байгууллагуудаас хүнс, хөдөө аж ахуйн салбарт оруулсан хандив, тусламжийн хуримтлалын хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулж байх асуудлыг Сангийн яамтай хамтран шийдвэрлэж байсугай.

3. Хүнсний жилд эхэлсэн ажлыг цаашид үргэлжлүүлэн эрчимжүүлэх, ялангуяа төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах, гахай, шувуу, туулай, зөгий үржүүлэх, сааль сүүний нөөцийг бүрэн ашиглахад нутаг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, иргэдийг өргөн оролцуулах, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах, хадгалах үйл ажиллагаанд иргэдийг суралцуулж дадлагажуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч байхыг бүх шатны Засаг дарга, хот, хороодын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга нарт даалгасугай.

4. Хүнсний хангамжийг сайжруулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор 1993 онд улсын төсвөөс олгосон зээлийн хөрөнгийн зарцуулалтын байдлыг

шалган үзэж, зээлийг тогтоосон хугацаанд төлүүлж төсөвт оруулахын дээр уг эх үүсвэрээс дээрх зориулалтаар 1994-1995 онд эргүүлэн зээлдүүлэх боломжийг хамтран судалж шийдвэрлэхийг Сангийн яам (Д. ДАВААСАМБУУ), Хүнс, хөдөө аж ахуйн яам (Ц. ӨӨЛД)-д даалгасугай.

5. Хөтөлбөрийг орчуулж зохих журмаар бэлтгэн НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад хүргүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн яам (Ц. ӨӨЛД) Эрүүл мэндийн яам (П. НЯМДАВАА)-д даалгасугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан «Хүн амын хүнсний хангамжийг сайжруулах зарим арга хэмжээний тухай» Монгол Улсын Засгийн газрын 1992 оны 78 дугаар тогтоолын 1, 2, 6, 9 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд** **П. ЖАСРАЙ**

**Хүнс, хөдөө аж ахуйн сайд** **Ц. ӨӨЛД**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр — Дугаар 72 — Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХҮНСНИЙ ХАНГАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Амьдрал нэн ядуу айл өрх, иргэд, тэтгэвэр авагчдад үзүүлэх нийгмийн халамж хийгээд хүн амын хүнсний хангамжийн үйлчилгээг сайжруулах шаардлагатай байгааг харгалзан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Энэ оны 4 дүгээр сараас эхлэн дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам (Э. ГОМБОЖАВ), аймаг, нийслэлийн Засаг дарга, хо-

туудын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга нарт даалгасугай:

а) ажил хөдөлмөр эрхэлж бие даан амьдрах чадваргүй, нэн ядуу иргэдийн судалгааг нарийвчлан гаргаж, тэднийг нийгмийн асрамжинд авах, тохирсон ажлыг зохион бэйгуулалтайгаар хийлгэх арга хэмжээ авах;

б) амьдрал ядуу, бага орлоготой айл өрх, иргэдэд туслах сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх үндсэн дээр хөнгөлөлттэй нөхцөл, болзлоор насны тэтгэвэр тогтоолгосон, тэтгэврээс өөр орлогогүй 55-аас доош насны эмэгтэйчүүд, 60-аас доош насны эрэгтэйчүүдийг орлогын байнгын нэмэгдэл эх үүсвэртэй болгох;

в) тэтгэврээс өөр орлогогүй, ажил хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийг мэргэжлийнх нь дагуу бололцоотой газруудад ажиллуулах, аж ахуйн нэгж, байгууллагаас захиалга авч тохирох ажилд хуваарилахын зэрэгцээ урт, богино хугацааны төрөл бүрийн сургалтад хамруулан дахин мэргэшүүлэх ажлыг холбогдох яам, тусгай газартай хамтран зохион байгуулах.

2. Хөнгөлөлттэй нөхцөл, болзлоор насны тэтгэвэр тогтоолгосон, тэтгэврээс өөр орлогын эх үүсвэргүй Улаанбаатар хотод оршин суугаа 55-аас доош насны эмэгтэйчүүд, 60-аас доош насны эрэгтэйчүүд, үүний дотор зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, цагдаа, улсын аюулгүй байдлыг хангах болон хорих ял эдлүүлэх байгууллагад ажиллаж байсан насны тэтгэвэр авагч уг насны иргэдэд ажил хөдөлмөр эрхлүүлэх, саалийн мал, гахай, тахиа, туулай үржүүлэх ,төмс, хүнсний ногоо тариалах зэргээр нэмэгдэл орлогын эх үүсвэртэй болгоход зориулан 1994 оны 50 сая төгрөгийн төсвийн зээлийг эргэж төлөгдөх нөхцөлөөр жилийн 4-өөс илүүгүй хувийн хүүтэйгээр нэг жил хүртэл хугацаагаар олгож, ажлын байр нэмэгдүүлэх тодорхой ажлыг холбогдох яам, тусгай газартай хамтран ахмадын байгууллагын оролцоотойгоор зохион байгуулж хэрэгжүүлэхийг Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам (Э. ГОМБОЖАВ), Нийслэлийн Засаг дарга (Ц. БААСАНЖАВ)-д даалгасугай.

3. Тариалан эрхлэх, гахай, тахиа, туулай үржүүлэх, хүнсний зүйл бэлтгэх, боловсруулах талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчлах, энэ ажилд мэргэжилтэй, эрдэмтдийг оролцуулан сургалт зохион байгуулахыг Радио, те-

левизийн Хэрэг эрхлэх газар (Б. ӨВГӨНХҮҮ), Хүнс, хөдөө аж ахуйн яам (Ц. ӨӨЛД), аймаг, нийслэлийн Засаг дарга, хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга нарт даалгасугай.

4. Дор дурдсан зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд (Ц. ӨӨЛД), нийслэлийн Засаг дарга (Ц. БААСАНЖАВ) нарт даалгасугай:

а) төрийн өмчийн болон төрийн өмч оролцсон хүнсний чиглэлийн аж ахуйн нэгж, байгууллагуудад мах, гурил, талх, төмс, хүнсний ногоо зэрэг өдөр тутмын хэрэгцээний хүнсний бүтээгдэхүүнээ борлуулахад нь зориулан нийслэлийн дүүрэг, хороодод хүнсний зах, дэлгүүрийн лангуу гаргаж өгөх, сул чөлөөтэй талбайг түрээслүүлэх, түүнчлэн худалдааны цэг байгуулж ажиллуулахад нь тэдэнд туслалцаа үзүүлэх зэргээр зохих нөхцөл боломжоор хангах;

б) хүн амын хүнсний хэрэгцээний гол нэр төрлийн бүтээгдэхүүний хангамжийн байдалд хиймэл хомсдол бий болгохгүй байх, дундаас нь завших, бөөнөөр авч дамлах, үнийг үндэслэлгүйгээр өсгөх явдлыг гаргуулахгүй байх, хүн амын өдөр тутмын хэрэгцээний хүнсний бүтээгдэхүүнийг нийслэлийн захын дүүрэг, хороодын оршин суугчид, ялангуяа амьдрал нэн ядуу айл өрх, иргэд, ахмад хүмүүст хүргэлж худалдаалах арга хэмжээ авч, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах;

в) төрийн өмчийн болон төрийн өмч оролцсон хүнсний чиглэлийн аж ахуйн нэгж, байгууллагаас борлуулах мах, гурил, талх, төмс, хүнсний ногоо зэрэг бүтээгдэхүүний үнийн дээд хязгаарыг тогтоолгон нийслэлийн Засаг даргын Тамгын газар бүртгэж, энэхүү үнийг өөрсдөөр нь олон нийтэд тогтмол зарлуулан мэдээлж байх.

5. Хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний хангамжид хиймэл хомсдол бий болгох, дундаас нь завших, бөөнөөр авч дамлах, үнийг үндэслэлгүй нэмэгдүүлэх, худалдааны дэг журам зөрчих зэрэг сөрөг үр дагаврыг цаашид гаргуулахгүй байхад иргэд, олон нийтийн хяналтыг чиглүүлэх зорилгоор хөнгөлөлттэй нөхцөл, болзлоор насны тэтгэвэр тогтоолгосон хөдөлмөрийн чадвар бүхий иргэд, өндөр настан ахмадуудыг хяналтын ажилд зохион байгуулалттайгаар оролцуулж хөлсийг нь тухай бүр тооцон олгож байхын гадна хэрэгцээтэй газарт тэднийг гэрээт харуулаар ажиллуулах арга хэмжээ

авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга, хотуудын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга нарт даалгасугай.

6. Тэтгэврийн санд оруулах хөрөнгийг цаг тухайд нь саадгүй олгож байхыг Сангийн яам (Д. ДАВААСАМБУУ)-д; нутаг дэвсгэртээ байрладаг аж ахуйн нэгж, байгууллагуудаас нийгмийн даатгалын шимтгэлийг тэтгэврийн санд хугацаанд нь бүрэн оруулж байх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга, хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга нарт; тэтгэвэр, тэтгэмжийн хөрөнгийг орон нутагт шуурхай шилжүүлж байхыг Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам (Э. ГОМБОЖАВ)-д тус тус даалгасугай.

7. Бүх төрлийн тэтгэвэр, тэтгэмж, түүн дээр нэмж олгож байгаа нөхвөрийг хугацаанд нь элдэв чирэгдэлгүй, бүрэн олгуулж байх арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны Засаг дарга, хот, хороодын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга нарт үүрэг болгосугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд** **П. ЖАСРАЙ**

**Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд** **Э. ГОМБОЖАВ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр — Улаанбаатар хот

Дугаар 73

## ХЭЛЭЛЦЭЭР БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан (ЮНИСЕФ)-гийн хоорондын хамтын

ажиллагааны тухай үндсэн Хэлэлцээрийг баталсугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд** **П. ЖАСРАЙ**

**Гадаад харилцааны сайд** **Ц. ГОМБОСҮРЭН**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр — Улаанбаатар хот

Дугаар 74

## Г. ЗАНАБАЗАРЫН ОЙГ ТЭМДЭГЛЭХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Монгөлын төр, шашин, соёл урлагийн нэрт зүтгэлтэн Гомбодоржийн Занабазарын 360 насны сүүдэр тухайлсны ойг 1995 оны 9 дүгээр сард тэмдэглэх тухай Соёлын яамнаас Өвөрхангай аймгийн Засаг дарга, Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгчтэй тохиролцон оруулсан саналыг зөвшөөрч тус ойг тэмдэглэх ажлыг зохион байгуулах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажиллуулсугай:

Комиссын дарга — Соёлын сайд Н. Энхбаяр

Орлогч дарга:
— Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С. Банзрагч;
— Олон улсын Монгол судлалын холбооны ерөнхий нарийн бичгийн дарга, доктор Ш. Бира.

Гишүүд:
— Улаанбаатар хотын Засаг дарга Ц. Баасанжав;
— Өвөрхангай аймгийн Засаг дарга С. Жанцандорж;

— Гадаад харилцааны дэд сайд, ЮНЕСКО-гийн үндэсний комиссын дарга Ж. Чойнхор;

— Монголын Бурхан шашинтны төвийн тэргүүн, Гандантэгчинлэн хийдийн хамба Д. Чойжамц (харилцан тохиролцсоноор);

— Урчуудын эвлэлийн хорооны орлогч дарга Ц. Энхжин (харилцан тохиролцсоноор);

— Буддын судлалын хүрээлэнгийн захирал, Азийн Буддистуудын Энх Тайвны Бага хурлын нарийн бичгийн дарга Г. Лувсанцэрэн;

— Хэл, зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор Л. Хүрэлбаатар;

— Түүхч, дэд доктор С. Ичинноров;

— Соёлын яамны харьяа Буддын соёлын төвийн захирал О. Дашбалбар;

Нарийн бичгийн дарга

— Шинжлэх ухааны академийн нийгмийн ухааны салбарын дарга, доктор С. Норовсамбуу

**Монгол Улсын Ерөнхий сайд** **П. ЖАСРАЙ**

**Соёлын сайд** **Н. ЭНХБАЯР**

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ**

1994 оны 6 сарын 21 Дугаар 49 Улаанбаатар хот

# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 7-Р ЗҮЙЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 7-р зүйлийн 1 дэх хэсгийн зарим заалтыг нэг мөр ойлгох явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 7-р зүйлийн 1 дэх хэсгийн зарим заалтыг дор дурдсанаар тайлбарласугай.

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 7-р зүйлийн 1 дэх хэсгийн «...жил тутам үйл ажиллагааны талаар танилцуулж байна» гэдэг нь Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн тухай хууль бусад хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ, түүний явц, үр дүнг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд сонордуулан мэдээлэхийг хэлнэ.

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 7-р зүйлийн 1 дэх хэсэгт болон бусад хуульд Ерөнхийлөгч тайлан тавьж хэлэлцүүлэхээр заагаагүй тул дээр дурдсанаар танилцуулах нь Ерөнхийлөгчийн үйл ажиллагааг шүүн хэлэлцэх, үнэлэлт дүгнэлт өгөх, үүрэг өгсөн шийдвэр гаргах ойлголт биш болно.

3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн «Ерөнхийлөгч Улсын Их Хуралд ажлаа харицуцаж...» гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 35 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн заалт тул Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-д зааснаар Улсын Дээд шүүхийн хууль тайлбарлах бүрэн эрхэд хамаарахгүй.

**Ерөнхий шүүгч** **Д. ДЭМБЭРЭЛЦЭРЭН**

**Шүүгч** **Д. НАМСРАЙЖАВ**

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТОГТООЛ

1994 оны 7 дугаар сарын 1-ний өдөр

Дугаар 51

Улаанбаатар хот

# ТӨРИЙН ЭРҮҮГИЙН ЯЛ ШИЙТГЭЛИЙН БОДЛОГЫГ ШҮҮХЭЭС ХЭРЭГЖҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДЛЫН ТУХАЙ

Шүүхээс оногдуулж байгаа эрүүгийн ял шийтгэлийн байдал, цаашид анхаарах зарим асуудлын тухай Дээд шүүхийн шүүгч Д. Алтангэрэлийн илтгэлийг сонсон хэлэлцээд Монгол Улсын Дээд шүүхээс ТЭМДЭГЛЭХ нь:

Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд түүний үйлдсэн хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, хувийн байдалд тохирсон ял оногдуулах нь бүх шатны шүүх, шүүгчдийн үндсэн үүрэг, тэдний анхаарлын төвд байнга байх ёстой гол асуудлын нэг мөн.

Монгол Улсын Дээд шүүх 1990 оны 12 дугаар сарын 24-ний өдөр «Ял шийтгэлийг зөв оногдуулах тухай» 88 дугаар тогтоол гаргаж шүүхээс гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд ял оногдуулахдаа удирдлага болгох үндсэн зарчмуудыг тодорхойлон тайлбарласан билээ.

Энэхүү тогтоол гарснаас хойшхи хугацаанд Монгол улсын эрүүгийн хуульд хэд хэдэн удаа томоохон өөрчлөлт орж, гэмт хэргийн тухай ойлголт, ялын зорилго, төрөл, хэмжээ, өөрөөр хэлбэл төрийн эрүүгийн эрх зүйн бодлогод зарчмын өөрчлөлт гарав. Одоогийн эрүүгийн хуульд зааснаар хорих, торгох, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах, цаазаар авах ялыг үндсэн ялын чанартайгаар хэрэглэж болох боловч эрүүгийн хуулийн тусгай ангид тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг үндсэн ялын чанартай хэрэглэх заалтгүйгээс эрх хасах ялыг, түүнчлэн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлаас шалтгаалан засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг бараг хэрэглэхгүй болж хорих, торгох ялыг голчлон хэрэглэхэд хүрч байна.

Сүүлийн жилүүдэд нийт гэмт хэрэг, түүний дотор хулгайлах,, танхайрах, бусдыг санаатай алах болон бусад зарим төрлийн гэмт хэрэг өсөж, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, учруулж байгаа хохирол ихээхэн нэмэгдэв.

Монгол улсын шүүхийн тогтолцоо шинэчлэгдэж, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд мэтгэлцэх зарчмыг мөрдөх болж шүүн таслах ажиллагааны хамтын зарчимд агуулгын болон хэлбэрийн томоохон өөрчлөлт орж, хуульд тусгайлан заасан нэлээд хэргийг шүүгч дангаараа таслан шийдвэрлэх болж байна.

1991—1993 онд нийт шүүх 26,9 мянган хүнд холбогдох эрүүгийн хэрэг таслан шийдвэрлэж нийт ял шийтгүүлэгчдийн 0,06 хувьд олон нийтийн өмнө буруушаах, 3,5 хувьд заасан хугацаагүүлэх ажил хийлгэх 21,3 хувьд торгох, 74,7 хувьд хорих ял оногдуулж, нийт ял шийтгүүлэгчдийн 32,9 хувийн ялыг биечлэн эдлүүлжээ. Шүүхээс оногдуулсан хорих ялын дотор 1—3 жилийн хорих ял 62,9 хувийг эзэлж байна.

Шүүхийн тоо бүртгэлийн мэдээнээс үзвэл хорих ялыг биечлэн эдлүүлэх нь жил дараалан буурч, тэнсэх нь өсөх хандлагатай явж иржээ. Хорихоос өөр төрлийн ял түүний дотор торгох ял хэрэглэх явдал хуульд заасны дагуу өсөж байгаа боловч тэдгээрийг нэгбүрчлэн эдлүүлж чадахгүй байна.

Шүүхүүд ялын цээрлүүлэх, урьдчилан сэргийлэх, иргэд, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах зорилгыг харьяалан ажиллаж байгаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийнхээ нэгжид голлон гарч байгаа гэмт хэргийн төрөл, тэдгээрийг үйлдсэн гэм буруутай этгээдийн хувийн байдалтай холбон үзэхгүй байгаагаас сүүлийн жилүүдэд өсөж байгаа бусдыг санаатай алах, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах, хулгайлах, танхайрах, гудамж замын хөдөлгөөний дүрэм зөрчих зэрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял сулрах хандлагатай болжээ.

Зарим шүүх тодорхой гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдийн үйлдсэн хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, шүүгчдийн хувийн байдал, гэм буруугийн хэр хэмжээ, учруулсан хор хохиролд тохирсон ялын зорилгыг хангасан ял оногдуулах хуулийн шаардлагыг жигд хэрэгжүүлэхгүй байна. Олон шүүх эрүүгийн хуульд заасан хүнд болон онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, удаа дараа гэмт хэрэг үйлд-

сэн этгээдэд оногдуулах ялыг үндэслэлгүйгээр хөнгөрүүлэх, хуульд заасан хорих ялын доод хэмжээнээс доогуур тогтоох буюу өөр төрлийн хөнгөн ял оногдуулах шүүхээс оногдуулсан хорих ялыг тэнсэж хянан харгалзах түүнчлэн хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд голчлон богино хугацааны хорих ял оногдуулах хандлагатай болжээ.

Тэгэхдээ 1993 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр болсон Монгол улсын шүүхийн шүүгчдийн нэгдсэн зөвлөлгөөнөөс хойшхи хугацаанд дийлэнх олонх шүүх шүүгчид шүүхээс оногдуулж байгаа эрүүгийн ял шийтгэлийн байдалд дүгнэлт хийж эхэлснийг тэмдэглэх нь зүйтэй. Хэрэв 1992 онд улсын хэмжээгээр нийт ял шийтгүүлэгчдийн 33,1 хувийн, 1993 онд жилд 31,7 хувийн хорих ялыг биечлэн эдлүүлж байсан бол 1994 оны хагас жилд 38,1 хувийг хорих ялыг биечлэн эдлүүлжээ.

Энэ бүхэн нь шүүхээс оногдуулж байгаа ял шийтгэлийн байдалд дүн шинжилгээ хийж, цаашид анхаарах асуудлыг тодорхойлон заах явдал өнөө үеийн шүүхийн чухал зорилт болохыг харуулж байна.

Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Монгол улсын нийт шүүх, шүүгчдэд ДААЛГАХ нь:

1) шүүхээс гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд оногдуулах ял нь түүний үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, учруулсан хохирол, шүүгдэгчийн хувийн байдал, гэм бурууғийн хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн арга, хэрэглэсэн зэвсэг, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдалд тохирсон, гэмт халдлагаас иргэн, нийгмийг хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, засан хүмүүжүүлэх ялтныг болон бусад хүнийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ялын зорилгыг биелүүлэхэд нийцсэн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг нарийн харгалзсан байх зарчмыг удирдлага болгон хэрэгжүүлэх.

2) гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь нотлогдсон этгээдэд ял оногдуулахдаа Монгол улсын эрүүгийн хууль «Ял шийтгэлийг зөв оногдуулах тухай» Дээд шүүхийн Бүгд хурлын 1990 оны 88 дугаар тогтоол болон бусад тогтоолын заалтыг чанд баримтлан хараат бусаар хэрэгжүүлж байх.

3) эрүүгийн хуулийн 6 дугаар зүйлд заасан хүнд болон онц хүнд гэмт хэрэг, түүний дотор бусдыг санаатай алах, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах, хүчиндэх, хулгайлах дээрэмдэх, танхайрах хээл хахууль авах

зэрэг гэмт хэргийг хүндрүүлэх шалтгаантайгаар үйлдсэн этгээдэд юуны өмнө ялын цэрлүүлэх зорилгыг хангах бусад зорилгыг хэрэгжүүлэх боломжтой хуульд заасан ялыг хөнгөрүүлэхгүйгээр хэрэглэх. Түүнчлэн болгоомжгүйгээр үйлдэгдсэн боловч уул хэргийг үйлдэхэд гэм бурууtай этгээдийн сахилгагүй, хариуцлагагүй байдал нь нөлөөлсөн бөгөөд нийгэм, иргэнд их хэмжээний хохирол учруулсан тодорхой гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хуульд заасан ял оногдуулж байх.

4) эрүүгийн хуульд заасан хөнгөн болон хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн насанд хүрээгүй этгээдэд ялын зарим хүмүүжүүлэх зорилгыг удирдлага болгон эрүүгийн хууль, түүний зүйл, хэсэгт заасан ялыг хуульд заасан журмын дагуу сонгон хэрэглэж байх. Үүнтэй холбогдуулан торгох ял оногдуулахдаа тодорхой хэргийн нийгмийн аюулын хэр хэмжээ, учирсан хохирол, гэмт этгээдийн хувийн байдал, түүний дотор амьдралын нөхцөл ажил эрхлэлт, орлогын байдлыг харгалзаж байх нь зүйтэй гэж үзсүгэй.

5) гэмт хэрэг үйлдсэн гэм бурууtай этгээдэд ял оногдуулахдаа энэ тогтоолын 3, 4 дүгээр зүйлийн заалтыг тухайн ялын гэмт халдлагаас иргэн, нийгмийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгыг нэгэн адил харгалзан үзэж байх. Үүнтэй холбогдуулан ялын урьдчилан сэргийлэх зорилгод зөвхөн гэмт хэрэг үйлдсэн тухай этгээдэд төдийгүй тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид олноор гарч байгаа гэмт хэргийг үйлдэхээс болон гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүмүүс гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилго багтаж байгааг тайлбарласугай.

6) гэмт хэрэг үйлдсэн гэм бурууtай этгээдэд оногдуулсан ялын зорилгыг хэрэгжүүлэхэд гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг үндэслэлтэй зөв тогтоож шийдвэрлэх нь чухал ач холбогдолтой тул нэхэмжлэлийг хангах арга хэмжээг урьдчилан авч хохирлыг гаргуулах асуудлыг эрүүгийн хэрэгтэй хамт таслан шийдвэрлэх тогтоолоор шийдвэрлэж, түүнийг хугацаанд нь бүрэн биелүүлэх арга хэмжээ авч байх.

2. Аймаг, нийслэлийн шүүх, сумын буюу сум дундын дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчдэд ДААЛГАХ нь:

1) өөр өөрийн харьяалан ажиллаж буй засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид гарч байгаа гэмт хэргийн байдал, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулсан ял түүнийг эдлүүлсэн байдлыг жил бүр буюу шаардлагатай өөр

хугацаанд дангаараа буюу бусад байгууллагатай хамтран нэгтгэн судалж дүгнэлт хийн шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах, эрүүгийн ялын зорилгыг зөв хэрэгжүүлэхэд чиглүүлэн ажиллах.

2) гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хорихоос өөр төрлийн ял оногдуулсан тохиолдолд тухайн ялыг хугацаанд нь бүрэн эдлүүлэх, тухайлбал таслан шийдвэрлэх тогтоолыг тухайн ялыг биелүүлэх, хяналт тавих эрх бүхий байгууллагад хүргүүлэх, торгуулийг гаргуулж улсын орлого болгох, түүнийг хугацаандаа төлөөгүй бол хорих ялаар солих хорих ял нь тэнсэгдсэн этгээд хянан харгалзсан болон таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд хөдөлмөрийн сахилга, нийгмийн дэг журмыг удаа дараа зөрчиж захиргааны, сахилгын эсхүл олон нийтийн нөлөөллийн арга хэмжээ авагдсан шүүхээс даалгасан үүргийг биелүүлээгүй, эсхүл ЗХА хийлгэх ял шийтгүүлсэн этгээд уул ялаас ноцтой зайлсхийсэн бол эрх бүхий байгууллагын саналаар таслан шийдвэрлэх тогтоолоор оногдуулсан ялыг эдлүүлэх арга хэмжээг хуульд заасан журмын дагуу авч байх.

3. Шүүхүүдээс оногдуулж байгаа ялын байдлыг аймаг, нийслэлээр болон тодорхой төрлийн хэргээр тухайн орон нутгийн онцлогтой холбон судалж, харилцан мэдээлж байх арга хэмжээг тогтмол авч байхыг Дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн судалгааны төвд үүрэг болгосугай.

4. Монгол Улсын Дээд шүүхийн Бүгд хурлын 1990 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 88 дугаар тогтоолын 10 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**Ерөнхий шүүгч** **Д. ДЭМБЭРЭЛЦЭРЭН**

**Шүүгч** **Д. АЛТАНГЭРЭЛ**

# ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙН АГУУЛГА, ОНЦЛОГ

Монголын ард түмний оюун ухаан, уран гараар бүтсэн түүх, соёлын дурсгалт зүйлийг төрийн хамгаалалтад байлган судлан шинжилж, сэргээн засварлаж хойш үедээ өвлүүлэн үлдээх нь зөвхөн соёлын төдийгүй, түүх, шинжлэх ухааны танин мэдэхүйн нэн чухал ач холбогдолтой билээ.

Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжиж байгаа өнөө үед эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр үе уламжлан хадгалж байсан түүх, соёлын дурсгалт зүйлийг худалдах, хууль бусаар хил давуулах гадаадад үзэсгэлэн худалдаа гаргах, номын санд байгаа ховор ном судрыг хувилан олшруулж, гадаадын хүнд тараах, хэвлэх бололцоо олгох, музейн үзмэр, ил задгай оршиж буй хадны сүг зураг, бичээс, эртний хөшөө дурсгалын зургийг авах, дүрс бичлэг, кино хийх, булш хиргисүүрийг дур мэдэн ухах, түүх, соёлын дурсгалт зүйлийг дуудлагын худалдаагаар худалдах зэрэг зөрчил гарах болов. Иймээс хуулийн сиймхийг далимдуулан хийж буй дээрх үйл ажиллагааг нэн даруй таслан зогсоож, хяналт тавин ажиллах шаардлага зүй ёсоор тавигдсан юм. 1970 онд батлагдсан «Бүгд Найрамдах Монгол Ард Улсын соёлын дурсгалт зүйлийг хамгаалах хууль» нь энэ шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байсан учраас «Монгол Улсын түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль»-ийг шинээр боловсруулж, Улсын Их Хурал хэлэлцэн баталлаа.

Чингэхдээ «Соёлын өв болон байгалийн өвийг хамгаалах тухай» болон «Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай» олон улсын конвенцийн нийтлэг зарчим, хэм хэмжээг энэ хуулинд тусгасан юм .Түүнчлэн хуулийг боловсруулан батлахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаа, заалтуудыг удирдлага болгохын хамт Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийн актуудтай нягт уялдуулсан болно. Уг хуулийг боловсруулах явцад ОХУ, Герман, Япон, Испани, Хятад, Өмнөд Солонгос зэрэг дэлхийн хөгжилтэй орнуудын түүх, соёлын өвийг хамгаалах хуулиудыг нарийвчлан судалж, тэдний ололт туршлагыг аль болохоор харгалзан үзэхийг эрмэлзсэн

юм. Гэхдээ хуулийг боловсруулахад голлон анхаарсан зүйл бол өөрийн орны өвөрмөц онцлогийг бүх талаар тусгах зарчим баримталсанд оршино.

«Монгол Улсын түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль» нь:

1) Нийтлэг үндэслсэл;

2) Түүх, соёлын дурсгалт зүйлийн улсын бүртгэл, мэдээллийн сан;

3) Түүх, соёлын дурсгалт зүйлийг сурвалжлан олох, судалж шинжлэх сурталчлах, ашиглах;

4) Археологийн хайгуул, малтлага судалгаа;

5) Түүх, соёлын дурсгалт зүйлийг өмчлөгч, эзэмшигчийн эрх, үүрэг;

6) Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тогтолцоо;

7) Бусад зүйл гэсэн 7 бүлэг, 23 зүйлтэй юм.

1 бүлэгт: энэ хуулийн зорилтыг түүх, соёлын дурсгалт зүйлийг сурвалжлан олох, бүртгэх, хадгалж хамгаалах, судлан шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, сурталчлах, сэргээн засварлах, өмчлөх, эзэмших ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино гэж тодорхойлжээ. Хууль ёсоор бол түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах түүх, соёл шинжлэх ухааны ач холбогдол бүхий археологи, уран барилга, бичиг соёлын болон угсаатны зүйн дурсгалууд, гар урлалын зүйлс, түүх, байгалийн дурсгалт газрууд, урлаг, уран сайхны бүтээлүүд түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарагдана.

Энэ хуулинд түүх, соёлын дурсгалт зүйлийг түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбодлоор нь хосгүй үнэт, үнэт ердийн гэж зэрэглээд, зэрэглэл, үнэлгээг тодорхойлох мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинжлэх ухаан, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална гэж заажээ.

II бүлэгт: Түүх, соёлын дурсгалт зүйлийн улсын бүртгэлмэдээллийн сангийн тогтолцоо, бүрдэл, бүртгэх журмыг тодорхойлсон нь эл хуулийн нэг шинэлэг тал юм. Хуулиар нийм сан бий болгож байгаа нь түүх, соёлын дурсгалт зүйлийн талаар улсын хэмжээний нэгдсэн мэдээлэлтэй болох, түүний хадгалалт, хамгаалалт, ашиглалтад хяналт тавих, нарийн судалж, сурталчлах өргөн боломжийг нээж өгч байгаа юм. Эл сан нь тухайн түүх, соёлын дурсгалт зүйлийн бүртгэл, тодорхойлолт, гэрэл зураг, судалгаа шинжилгээ, сэр-

гээн засварлах ажлын товч тайлан зэрэг үндсэн хэсгээс бүрдэхээр хуулинд заажээ. Энэ хууль ёсоор төрийн өмчид байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийг улсын бүртгэл, мэдээллийн санд заавал бүртгэх ба өмчлөгч иргэн заавал бүртгүүлэх ёстой. Хэрэв өмчлөгч хүсвэл түүх, соёлын дурсгалт зүйлийн бүртгэлийг нууцлан хадгалах болно. Түүх, соёлын дурсгалт зүйлийг улсын бүртгэл мэдээллийн санд бүртгэсэн тухай гэрчилгээ олгох, бүртгэсэн түүх, соёлын дурсгалт зүйлийн тоо-логыг 4 жил тутам явуулахаар хуулинд тусгажээ.

III бүлэгт: Түүх, соёлын дурсгалт зүйлийг сурвалжлан олох, судалж шинжлэх, сурталчлах, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулжээ. Түүх, соёлын дурсгалт зүйлийг сурвалжлан олох, судалж шинжлэх журмыг шинжлэх ухаан болон, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно. Түүх, соёлын дурсгалт зүйлийн судалгаа шинжилгээний ажлын нэгдсэн мэдээллийг шинжлэх ухаан болон соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран жил бүр гаргаж улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд хадгалахаар уг хуулинд тусгажээ. Хууль ёсоор байгууллага, иргэд олж илрүүлсэн түүх, соёлын дурсгалт зүйлээс цаашид өөрсдөө нарийвчлан судлах тохиолдолд давуу эрх эдэлнэ.

Хуулинд түүх, соёлын дурсгалт байшин барилгаас бусад түүх, соёлын дурсгалт зүйлийг гагцхүү нийтэд дэлгэн үзүүлэх, сурталчлах, судалгаа шинжилгээ, сургалт явуулах зориулалтаар ашиглаж болохыг заахын хамт гэмтээх, үрэгдүүлэх, төрх байдлыг өөрчлөх, язгуур зориулалтаар ашиглах, үнэ цэнийг алдагдуулах үйл ажиллагаа явуулахыг хоригложээ. Харин түүх, соёлын дурсгалт зүйлийг Төр, сүм хийдийн хуульд заасны дагуу хэрэглэх асуудлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын санал болгосноор Засгийн газар шийдвэрлэх болно.

IV бүлэгт: археологийн ажлын үндсэн чиглэл, эрхлэн явуулах байгууллага, археологийн малтлага хийх, олзворыг бүртгэх, судлан шинжлэхтэй холбоотой асуудлыг хуульчилжээ Энд гурван зүйлийг онцлон тэмдэглэхэд, нэгдүгээрт археологийн хайгуул, малтлага, судалгааг зөвхөн мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага эрхлэн явуулна, хоёрдугаарт, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрлийг археологийн судалгаа дагнан эрхлэн явуулдаг эрдэм шинжилгээний улсын байгууллага олгоно, гуравдугаарт, археологийн хайгуул, малтлага, судалгааг гадаадын эрдэм шин-

жилгээний байгууллага, эрдэмтэдтэй хамтран гүйцэтгэх шаардлагатай тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжоор хориглоогүй бол уг ажлыг археологийн судалгаа дагнан эрхэлдэг эрдэм шинжилгээний улсын байгууллагын саналыг үндэслэн Засгийн газраас гаргасан шийдвэрийн дагуу гүйцэтгэж болно гэдгийг онцгой анхаарвал зохино.

V бүлэгт: Түүх, соёлын дурсгалт зүйлийг өмчлөгчийн эрх үүргийг хуульчлахын хамт мөн өмчлөх эрхийг хязгаарлах нөхцөлийг шинээр тодорхойлжээ. Эл хуулинд түүх, соёлын дурсгалт зүйлийг өмчлөгч нь худалдах, бэлэглэх, өвлүүлэх, нийтэд дэлгэн үзүүлэх, сурталчлах, үнийг нь тогтоох, өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх (гадаадын хүн, харьяалалгүй хүнд шилжүүлэхийг хориглоно) зэрэг эрх эдлэхээр заажээ. Түүх, соёлын дурсгалт зүйлийг өмчлөгч нь өмчлөх эрхээ бусдад шилжүүлсэн ба өвлүүлсэн тохиолдолд улсын бүртгэлд өөрчлөлт оруулах, түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдрэл гэмтэлгүй, бүрэн бүтэн хадгалж хамгаалж байх, алдагдсан тохиолдолд мэдэгдэх зэрэг үүргийг хүлээхээр хуулинд тусгагдсан байна. Хуулинд зааснаар түүх, соёлын дурсгалт зүйлийг худалдах, солилцох журмыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

VI бүлэгт: Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тогтолцоог бий болгожээ. Энэ тогтолцоо ёсоор түүх, соёлын дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалтад соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга хяналт тавина. Түүх, соёлын дурсгалт зүйлийн эрх зүйн хамгаалалтыг улсын, орон нутгийн, байгууллагын гэж ангилна. Уг хуульд түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалж хамгаалах, хамгаалалтын бүс тогтоох, сэргээн засварлах, даатгуулах, эрдэнэсийн санд хадгалуулах зэрэг заалтуудыг хуульчлан тусгасан юм.

Хуулинд зааснаар түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг үзэсгэлэнд тавих, сурталчлах, сэргээн засварлах зорилгоор түүний хадгалалт хамгаалалтын найдвартай нөхцөлийг бүрдүүлсний үндсэн дээр Засгийн газрын зөвшөөрөлтэйгээр хил нэвтрүүлэх боломжтой юм. Харин түүх, соёлын үнэт дурсгалт зүйлийг шинжлэх ухаан, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр эгүүлж авчрах нөхцөлтэйгөөр 1-ээс дээшгүй жилийн хугацаатай хил нэвтрүүлэх ёстой. Хууль бусаар хил гаргасан түүх, соёлын дурсгалт зүйлийг улсын өмч болгон зарлах ба хил нэвтрэх

үед хураагдсан түүх, соёлын дурсгалт зүйлийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлэхээр хуулинд заажээ.

VII бүлэгт: Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах сан, урамшуулал, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгасан юм. Хуулинд түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах үйлсэд хувь нэмэр оруулсан байгууллага, иргэдийг алдаршуулах, урамшуулахаар заасан нь хуулийн хэрэгжилтэд зохих түлхэц үзүүлэх болно. Мөн уг хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг нарийвчлан заасныаар аа өмнө үйлчилж байсан хуулиас давуутай юм.

Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хуулийг 1994 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх болно. «Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай» Монгол Улсын Их Хурлын тогтоолд уг хуульд заасан дүрэм, зааврууд ыг 1994 оны 9 дүгээр сард багтаан баталж, хуулийг хэрэгжүүлэх иж бүрэн хөтөлбөр боловсруулж мөрдүүлэхээр заалаа. Энэ хуулийн зүйл, заалт бүхнийг чанд дагаж мөрдөх нь албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэн бүрийн эрхэм үүрэг мөн.

Улсын Их Хурлын гишүүн Ж. БОЛДБААТАР

# ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ХУУЛИЙН ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлж эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хуулийн байгууллагуудын болон тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулах олон хуулийг шинээр гаргаж, зарим хуульд нэмэлт өөрчлөлтийг оруулж байна.

Үүний нэг бол «Иргэний байцаан шийтгэх хууль»-ийг шинэчлэн найруулж, «Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хууль»-ийг Улсын Их Хурлаас батлан гаргасан явдал юм.

Энэхүү хуулийн зорилго бол өөрийн буюу бусдын эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалж, иргэн, хуулийн этгээдээс нэхэмжлэл, хүсэлт, гомдол гарган мэдүүлсэн эрх зүйн маргааныг шүүх иргэний хэрэг үүсгэн хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад чиглэж байна.

Уг хууль нь 18 бүлэг, 242 зүйлээс бүрдэж байгаа бөгөөд зарим бүлэг дотроо тодорхой чиглэлээр нарийвчлан задалсан хэд хэдэн хэсгүүдээс бүрдэж байна.

Хуучин дагаж мөрдөж байсан «Иргэний байцаан шийтгэх хууль»-д байсан олон зүйлүүд «нийтлэг үндэслэл», «хэргийн оролцогч», «нотлох баримт», «шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамж», «нэхэмжлэл гаргах, түүнийг хүлээн авах», «шүүх хуралдааны бэлтгэл хангах», «шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчид, хуралдааны нийтлэг журам», «анхан шатны шүүх хуралдааны дэг», «шүүхийн шийдвэр, түүнийг гаргах», «гэрлэлт цуцлах тухай хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа», «хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаа», «гомдлоор авч хэлэлцэх хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа», «давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа», «хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа», «шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах», «шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа» гэсэн бүлгүүдэд үндсэн агуулгаараа хэвээр үлдэж, харин «нотариатын байгууллагын үйл ажиллагаанд гомдол гаргах» гэсэн хуучин хуулийн бүлгийг энэ хуульд оруулаагүй хассан болно.

Энэ хуульд олон шинэ заалтууд орсон нь түүний шинэлэг өөрмөц шинжийг тодорхойлж, ач холбогдлыг өндөржүүлж байна. Тухайлбал иргэний шүүн таслах ажиллагааг

мэтгэлцэх зарчмын үндсэн дээр хэрэгжүүлэхээр заалаа. Нэхэмжлэгч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч нь нэхэмжлэлийн шаардлага, маргааны, үйл баримт, хариуцагчийн гэм бурууг нотолж, түүний татгалзлыг үгүйсгэх, хариуцагч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч нь нэхэмжлэгчийн шаардлагыг татгалзах, түүнийхээ үндэслэлийг нотлох үүднээс тэдгээр нь шүүх хуралдаанд, биечлэн оролцох, хүсэлт, тайлбар гаргах, үг хэлэх, нотлох баримт гаргаж өгөх, түүнийг шинжлэн судлахад тэгш эрхтэйгээр оролцох замаар мэтгэлцэх юм. Иймэ заалтыг оруулснаар шүүхийн ардчиллыг шинэ шатанд гаргаж, хэргийн үнэнийг тогтооход оролцогчдын оролцоог хангасан зарчмын чухал алхам боллоо.

Хэргийн оролцогчдын эрх зүйн байдлыг нарийвчлан тодорхойлж өгсний дараа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох оролцоо, түүний эрх, үүргийг нэлээд дэлгэрэнгүй бөгөөд шинэлэг байдлаар зааж өгөхийг тэмдэглэж байна.

Өмгөөлөгч нь шаардлагатай нотлох баримтыг цуглуулах, шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах талаар хүсэлт гаргах, төлөөлүүлэгчийн шаардлага, татгалзал, түүнийг нотлох баримт, үндэслэлийг гаргах, эсрэг талын болон бусад оролцогчдын гаргасан нотлох баримт, шаардлага, татгалзал, тайлбартай танилцах, тэдгээрт тайлбар өгөх, бусад зохигчид, оролцогчдод асуулт тавих, нотлох баримт шинжлэхэд оролцох, нэмэлт нотлох баримт шинжлүүлэх, гэрч байцаалгах, шинжээч томилуулах, шүүх хуралдааныг хойшлуулах болон бусад асуудлаар хүсэлт гаргах, шүүх хуралдааны болон хэрэг хянан шийдвэрлэх бусад ажиллагааны тэмдэглэлтэй танилцах, шүүх бүрэлдэхүүн, оролцогчдыг татгалзан гаргах, шүүхийн шийдвэрийг давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах эрхийг эдэлж, харин гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдийг төлөөлөхдөө төлөөлж буй этгээдийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан сонирхлыг хамгаалах зорилгоор хуульд заасан бүх арга хэмжээ авах ба шаардагдах эрх зүйн туслалцаа үзүүлэх, хэргийн бодит байдлыг тогтооход туслах үүрэг хүлээх болно.

Зарим төрлийн хэргийг шүүгч дангаар шийдвэрлэж байх, анхан шатны журмаар шүүгч дангаар шийдвэрлэхээс бусад хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй шийдвэрлэхээр зохих заалтууд орсон нь урьд байгаагүй шинэ зүйл бөгөөд эдгээр заалтууд орсноор, шүүх шүүгчдээс бүрдэх тухай Үндсэн хуулийн заалтад нийцэж байгаа бөгөөд «Монгол Улсад шүүх

эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ» гэсэн тодорхой заалт жинхэнэ ёсоор хэрэгжих боломж бүрдэж байна.

Энэ хууль хүчин төгөлдөр болсноор, иргэний шүүн таслах ажиллагаанд оролцох иргэдийн төлөөлөгч (хуучин хуулиар «ардын төлөөлөгч»)-ийн үүрэг роль үндсээрээ өөрчлөгдөж байна. Хуучин хуулиар ардын төлөөлөгч нь шүүх бүрэлдэхүүнд орж, мэргэжлийн шүүгчтэй адил бүрэн эрхийг хэрэгжүүлж байсан нь хууль зүйн хувьд зохимжгүй байсан юм. Одоо иргэдийн төлөөлөгч нь олон нийтийн төлөөлөгчийн хувьд шүүх хуралдаанд оролцож, шүүхийн байранд хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, нотлох баримт шинжлэхэд оролцох, зохигчид, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд, гэрч, шинжээчид асуулт тавих, нэмэлт нотлох баримт судлах талаар болон шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах, хүсэлт гаргах, түүнчлэн шүүхийн шийдвэрийг давж заалдах эрх эдэлж, маргааны баримт, зохигчдын гэм буруугийн талаар дүгнэлт гаргах үүрэгтэй бөгөөд дүгнэлтийг бичгээр гаргана. Харин эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас бичгээр гаргах боломжгүй бол энэ тухай хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлж, амаар дүгнэлт гаргаж болно. Иргэдийн төлөөлөгч шаардлагатай гэж үзвэл дүгнэлтээ зөвлөлдөх тасалгаанд гаргах бөгөөд дүгнэлтээ хуралдаанд уншин сонсгож, хэрэгт хавсаргах ёстой.

Хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх шүүх хуралдаанд 3 хүртэл тооны иргэдийн төлөөлөгч оролцуулах ба тухайн хуралдаанд оролцуулах иргэдийн төлөөлөгчийн тоог шүүх хуралдаан даргалагч тогтооно.

Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа өөрчлөгдсөнийг манай нийт иргэд онцгой анхаарах хэрэгтэй. Хуулийн дагаж мөрдөж байсан хуулиар шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор түүнд давж заалдах гомдол, эсэргүүцэл гараагүй бол уг шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсонд тооцож байсан бол энэ хуулиар 30 хоногийн хугацаатай болсон байна. Энэ нь хэргийн оролцогчдын давж заалдах гомдол, эсэргүүцэл бичих боломжийг нэмэгдүүлж байгаа чухал арга хэмжээ гэж ойлговол зохино.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа бол шүүн таслах ажлын эцсийн бөгөөд салшгүй чухал хэсэг мөн. Тэгвэл шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар гүйцэтгэх шийдвэр, гүйцэтгэх бичиг баримт, түүнийг бичих, олгох, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр төлөгч, төлбөр аваг-

ийн эзэмшлэх эрх, төлбөр төлөгчийн эд хөрөнгөнд үзлэг, нэгжлэг хийлийх, эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураах курам,м,, төлбөрт гаргуулж болохгүй эд хөрөнгө, цалин хөлс, бусад орлого, мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулах журам, тодорхойлсон үйл ажиллагаа гүйцэтгүүлэхээр хариуцагчид даалгасан шийдвэрийг биелүүлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн зансаагаас мөнгө олгох, хүүхдийн тэтгэлэгийн мөнгийг олгох, хаяг тодруулах буюу эрэн сурвалжлах ажиллагаа, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг түдгэлзүүлэх, хэрэгсэхгүй болгох, гүйцэтгэсэн шийдвэрийг цуцлах зэрэг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны олон асуудлын талаар энэ хуулийн 116 дугаар бүлэг тодорхой хариулт өгнө.

Хуулийн эцсийн буюу 18 дугаар бүлэгт хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын тухай тодорхой заалт тусгагдсэн. Энд зааснаар, шүүх хуралдааны журам зөрчиж хуралдааан даргалагчаас сануулга авсан этгээд зөрчил дахин гаргасан бол шүүгч түүнд 200—5000 төгрөгөөр торгох, шүүхэд хуурамч бичиг баримт гаргаж өгсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч гэм буруутай этгээдэд 10000—25000 төгрөгөөр торгох шийтгэл тус тус ногдуулахаар тогтоосон байна.

Энэ хуулийг 1994 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Иймхүү Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль батлагдан гарсан нь эрх зүйн шинэчлэл, шүүх болон хуулийн бусад байгууллагуудын үйл ажиллагааг боловсронгуй болгох, тэдгээрийг шинэ байдлаар ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд чухал хувь нэмэр болох нь дамжиггүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц. ШАРАВДОРЖ

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ:

Ерөнхий эрхлэгч **Н. Ринчиндорж**
Нарийн бичгийн дарга **Сан. Жаргалсайхан**
Гишүүд **Т. Баасансүрэн**
**Ч. Бавуу**

Техник редактор **Н. Оюунцэцэг**
Уншиж хянасан **Сан. Жаргалсайхан**
**Б. Янжинлхам**

Үйлдвэрт шилжүүлсэн 1994 оны 8-р сарын 5-нд. Өрөлтөд 1994 оны 8-р сарын 6-нд. Хэвлэлтэнд 1994 оны 9-р сарын 20-нд. Хэвлэлийн хуудас 10,5 Хэвлэсэн тоо 3685 ширхэг.

**Засгийн газрын хэвлэх үйлдвэр**